

ХҮНИЙ ЭРХ сэтгүүл  
2009/1 (27)  
Улсын бүртгэлийн дугаар 244  
Жил 4 удаа хэвлэгдэнэ.  
8 дахь жилдээ

#### Сэтгүүлийн редакцийн зөвлөл

Д.Солонго Ерөнхий редактор /ХЭҮК-ын дарга/  
Ц.Адъяахишиг Нарийн бичгийн дарга /ХЭҮК-ын ахлах референт/

#### Гишүүд:

Ж.Амарсанаа /ШУ-ны академийн жинхэнэ гишүүн Академич,  
Хууль зүйн шинжлэх ухааны доктор,  
профессор, Үндсэн хуулийн цэцийн гишүүн/  
С.Нарангэрэл /ШУ-ны академийн жинхэнэ гишүүн Академич,  
Хууль зүйн шинжлэх ухааны доктор,  
профессор, МУИС-ын ХЗС-ийн захирал/  
Л.Баасан /Хууль зүйн шинжлэх ухааны доктор,  
профессор, ОТИС-ийн дэд захирал/  
Н.Мөнхбат /НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Хүний  
эрхийн шинжээч/  
Л.Мөнхцэцэг /ХЗДХЯ-ны ХЭХҮХ-ийн Ажлын албаны дарга/  
Р.Оюунцэцэг /Хэвлэлийн хүрээлэнгийн сэтгүүл зүйн багш,  
докторант/

## АГУУЛГА

Л.Батдолгор <b>Хүний эрх ба Гүйцэтгэх ажил</b>	<b>3</b>
Д.Баянбилэг <b>Хүний эрх, эрх чөлөө ба хүний хөгжил, хүний аюулгүй байдлын харилцан хамаарал</b>	<b>9</b>
Г.Буяндэлгэр <b>Төр, Шашны харилцаа ба Бурхны шашин</b>	<b>20</b>
Ж.Дашдорж <b>Хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд хууль тогтоомжийг боловсронгүй болгох нь</b>	<b>25</b>
Ч.Отгончулуун <b>Амьд явах эрх ба цаазаар авах ял</b>	<b>41</b>
Б.Уранцэцэг <b>Хүн худалдаалах гэмт хэргийн талаархи нийгмийн ойлголт, хандлага</b>	<b>46</b>
Д.Солонго <b>Хүүхэд хөдөлмөрлөх ёстой юу?</b>	<b>57</b>
Ц.Цогт <b>Шүүх - Хүний эрхийн баталгаа</b>	<b>64</b>
У.Эрдэнэтуяа <b>Шүүх, прокурор, өмгөөллийн байгууллагын хараат бус, шударга байдал</b>	<b>71</b>
<b>Таны танин мэдэхүйд</b> Гэмт хэрэг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 35 арга зам	<b>77</b>
Хүний эрхийн нэр томъёоны тайлбар	<b>83</b>

ХҮНИЙ ЭРХ БА ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ



**Л.Батдолгор ТЕГДС-ийн Судалгаа- эрдэм шинжилгээний төвийн ахлах судлаач, докторант**

Эрх зүйн үүднээс авч үзвэл хүн бол эрх зүйн харилцааны субъектын бие даасан төрөл болдог. Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуулийн заалт, эрх зүйн онолын зарчмуудын агуулгаас үзвэл хүний эрх гэж өөрийнх нь төрөлх жам ёсны хэрэгцээнээс үүдэлтэй, мөн чанарын хувьд төрөөс тогтоосон биш хүлээн зөвшөөрсөн бөгөөд эрх зүйн хэм, хэмжээгээр бэхжигдэн хамгаалагдсан ямар ч тохиолдолд хөндлөнгийн хэн ч дур мэдэн хөндөж, хязгаарлаж болохгүй хэд, хэдэн туйлын эрхийн тухай цогц ойлголт мөн билээ. Үүнийг Монгол Улсын 1992 оны шинэ Үндсэн хуульд баталгаажуулсан. Миний бичиж буй сэдвийн хувьд ялангуяа Гүйцэтгэх ажлын байгууллагуудын үйл ажиллагаанд Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-д хуульчилсан **иргэний хувийн ба гэр бүл, захидал, харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална** гэсэн заалт ихээхэн хамааралтай.

Өнөө үед Үндэсний аюулгүй байдалд аюул учруулах гэмт хэргүүдийг сайтар төлөвлөж, нарийн зохион байгуулалттай үйлдэж, түүнийг үйлдэх арга, хэрэгсэл улам боловсронгуй болж байгаа нөхцөл байдал, гэмт этгээдүүд тагнуулын албадад ч ашиглагддаг аргуудыг ч хэрэглэдэг болсон нь гэмт үйлдлийг илээр мөрдөн шалгах уламжлалт аргуудаар илрүүлж, илчилж үр дүнд хүрэхэд нэн түвэгтэй болж Үндсэн Хуулиар олгогдсон, олон улсын гэрээ конвенциар хүлээн зөвшөөрөгдсөн хүний зарим халдашгүй эрхэд аргагүй эрхэнд халдаж, хязгаарлах шаардлагыг хууль хамгаалах байгууллагуудад тулган хүлээлгэж байна. Өөрөөр хэлбэл хууль хамгаалах байгууллагууд хэрэг илрүүлэх хуучин арга барилаа нэн даруй

өөрчилж, тусгай арга, хэрэгслүүдийг хэрэглэхээс аргагүй байдалд хүрч байна.

Гүйцэтгэх ажлын байгууллагууд нь хуульд заасан тохиолдолд л хүний эрх, эрх чөлөөнд халдаж, хязгаарлах үүрэг хуулиар хүлээх боловч хүний эрхэд халдаж хязгаарлах үндэслэл нь тов тодорхой байх ёстой.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа гүйцэтгэх ажлын тухай хуулийн заалтуудаас үзэхэд Гүйцэтгэх ажил явуулах эрхтэй бүх байгууллага (Тагнуулын ерөнхий газрын сөрөх тагнуулын алба, гадаад тагнуулын алба, Батлан хамгаалах яамны цэргийн тагнуулын алба, Хил хамгаалах ерөнхий газрын хилийн тагнуулын алба, Цагдаагийн ерөнхий газрын эрүүгийн цагдаагийн алба, Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын гүйцэтгэх алба, Авилгатай тэмцэх газрын гүйцэтгэх алба ) Үндсэн хуулиар хамгаалагдсан, мөн олон улсын Монгол Улсын нэгдэн орсон гэрээ конвенцоор хамгаалагдсан хүний халдашгүй эрхүүдэд, тухайлбал хүний захидал харилцааг хянах, орон байранд үзлэг нэгжлэг хийх үйл ажиллагааг явуулах эрх нь хуулиар нээлттэй байгаа юм. Гэмт хэргийг илрүүлэх зорилгоор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахын зэрэгцээ гүйцэтгэх ажлын тусгай арга хэрэгслийг бүхий л гэмт хэргийг илрүүлэхийн тулд ашиглах юм шиг ойлголт байдаг. Олон улсын жишигээс үзэхэд зөвхөн зарим нэг хүнд, онц хүнд гэмт хэргийг илрүүлэхэд л дурьдсан тусгай арга хэрэгслийг ашиглана гэж заасан байна. Эдгээр нь Хүний Үндсэн хуулиар болон Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн конвенцуудад заасан хүний эрхүүдэд гүйцэтгэх албадын зүгээс дураар халдахгүй байхыг хязгаарласан заалтууд юм. Түүнээс гадна гүйцэтгэх ажил явуулдаг бүх байгууллага хүний эрхэд халдаж хязгаарлах эрх эдэлдэггүй олон улсын жишиг байдаг тухайлбал ОХУ-ын тагнуул, гүйцэтгэх ажлын 10 гаруй байгууллагын зөвхөн гурав нь л хуулиар тусгай арга хэрэгсэл ашиглах эрх эдэлж бусад дээрх байгууллагууддаа шаардлагатай үед захиалга өгч үйлчлүүлдэг байна. Энэ нь бас л тусгай албадын зүгээс хүний эрхэд халдаж хязгаарлах ажиллагааг цэгцэлсэн хуулийн заалт юм.

Хүний Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхэд халдаж хязгаарлах асуудалд нухацтай хандсан олон улсын бас нэг жишиг бол манай тусгай албадын тухай хуульд одоогоор заагаагүй байгаа тусгай арга хэрэгсэл ашиглах зөвшөөрлийг ямар байгууллагын, хэн гэдэг албан тушаалтан тушаал өгөхийг хуульчилах асуудал юм.

Хүний эрхийг хязгаарлах асуудлыг баталгаатай байлгах үйл ажиллагаанд Шүүх, прокурорын байгууллага тодорхой үүрэг хүлээдэг. Тухайлбал: Монгол Улсын ЭБШХ-д “Иргэний орон байр халдашгүй байна” (11-р зүйлд), “Энэ хуульд заасан үндэслэл журмаас гадуур хэн ч иргэний орон байранд оршин суугчийн зөвшөөрөлгүй нэвтрэн орох эрхгүй”(11.22-д), “Орон байранд хийх нэгжлэгийг прокурорын зөвшөөрлөөр энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэнэ (11.3-д); “Иргэний хувийн болон гэр бүл захидал харилцааны нууцыг хуулиар хамгаалах ба энэхүү эрхийг зөвхөн прокурорын зөвшөөрлөөр хуульд заасан үндэслэл журмын дагуу хязгаарлаж болно” (92.1-д), “Эрүүгийн хэргийн талаар хуульд заасан үндэслэл, нөхцөл журмын дагуу прокурорын зөвшөөрлөөр явуулсан гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан баримт сэлтийг нотлох баримтын хэмжээнд үнэлж болох ба ингэхдээ нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх үйл ажиллагааны эх сурвалжийг нууцлана” (79.3-д)”, гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох зорилгоор хийгдэж байгаа гүйцэтгэх ажилд хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд прокурор хяналт тавина (193.1.5-д)”, Прокурорын байгууллагын тухай хуульд “Улсын Ерөнхий прокурор, түүний тусгайлан эрх олгосон прокурор Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасны дагуу гүйцэтгэх ажилд хяналт тавина” (13-р зүйлд), “Гүйцэтгэх ажлын тухай хуульд “Гүйцэтгэх ажлын байгууллага хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд утсан харилцааг хянах, шуудан харилцааг хянах, орон байр, барилга байгууламж, газар, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, эд зүйлд нууц үзлэг хийх, нууцаар ажиглалт явуулах, нууцаар харах, сонсох техник хэрэгсэл ашиглахад Монгол Улсын Ерөнхий Прокурор , түүний тусгайлан эрх олгосон прокурор бичгээр урьдчилан зөвшөөрөл өгч хяналт тавина “(23-р зүйлд )гэсэн заалтууд бол хуулиар Прокурорын байгууллагаас тагнах үйл ажиллагаанд хяналт тавих ажлын эрх зүйн үндэс, хүний эрхийн бас нэг баталгаа юм. Прокурорын байгууллага зөрчигдсөн эрхийг сэргээх, хууль ёсны баталгааг нь хангах арга хэмжээг авах ёстой. Энэ талаар Гүйцэтгэх ажлын тухай хуульд (7.1-д) “гүйцэтгэх ажлын байгууллага, түүний ажилтан хуулиар олгосон эрхээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж хууль бусаар иргэн хуулийн этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироосон бол прокурор зөрчигдсөн эрхийг сэргээж, учирсан хохирлыг арилгах арга хэмжээг...хууль тогтоомжид заасны дагуу авна” гэсэн байна.

Олон улсын тагнах үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зарим баримт бичгээс үзэхэд ялангуяа Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрхийг хязгаарлах үйл ажиллагаанд ихэнх тохиолдолд шүүх зөвшөөрөл өгдөг байна. Ингэснээр тагнуулын арга, хүч, хэрэгслээр мэдээ олох, үр дүнг нь нотлох баримтын хэмжээнд үнэлж мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанд ашиглах эрх зүйн зохицуулалт боловсронгуй болж, мөн иргэн, хуулийн этгээдийн эрхийг хууль бусаар зөрчихгүй байх асуудал улам баталгаатай болдог байна.

Монгол Улсын Гүйцэтгэх ажлын тухай хуульд ч шүүхтэй холбоотой олон заалт бий. Жишээ нь: Гүйцэтгэх ажлын тухай хуульд (9.1.3-д) "...шүүгдэгч ялтан болон...шүүхээс даалгасан бусад хүнийг эрэн сурвалжлах; (11.2.3-д) эрүүгийн хэргийн нотолгоог бүрэн гүйцэд шалгах зорилгоор шүүх...даалгавар ирүүлэх эрхтэй, Тагнуулын байгууллагын (11.3-д) ба хилийн тагнуулын албаны эрэн сурвалжлах ажиллагаанд ч (11.6-д) шүүхийн даалгавраар эрэн сурвалжлах ажиллагаа явуулна", "гүйцэтгэх байгууллага, түүний ажилтан хуулиар олгосон эрх хэмжээгээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж хууль бусаар иргэн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөө хууль ёсны ашиг сонирхлыг хохироосон бол...шүүх зөрчигдсэн эрхийг нь сэргээж, учирсан хохирлыг арилгах арга хэмжээг...хууль тогтоомжид заасны дагуу авна" (7.2-д), (11.3.3-д) "эрүүгийн хэргийн нотолгоог бүрэн гүйцэд шалгах зорилгоор шүүхээс ирүүлсэн даалгавар нь гүйцэтгэх ажил явуулах үндэслэл болно", (12.1.6-д) "...хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн нотлох баримтын эх сурвалжийг олж тогтоох,"...шүүхээр...шалгагдаж байгаад оргосон этгээд нуугдаж байна гэж үзэх үндэслэл байвал...иргэдийн орон байр орон сууцанд нэвтрэх бүрэн эрхтэй "(13.2.3-д) гэж тус тус заасан нь тагнуулын байгууллагын зүгээс Үндсэн хуулиар хамгаалагдсан иргэний эрхийг, хязгаарлах ажиллагаанд шүүгч зөвшөөрөл өгөх, шүүх оролцох үүрэгтэйг нотлож байгаа юм.

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн шүүхтэй холбоотой эдгээр заалтыг шүүхийн оролцоогүй шийдвэрлэх боломжгүй. Ялангуяа хүний Үндсэн хуулиар болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ конвенцоор хамгаалагдсан эрхийг хязгаарладаг тагнах арга хэмжээ зохион байгуулахдаа тагнуулын байгууллага гол төлөв шүүхээс зөвшөөрөл авдаг эрх зүйн зохицуулалтыг олон улсын жишгээр гүйцэтгэх ажлын

байгууллагын тухай хуульд суулгаж өгөх нь хүний эрх, эрх чөлөөг дээрдүүлэх ургаш ахисан алхам болно.

Гүйцэтгэх ажлын байгууллагын ажиллах боломжийг боогдуулахгүй харин хяналт тавих төрийн механизмыг хуулиар зөв тодорхойлж, гүйцэтгэх байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгосноор гүйцэтгэх арга, хүч, хэрэгслээр мэдээлэл олох ба үр дүнг нотлох баримтын хэмжээнд үнэлж мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанд ашиглах эрх зүйн зохицуулалт улам боловсронгуй болж, иргэн ба хуулийн этгээдийн эрхийг хууль бусаар зөрчихгүй байх асуудал баталгаатай болно.

2003 онд Монгол УИХ-ын 41–р тогтоолоор батлагдсан “Монгол Улсад хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр”-ийн *хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хангах талаарх* (2.1.2.2-д) “Хүний биед халдах, түүний дотор баривчлах, үзлэг, нэгжлэг хийх, орон байранд нэвтрэх эрхийг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, байгууллага, албан тушаалтны зөвшөөрлөөр хэрэгжүүлдэг практикийг халж, зөвхөн шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтанд олгох чиглэл баримтлана” гэсэн заалт, *хүний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц ...ын халдашгүй байх эрхийн талаарх* (2.1.3.1-д) “Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг тагнах, чагнах зориулалтын хэрэгсэл, тагнах төхөөрөмж гадаадаас оруулах, худалдах, эзэмших, ашиглахыг хуулиар хориглож, түүнийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо бий болгоно” гэсэн заалт, (2.1.3.2-д) “Тагнах, чагнах хэрэгсэл, тоног төхөөрөмжийг зөвхөн гүйцэтгэх ажил эрхэлдэг төрийн байгууллагуудын захиалгаар тагнуулын байгууллага гадаадаас оруулж ирэх, улсын хэмжээнд ашиглагдаж байгаа тийм хэрэгслийн нэгдсэн тоо бүртгэл, хяналтын журам тогтооно” гэсэн заалт, (2.1.3.3-д) “Иргэдэд захидал харилцаа, мэдээллээр үйлчилдэг цахилгаан болон шуудан холбоо, үүрэн телефон, интернетийн үйлчилгээний байгууллагуудын иргэний хувийн болон захидал харилцааны нууцыг хамгаалах талаар стандарт тогтоож мөрдүүлэх, төрийн хяналтын систем тогтоох, эрх бүхий байгууллагын шийдвэрээр иргэний хувийн нууцтай танилцсан, чагнасан, тохиолдол бүрийг бүртгэх журам, тогтолцоог бий болгоно” гэсэн заалт, (2.1.3.4-д) “Иргэний хувийн болон захидал харилцаа...ны нууцыг задруулсан тохиолдолд эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхийн зэрэгцээ хохирогчид нөхөн төлбөр олгох эрх зүйн нөхцөл бүрдүүлэх, хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял эдэлсэн хүмүүст эд

хөрөнгийн хохирлыг нөхөн төлөхийн зэрэгцээгээр хилсээр хоригдсон хоног тутамд ногдох сэтгэл санааны төлбөрийн хэмжээг тогтоож мөрдүүлнэ” гэсэн заалтууд<sup>1</sup> цөм зөвхөн шаардлагатай тохиолдолд хүний эрх, эрх чөлөөнд халдаж, хязгаарлах ажиллагааг эмхлэн цэгцэлж журам тогтооход чиглэгдсэн байна. 2006 онд ТЕГ-ын даргын 439-р тушаалаар<sup>2</sup> “Монгол улсад хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийн ТЕГ дахь салбар хорооны дүрэм”. ТЕГ-ын даргын тушаалын

Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн ТЕГ дахь салбар хорооны дүрмийг баталж, хүний эрхийн салбар хороог байгуулсан байна. Уг дүрэмд зааснаар бол хүний эрхийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг энэ хороо ТЕГ-ийн хэмжээнд зохион байгуулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, Үндэсний хөтөлбөрийн хороо, түүний ажлын албанаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх үүрэг хүлээж салбар хорооны дарга нь ТЕГ-ын дарга байхаар заасан нь хүний эрхийг хамгаалах талаар ургаш ахисан арга хэмжээ болжээ.

ТЕГДС-ийн багш Х.Эрдэнэбат “Хүний халдашгүй эрх” номонд “Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Гүйцэтгэх ажлын тухай ба ЭБШХ-иар эрүүгийн хэрэгт нууцаар хийгдэх эрэн сурвалжлах тодорхой журмыг тогтоогоогүй байгаа учраас тэдгээрийн агуулыг нь шууд тодорхойлох бололцоогүй болгож байна. *Иймд ЭБШ эрх зүйн онолын үүднээс хүний халдашгүй эрхийг, хуульчлан тогтоогоод байгаа эрэн сурвалжлах ажиллагааны явцад хамгийн түгээмэл байдлаар зөрчиж, улмаар хүний эрх, эрх чөлөө үгүйсгэгдэх магадлалтай гэж дүгнэж болно*”<sup>3</sup> гэсэн нь анхаарууштай асуудал мөн. ТЕГ-ын Судалгаа-эрдэм шинжилгээний Төвийн зарим судлаач тагнах үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөний асуудал ямар нэг байдлаар гарцаагүй хөндөгддөг тухай “Хүний эрх ба тагнуулын үйл ажиллагаа” гэсэн судалгааны өгүүлэлийг “Хүний эрх” сэтгүүлд бичсэн нь<sup>4</sup> хүний эрх ба тагнах үйл ажиллагааны тэнцвэрт байдлын талаар ойлгоц өгөх ач холбогдолтой юм.

<sup>1</sup> Монгол улсад хүний эрхийг хангах хөтөлбөр, УБ. 2003. хуудас 17-18

<sup>2</sup> Монгол улсад хүний эрхийг хангах хөтөлбөрийн ТЕГ дахь салбар хорооны дүрэм, ТЕГ-ын даргын тушаалын эмхтгэл, УБ. хуудас 157-166

<sup>3</sup> Х.Эрдэнэбат. Хүний халдашгүй эрх. УБ. 2002. Хуудас 74.

<sup>4</sup> Л.Батдолгор. Хүний эрх ба тагнуулын үйл ажиллагаа. “Хүний эрх” сэтгүүл. №2. 2008. Хуудас 33-41.



## ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ БА ХҮНИЙ ХӨГЖИЛ, ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАРИЛЦАН ХАМААРАЛ



Д.Баянбилэг Хуульч

I. Америкийн Нэгдсэн Улсын 32 дахь Ерөнхийлөгч асан Франклин Делано Рузвельт / 1882-1945/ 1941 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр “Бид аюулгүй, бат бэх байдлыг тогтоохоор хичээн зүтгэхдээ юуны өмнө дэлхий дахинд дөрвөн гол эрх чөлөөний суурийг тавьсан байх ёстой. Энэ нь 1 дүгээрт үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх..., 2 дугаарт бишрэн шүтэх, итгэл үнэмшилтэй байх..., 3 дугаарт гачигдах зовлонгоос ангид байх..., 4 дүгээрт айх аюулгүй байх... эрх чөлөө дэлхийн газар сайгүй хангагдсан байх ёстой...” хэмээн Конгресст хандаж түүхт үгээ хэлсэн<sup>1</sup> нь Нэгдсэн Үндэстний Байгууллагыг<sup>2</sup> бий болгох, хүний эрх, эрх чөлөөг дэмжин дэлгэрүүлэх үйлсэд онцгой ач холбогдол өгсөн юм.

Энэхүү түүхт үг Хүний эрхийн түгээмэл тунхаглал /1948 он/-ын удирдтгал хэсэгт “хүн ардын эрхэм дээд эрмэлзэл”, түүнчлэн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт /1966 он/, Нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн тухай олон улсын Пакт<sup>3</sup> /1966 он/-ын оршил хэсэгт

<sup>1</sup> <http://www.youtube.com/watch?v=5iHKtrijY>; <http://www.wnorton.com/college/history/ralph/work-book/ralprs36b.htm>; Х.Виктор Кондэ “Хүний эрхийн нэр томъёоны гарын авлага” /орчуулагч Ж.Амарсанаа, Н.Цогт/2002 он, 56 тал.

<sup>2</sup> Дэлхийн II дайнаас хойш олон улс орон тусгаар тогтнолоо сэргээн тогтоож, түүнчлэн тусгаар тогтносон шинэ улс байгуулах хөдөлгөөн өрнөж, улмаар биеллээ олж, тэдгээр улс НҮБ-ын гишүүн улс болж байлаа. Тухайлбал, Анх 1945 онд 51 улс НҮБ-ын гишүүн улс болж байсан бол үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн өрнөсөн үед буюу 1966 он гэхэд 122 улс, мөн “хүйтэн дайн” төгсөж ЗХУ задарч, Югославт иргэний дайн дууссаны дараагаар 1993 он гэхэд нийт 184 улс аль хэдийнээ НҮБ-ын гишүүн улс болсон байлаа. 2009 оны 6 дугаар сарын байдлаар НҮБ-ын 192 гишүүн улс байна. Эдгээрээс Африкийн бүсчлэлд 47, Ази-Номхон далайн бүсчлэлд 39, Европ, Хойд Америк, Төв Азийн бүсчлэлд 55, Латин Америк, Карибын тэнгисийн бүсчлэлд 33, Ойрхи Дорнод, Хойд Африкийн бүсчлэлд 18 гишүүн улс тус тус багтаж байна.

<sup>3</sup> НҮБ-ын олон улсын гэрээ болох Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад 163 улс, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт 160 улс 2009 оны 6 дугаар сарын байдлаар нэгдэн ороод байна. <http://www.un.org/en/members/index.shtml>

“бие хүний эрхэм зорилго” болж тусгагдан, түүний агуулга, мөн чанар хүний эрхийн олон улсын болон бүс нутгийн байгууллагын эрх зүйн баримт бичигт, улс орон бүрийн Үндсэн хууль, хууль тогтоомжид илрэлээ олсоор байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллага /НҮБ/-ын Дүрэм /1945 он/-д түүний зорилгыг “...Улс үндэстнүүдийн хооронд улс түмний тэгш эрх, өөрөө засан тохинох зарчмыг хүндэтгэсэн найрсаг харилцааг хөгжүүлэх, ...хүмүүнлэгийн шинжтэй олон улсын асуудлыг шийдвэрлэх, ...хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх явдлыг хөхиүлэн дэмжиж дэлгэрүүлэх талаар олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх...” гэж тодорхойлсон бөгөөд нөгөө талаар эдгээрийг НҮБ-ын олон улсын эдийн засаг, нийгмийн хамтын ажиллагааны үүрэг хэмээн тогтоосон байдаг.<sup>4</sup>

II. Хүний эрх, эрх чөлөөний талаархи янз бүрийн тодорхойлолтыг тухайлбал, “Хүн бол бүх эдийн хэмжүүр” хэмээсэн Эртний грекийн философич, гүн ухаантан Протагор /МЭӨ 490-420/-ын үеэс өнөөг хүртэл гадаадын болон дотоодын олон эрдэмтэн, судлаачийн хүний эрхийн талаархи бүтээлд олонтаа томъёолсон байдаг.

Энэ удаад түүнийг манай зарим эрдэмтэн хэрхэн тодорхойлсныг үзье.

**Хүний эрх** гэдэг нь төрөлхөөс заяасан бөгөөд хамгийн эгэл утгаараа хүнд өөрт нь байдаг, нийгмийн дотор заавал эдлэх боломж мөн. **Эрх чөлөө** гэдэг нь хүний заавал эдлэх ёстой бөгөөд ямар нэгэн хязгаар тавьж үл болох боломжийг хэлнэ. Үүгээрээ эрх чөлөө нь хүний салшгүй эрх болж илэрдэг байна.<sup>5</sup>

**Хүний эрх** нь хувь хүн, нийгэм, төр хоорондын харилцааны эрх зүйн хэм хэмжээний хэлбэр мөн. ...**Үндсэн эрх, эрх чөлөө** нь хувь хүний эрх зүйн байдлын гол суурь болж өгдөг ба тэдгээр нь хүний амьдралын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах бусад олон эрхийг бий болгох боломжийг олгодог.<sup>6</sup>

<sup>4</sup> Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн IX бүлэг, 55-60 дугаар зүйл.

<sup>5</sup> Б.Чимид, “Үндсэн хуулийн тухай мэдлэг”, УБ., 2006 он.

<sup>6</sup> Ж.Амарсанаа, “Хүний эрхийн тухайд” илтгэл, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 50 жилийн ойд зориулсан олон улсын бага хуралд тавьсан илтгэл, УБ., 1997 он, 15, 17 дахь тал.

Олон улсын эрх зүйн баримт бичгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө нь дор дурдсанаар ангилагдаж байна. Үүнд:

1. **Хамрах хүрээ, салбараар** нь хувийн, улс төрийн, эдийн засаг, нийгэм, соёлын;

2. **Нийгмийн харилцаанд оролцох субъект болон тоогоор** нь бие хүний, бүлгийн, хамтын /энэ нь зөвхөн тухай улсын дотроо/;

3. **Мөн чанараар** нь жам ёсны болон үүсмэл;

4. **Хууль зүйн баталгааны хүрээгээр** нь хууль тогтоомжид заасан үндэслэлээр хязгаарлаж болох, ямар ч тохиолдолд хязгаарлаж болохгүй;

5. Ард түмэн өөрөө засан тогтнох, хүүхэд, эмэгтэйчүүд, хөдөлмөрлөх, эвлэлдэн нэгдэх, тахир дутуу иргэд, цагаачлагч, дүрвэгсэд, геноцидын эсрэг, ялгаварлан гадуурхахын эсрэг, хүмүүнлэгийн гэх мэтээр 21 бүлэгт ангилагдсан 100 гаруй **олон улсын эрх зүйн баримт бичгийн зорилго, зорилтоор**;

6. Даяарчлагдаж буй дэлхий ертөнцийн өнөөгийн ерөнхий төлөв, **агуулгын хувьд** тэдгээрийг багцлаад олон улсын хэмжээнд ерөнхийдөө дараахь байдлаар авч үзэх хандлага гарч байна:

1/ хувь хүний шууд эдлэх, угаасаа заяагдсан, салшгүй эрх; Энэ эрх бол иргэний ба улс төрийн зарим эрх юм.

2/ төрөөс тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг шаарддаг эрх буюу эдийн засаг, нийгэм, соёлын эрх; Энэ эрх бол улс бүрийн санхүү, эдийн засгийн нөөц, чадавхийн хүрээнд арга хэмжээ авахыг шаарддаг эрх юм.

3/ Хамтын эрх. Энэ эрх нь дан ганц улсаас хальсан өөрөөр хэлбэл олон улсын хүчин чармайлтын хүрээнд хэрэгжих эрх /дайн, терроризм, цөмийн зэвсгийн аюулаас ангид байх, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, арилгахтай холбогдсон гэх мэт/ юм.

Хүний эрх, эрх чөлөөг төрөөс дээдлэх, хамгаалах, хангах, хөхиүлэн дэмжих асуудлын хувьд хөгжлийн янз бүрийн түвшинд байгаа тухайлбал, өндөр хөгжилтэй, хөгжиж байгаа, ядуу буурай улс орнуудын хандлагад ялгаа ажиглагддаг. Өндөр хөгжилтэй улс орнууд улс төрийн болон хувь хүний эрхийг, ядуу буурай улс орнууд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг дээгүүр тавьж байхад, харин хөгжиж байгаа улс орнууд аль алийг нь анхаарах чиг баримталж байна. Энэ ялгаа нь 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглалд дурдагдсан хүний эрхүүд нь капиталист, социалист нийгмийн тогтолцооны бүлэг улсуудын ашиг сонирхол, үзэл бодлын

зөрөлдөөнөөс улбаалан 1966 онд 2 тусдаа олон улсын гэрээ /Пакт/ болж батлагдахад ч нөлөөлсөн байдаг.

3. Хүний эрх, эрх чөлөөтэй холбогдож, тэдгээрийг тодотгож байгаа “хүний хөгжил”, “хүний аюулгүй байдал” гэсэн хоёр үндсэн ойлголтын талаар товч өгүүлье.

### 3.1. Хүний хөгжил гэж юу вэ?

**Тодорхойлолт:** Хүний хөгжил бол аливаа хүн эдийн засгийн, нийгмийн, улс төрийн, соёлын сонголтоо чөлөөтэй хийх боломжийг өргөжүүлэх үйл явц, нөгөө талаар үр дүн юм<sup>7</sup>.

**Хүний хөгжил** нь хүний өөрийнх нь дотоод нөөцийг хөгжүүлэх замаар чадавхийг нь сайжруулах, ингэснээр түүний амьдралд ач холбогдолтой, үр дүнтэйгээр тусгалаа олох явдал бөгөөд хүний нийгмийн харилцаанд оролцох олон талт идэвхтэй үйл ажиллагааны цогц юм. (зохиогч Д.Б.)

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд ...”Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна...” гэж тунхагласан. Хүмүүс төрөх мөчдөө тэгш эрхтэй байдаг, тэдний цаашид нийгэмд эзлэх байр суурь, эрх тодорхой хэрэгжих нь өөрсдийнх нь зарцуулсан хөдөлмөр, чадавхиас хамаардаг.<sup>8</sup>

Улс орны хөгжлийн “толь” бол хүний хөгжил билээ. Монгол ардын зүйр цэцэн үгст “Иргэн баян бол улс баян” гэдэг мэргэн санаа /зүйр цэцэн үг/ байдаг нь үүний илэрхийлэл болов уу.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр /НҮБХХ/-өөс дэлхийн эдийн засаг, нийгмийн өөрчлөлтөд дүгнэлт хийж, улс орон бүрийг хүний хөгжлийн нэгдсэн хэмжүүр буюу хүний хөгжлийн индексээр нь байр эзлүүлэн, “Дэлхийн хүний хөгжлийн илтгэл”-ийг 1990 оноос эхлэн жил бүр гаргах болсон бөгөөд өнгөрсөн хугацаанд нийт 18 удаа “бичигджээ”. Жил бүр өөр өөр сэдвээр, тухайн сэдэвтэй холбогдсон асуудлуудыг түлхүү

<sup>7</sup> НҮБХХ “Хүний хөгжлийн илтгэл: Хүний хөгжлийн үзэл баримтлал ба хэмжүүр”, Нью Йорк, 1990 он.

<sup>8</sup> Ж.Амарсанаа, “Хүний эрх (Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал)”, УБ., 2000 он, 69 дэх тал.

хөндөж, дүн шинжилгээ хийж, үнэлэлт өгсөн илтгэлүүдийн анхных нь “Хүний хөгжлийн үзэл баримтлал ба хэмжүүр” нэртэйгээр гарсан ба “Ард түмэн бол аливаа үндэстний жинхэнэ баялаг мөн. Тийм ч учраас хөгжлийн зорилго нь хүн ардаа урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах таатай орчинг бүрдүүлэхэд оршино.” хэмээн эхэлдэг.

Хүний хөгжлийн индекс /ХХИ/-ийг иргэдийн наслалтын хэмжээ, боловсролын түвшин буюу насанд хүрэгсдийн бичиг үсэг тайлагдалт ба анхан, дунд, дээд шатны сургуульд хамрагдалт, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ буюу амьжиргааны түвшин гэсэн үндсэн 3 суурь үзүүлэлтээр тодорхойлдог. Хэдийгээр ХХИ нь хүний хөгжлийн суурь, дундаж хэмжигдэхүүн боловч түүнийг бүрэн төгс тодорхойлдоггүй юм.

Дэлхийн улс орнуудыг Африкийн улсуудын, Арабын улсуудын, Европ болон Европын холбооны улсуудын, Ази, Номхон далайн улсуудын, Латин Америк, Карибын тэнгисийн гэж газар зүйн байршлаар нь бүлэглэж, эдгээр 5 бүс нутгийн илтгэлийг 34 удаа эрхлэн бэлтгэж гаргасан байна.

Дэлхийн улсуудаас анхлан Бангладеш, Камерун, Пакистан, Филиппин улс 1992 онд НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр үндэсний хүний хөгжлийн илтгэлээ бэлтгэн гаргаж байсан бол 2001 он гэхэд 120 гаруй улс 260 гаруй үндэсний хүний хөгжлийн илтгэлийг, харин 2009 оны 5 дугаар сарын байдлаар 146 улс нийтдээ 629 ийм илтгэлийг боловсруулан гаргасан байна.

Монгол Улсын Засгийн газар “Монголын хүний хөгжлийн илтгэл”-ээ 1997 онд НҮБХХ-тэй хамтран анх удаа, түүнээс хойш 2000, 2003, 2007 онд гээд нийтдээ 4 удаа гаргаад байна. Манай улсын хүний хөгжлийн анхны илтгэл шилжилтийн үеийн Монгол Улсын иргэдийн амьжиргаа, аж байдлын түвшинд үнэлгээ өгсөн, хоёр дахь илтгэл нь Монгол Улсад төрийн үүрэг ямар байх ёстой, яаж ажиллах вэ? гэдэгт анхаарал хандуулсан, гурав дахь илтгэлд хот, хөдөөгийн ялгаатай байдалт үнэлэлт өгсөн байдаг. Харин 2007 онд гаргасан дөрөв дэх илтгэл нь хөдөлмөр эрхлэлт ба ядуурлын асуудлыг хөндсөн байна.

Түүнчлэн Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, НҮБХХ, Шведийн олон улсын хөгжлийн агентлаг, Удирдлагын академи, Монгол Улсын Их сургууль хамтран хүний хөгжлийн суурь мэдлэг, Монгол Улс дахь хүний хөгжлийн байдал, ирээдүйн чадавхи, боломж, төрийн бодлогын талаар өгүүлсэн “Хүний хөгжил” нэртэй сурах бичгийг 2006, 2007 онд эрхлэн гаргажээ.

Дэлхийн хэмжээнд 1990-2008 оны хооронд жил бүр Монгол Улс хэдэн улсаас хүний хөгжлийн индексээрээ хэддүгээр байрт орж байгааг дараахь хүснэгтээр харьцуулан үзүүлж байна.

№	Дэлхийн хүний хөгжлийн илтгэл <sup>9</sup>			
	Он	Илтгэлд хамрагдсан улсын тоо	Монгол Улсын эрэмбэлэгдсэн байр	Илтгэлийн сэдэв
1.	1990	130	61	“Хүний хөгжлийн үзэл баримтлал ба хэмжүүр”
2.	1991	160	87	“Хүний хөгжлийг санхүүжүүлэх нь”
3.	1992	160	88	“Нийтлэг чиг хандлага ба хүний хөгжил”
4.	1993	173	100	“Ард түмний оролцоо”
5.	1994	173	102	“Хүний аюулгүй байдлын шинэ чиг хандлага”
6.	1995	174	110	“Жендер ба хүний хөгжил”
7.	1996	174	113	“Эдийн засгийн өсөлт ба хүний хөгжил”
8.	1997	175	101	“Ядуурлыг арилгахын төлөө хүний хөгжил”
9.	1998	174	101	“Хүний хөгжлийн хэрэглээ”
10.	1999	174	119	“Хүний төлөв байдлын даяарчлал ”
11.	2000	174	117	“Хүний эрх ба хүний хөгжил”
12.	2001	162	116	“Хүний хөгжилд зориулагдсан шинэ технологийн бүтээл бүтээх нь”
13.	2002	177	114	“Задарж буй дэлхийд ардчиллыг гүнзгийрүүлэх нь”
14.	2003	175	117	“Мянганы хөгжлийн зорилт: Хүн төрөлхтөний ядуурлыг эцэс болгохын тулд улс үндэстнүүд хоорондоо ойртон нягтрах нь”
15.	2004	177	117	“Өнөөгийн олон талт дэлхий ертөнцийн соёлын эрх чөлөө”
16.	2005	177	114	“Олон улсын хамтын ажиллагааны уулзвар: Тэнцвэргүй дэлхий дэх тусламж, худалдаа, аюулгүй байдал”
17.	2006	177	116	“Хэт хомсдол: Эрх мэдэл, ядуурал ба усны гачаалын даяарчлал”
18. <sup>10</sup>	2007	177	114	“Цаг уурын өөрчлөлттэй тэмцэх нь: Хуваагдаж буй дэлхий дэх хүн төрөлхтөний эв санааны нэгдэл”

<sup>9</sup> <http://www.hdr.undp.org/statistics>

<sup>10</sup> Дэлхийн хүний хөгжлийн илтгэлийн 2007, 2008 оныхыг нэгтгэн 2008 онд гаргасан бөгөөд харин улс орнуудын хүний хөгжлийн индексийг нь дурдсан онуудад тус бүрт нь гаргасан байна.

Дэлхийн улс орнуудыг (2008 оны байдлаар) хүний хөгжлийн индекс тогтоосон түвшингөөр нь дээд /1-75 дугаарт/, дундаж /75-153 дугаарт/, доод /154-аас хойш/ гэж 3 ангилан эрэмбэлж байгаа бөгөөд манай Монгол Улсын хувьд дундаж түвшний ангилалд орж байна.

Монгол Улс ХХИ-ээрээ нэлээд хойгуур эрэмбэлэгдсэн шалтгаан нь нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн, иргэдийн дундаж наслалт доогуур үзүүлэлттэй байгаа явдал юм. Гэхдээ иргэдийн боловсролын түвшингөөрөө харьцангуй дээгүүр байр эзэлдэг.

### **3.2. Хүний аюулгүй байдал**

Хүний аюулгүй байдал нь айх аюулгүй, гачигдах дутагдахаас ангид байх эрх чөлөө гэсэн хоёр бүлэг ухагдахууныг агуулж байдаг.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон Нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн тухай олон улсын пактын удиртгал тус бүрт айх аюулгүй, гачигдах зовлонгүй байх чөлөөт бие хүний зорилгыг тодорхойлж, энэ зорилгыг хэрэгжүүлэх үүргийг олон улсын гэрээний оролцогч улс бүр хүлээн зөвшөөрсөн байдаг.

1980-аад оны сүүлч хүртэл капиталист, социалист нийгмийн тогтолцооны ялгаанаас үүдэлтэйгээр жишээ нь 1949 онд байгуулагдсан Умард Атлантын цэргийн эвсэл-НАТО, 1956 онд байгуулагдсан Варшавын гэрээний улсуудын гэх мэтийн цэрэг-улс төрийн бүлэглэлийн аюулгүй байдал, улс орны үндэсний аюулгүй байдлын асуудал хурцаар хөндөгдөж байсан.

Харин “хүйтэн дайн” төгсгөл болсноор нийгмийн тогтолцооны ялгаа хоорондын дайсгалцах үзэл үндсэндээ арилж, 1990-ээд оны эхэн үеэс, тухайлбал 1994 онд анх удаа НҮБХХ-ийн Дэлхийн хүний хөгжлийн илтгэл нь “Хүний аюулгүй байдлын шинэ чиг хандлага” сэдэвтэйгээр бэлтгэгдэн гарсан нь дэлхийн хэмжээнд болон улс орны үндэсний аюулгүй байдлын хүрээнд “хүний аюулгүй байдал” гэсэн ухагдахуун түгэн дэлгэрч, улмаар улс орнуудын гадаад, дотоод бодлогод баримтлах үзэл баримтлалын чиглэлийн нэг боллоо.

**Тодорхойлолт:**

НҮБ-ын Хүний аюулгүй байдлын зөвлөлөөс “Хүний амьдралын утга учрыг хүний эрх, эрх чөлөө, сэтгэл хангалуун байдлаар тодорхойлно. **Хүний аюулгүй байдал** гэдэг нь хүмүүний амьдралын гол утга учир болох үндсэн эрх чөлөөг хамгаалахыг хэлнэ. Энэ нь хүнийг хямралт байдал, аюултай орчноос хамгаалахыг хэлнэ. Энэ нь улс төр, нийгэм, хүрээлэн буй орчин, эдийн засаг, батлан хамгаалах, соёлын системийг цогцлон бүтээж, улмаар нэр төртэй аж төрөх нөхцөл бий болгохыг хэлнэ.” гэж хүний аюулгүй байдлыг тодорхойлжээ.<sup>11</sup>

**Хүний аюулгүй байдал гэж юу вэ?** Хамгийн энгийнээр хэлбэл энэ нь дэлхийд эрэгтэй, эмэгтэй хэн боловч мөрөөдөн хүсдэг зүйлс, тухайлбал өрх гэрийнхнээ хүрэлцээтэй хоол хүнсээр хангах, боломжийн орон байртай байх, эрүүл энх байх, үр хүүхдээ эрдэм номд сургах, бусад хүмүүс болон байгалиас учруулж болох аюул заналаас хамгаалагдсан байх, төр засаг нь иргэд хүмүүсээ дарлан хавчдаггүй, харин тэднийхээ санал бодолд нийцүүлэн засаглалаа хэрэгжүүлдэг байхыг хэлнэ.<sup>12</sup>

НҮБ-аас хүний аюулгүй байдал үндсэн 7 хэсгээс бүрэлдэн тогтохыг тодорхойлсон байдаг. Үүнд:

- Эдийн засгийн аюулгүй байдал;
- Хүнсний аюулгүй байдал;
- Эрүүл мэндийн аюулгүй байдал;
- Байгаль орчны аюулгүй байдал;
- Хувийн аюулгүй байдал;
- Хамт олны аюулгүй байдал;
- Улс төрийн аюулгүй байдал.

Тэгвэл Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд “Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг

<sup>11</sup> “Монгол Улсын эдийн засаг, экологийн эмзэг байдал ба хүний аюулгүй байдал” товхимол, 2005 он, 12 дахь тал.

<sup>12</sup> “Глобальчлалын эрин дэх хүний аюулгүй байдал” олон улсын бага хурлын илтгэлийн эмхтгэл, УБ., 2000 он, 270 дахь тал.



сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ.” хэмээн тодорхойлоод түүний бүрэлдэхүүн хэсгийг дараахь байдлаар тогтоож өгсөн байна:

- Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал;
- нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал;
- иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал;
- эдийн засгийн аюулгүй байдал;
- шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал;
- мэдээллийн аюулгүй байдал;
- монгол соёл иргэншлийн аюулгүй байдал;
- хүн ам, удмын сангийн аюулгүй байдал;
- экологийн аюулгүй байдал.<sup>13</sup>

Эндээс үзвэл хүний аюулгүй байдал нь улс орны үндэсний аюулгүй байдалтай нягт уялдаатай нь харагдаж байна.

Олон улсын түвшинд улс бүр үндэсний аюулгүй байдалд тусгаар тогтнол, оршин тогтнох газар нутгийн бүрэн бүтэн байдалтай холбогдсон аюулгүй байдлыг оруулдаг бөгөөд үүнд санал нэгтэй хандаж байдаг.

Харин хүний аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг байх ёстой, эсхүл энэ хоёр зэрэгцэн байх ёстой гэсэн өөр өөр байр сууриас үзэж байна.

Энэ нь улс орон бүрийн хөгжлийн, хүний хөгжлийн түвшин, хүний эрх, эрх чөлөө хэр хангагдаж байгаагаас шалтгаалж байна.

2000 оны 5 дугаар сард Монгол Улсын Засгийн газар, НҮБХХ, Шведийн олон улсын хөгжлийн агентлаг, “Очирбат сан” төрийн бус байгууллага хамтран “Глобальчлалын эрин дэх хүний аюулгүй байдал” сэдэвт олон улсын бага хурлыг зохион байгуулж, хүний аюулгүй байдлыг тойрсон 20 гаруй сэдвээр АНУ, БНСУ, Дани, Канад, ОХУ зэрэг гадаадын 8 улсын, түүнчлэн олон улсын байгууллагын болон дотоодын олон улсын хөгжил, аюулгүй байдлын судлаач мэргэжилтнүүд илтгэл тавьж хэлэлцүүлсэн юм.

Энэхүү олон улсын бага хурлын төгсгөлд хүний аюулгүй байдлын ерөнхий ойлголт, үндсэн элемент, эдийн засаг, нийгэм, экологийн

<sup>13</sup> Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, 2001 он, 3.1, 3.4 дэх хэсэг, түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 1994 оны 56 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 2, 5 дахь хэсэгт тодорхойлсон байна.

асуудал, мэдээлэл, мэдээллийн технологи, Монгол Улсын хөгжлийн гадаад хүчин зүйлст хүний аюулгүй байдал ба үндэсний аюулгүй байдлын нөлөөллийн гэсэн 6 үндсэн чиглэлээр зөвлөмж гаргасан юм.

Олон улсын бага хурлын зөвлөмжийг Монгол Улсын Засгийн газар хүлээн авч, 2001 онд “Хүний аюулгүй байдлын төлөөх сайн засаглал хөтөлбөр”-ийг баталж, төрийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх, ард түмэндээ үр нөлөөтэй, шуурхай үйлчилж, тэдний үндсэн хэрэгцээг хангах, шударга ёсыг хэвшүүлэн сайн засаглалыг бүрдүүлэх зорилгыг дэвшүүлсэн. Энэ хөтөлбөрт Монгол Улсын хүний аюулгүй байдалд нөлөөлөх аюулыг харилцан уялдаатай цогц асуудлууд гэж тодорхойлоод үүнийг сайн засаглалаар дамжуулан өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулж шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн.

2004 онд Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын шинжээчдийн тусламжтайгаар өөрийн улсынхаа эдийн засаг, экологийн эмзэг байдал хүний аюулгүй байдалд хэрхэн нөлөөлж байгаа талаар 2 төрлийн судалгааг анх удаа явуулж, эдийн засгийн эмзэг байдлаараа хөгжиж байгаа 112 орны дотор 20 дугаар байрт оржээ.

#### **4. Хүний эрх, эрх чөлөө, хүний хөгжил, хүний аюулгүй байдлын харилцан хамаарал**

Эдгээр нэр томъёо - ухагдахууныг өмнө дурдсан тодорхойлолтыг нь үндэслэн маш товчоор илэрхийлбэл:

- Хүний эрх, эрх чөлөө - боломж, чөлөөт бие хүний эрхэм зорилго;
- Хүний хөгжил - үйл явц, үр дүн;
- Хүний аюулгүй байдал – баталгаа буюу нөхцөл хангагдсан орчин.

Хүний эрх, эрх чөлөөг төр, шашин, хэн нэг этгээдээс олгодоггүй. Тэр нь хүнд өөрт нь байдаг, салшгүй боломж юм.


Хүний эрх, эрх чөлөө, хүний хөгжил, хүний аюулгүй байдлыг хангах нь төрийн бодлогын нэн тэргүүнд тавигдах асуудал байх ёстой.

Энэ 3 багц ухагдахууны нийтлэг шинж бол хүн рүү чиглэгдсэн, хүнд төвлөрсөн, нөгөө талаар тэдгээрийг хангахад ямар нэгэн хүрэх ёстой түвшин, хязгаар, тулж очих “хана, дээвэр” байхгүй.

Учир нь “Хүний эрхийн билл” хэмээн нэрлэгдсэн олон улсын баримт бичгүүдийн оршил тус бүрт хүн бүр улс төр, иргэний, эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ адил эдлэх нөхцөлөөр хангагдаж байж, айх аюулгүй,

гачигдах зовлонгүй байх чөлөөт бие хүний эрхэм зорилго биелэгдэхийг тодорхойлсон. Энэ өгүүлбэрээр л тэрхүү 3 ухагдахууны харилцан хамаарал, уялдаа холбоог илэрхийлж болж байна.

### Хүний эрх, эрх чөлөө



Хүний хөгжил, хүний аюулгүй байдал нь харилцан нэгнийгээ нөхцөлдүүлж, дэмжиж байдаг тул аль нэгт нь ахиц гарахад нөгөөдөө ч эерэгээр нөлөө үзүүлдэг. Энэ хоёр нь хүн эрх, эрх чөлөөгөө эдлэх суурь, үндсэн нөхцөл болно.

Энэ 3 ухагдахуун нэгдэж **“Аливаа хүн эрх, эрх чөлөө болсон боломжоо эдлэхдээ аюулгүй баталгаат орчинд чөлөөтэйгөөр өргөн сонголт хийх”** гэсэн “цогц ойлголт”-ыг бүрдүүлж байна.

Нөгөө талаар үүнийг хувь хүн эрх, эрх чөлөө, эд баялгаа чөлөөтэй эдэлж, тэдгээр нь аюулгүй байдлаар хамгаалагдсан газарт хүний эрх хангагдана гэж ойлгож болно.

Тэдгээрийг “хангах” олон улсын болон дотоодын хүчтэй механизм, эдийн засгийн өндөр чадавхи болон эрх зүйн нэн тааламжтай орчин зайлшгүй шаардлагатай.

**ТӨР, ШАШНЫ ХАРИЛЦАА БА БУРХНЫ ШАШИН**

**Г.Буяндэлгэр Зүүн хүрээ  
“Дашчойлин” хийдийн цорж лам  
Хэл шинжлэлийн ухааны магистр**

Монгол Улс олон мянган жилийн турш дэлхийн улс орнуудтай мөр зэрэгцэн өөрийн төрт улсыг байгуулж, тусгаар тогтнолоо хадгалж ирсэн түүхэн уламжлалтай билээ.

Цаг хугацааны явцад тухайн нийгмийн байдлаас хамааран нэгэн үе мандан бадарч, нэгэн үе бууран доройтож байсан ч өнөөдрийг хүртэл оршин байгаа нь өвөг дээдсийн минь аугаа их гавъяа бөгөөд газар нутаг, өв соёл зэрэг нь бидэнд үлдээсэн үнэлж баршгүй эрдэнэ юм.

Хэдийгээр Монгол Улс он цагийн урсгалаар түүхийн олон зуун хуудсыг элээсэн ч 1921 оны Ардын хувьсгал, 1990 оны Ардчилсан хувьсгал нь хамгийн чухал байр суурийг эзэлдэг юм.

1921 оны Ардын хувьсгалаар ард түмэн эрх чөлөөгөө олж дэлхий дахинтай хөл нийлүүлж хөгжин дэвшиж нэгэн үеийн доройтмол байдлаас гарсан боловч хэт их хувьсгалжин туйлширч хүн ардын үзэл санаа, амьдралын хэв маяг, шашин шүтлэгийг боон хязгаарласан хэлмэгдүүлэлт явагдсанаас гадна, хэлмэгдэлтэнд автсан билээ. 1990 онд эхэлсэн ардчилсан хувьсгалын үр дүнд хүний эрхийг дээдэлсэн ардчилсан улс болох замдаа орсон юм.

Орчин үед дэлхийн улс орнуудад техник технологийн өндөр хөгжил, эдийн засгийн хувьд нэгдсэн байдлаас хамааран үзэл санаа даяарчилагдан амьдрал ахуй, шашин шүтлэгийн хүрээнд ч адил төстэй шинж чанар бий болж байгаа ч энэ даяарчилалд өв соёл, зан заншил, шашин шүтлэгээ алдалгүй хадгалж чадвал бусад улс орнуудын дунд өөрийн гэсэн байр суурьтай болж, бүрэн бүтэн байдалтай байх болно.

1990 оноос хойшхи 20 орчим жилд монголчууд дэлхий дахины соёл иргэншил, хөгжил, эдийн засагтай улам ойртож улсын бодлогоо тодорхойлох болсон бөгөөд мөн тэр чинээгээрээ гадны шашин соёл, үзэл бодлуудтай танилцаж байна.

Шашин гэдэг нь энэтхэгийн эртний хэл болох санскрит хэлний үзэл бодол гэсэн утгатай үг юм. Үзэл бодол нь хүн амьтны төлөө, зовлон зүдгүүргүй сайн сайхан байлгах гэсэн тогтсон таалалтай нэг зарчмаар бусдын үйлийг бүтээдэг.

Дэлхийд олон шашин, шашны урсгалууд байдаг бөгөөд ерөнхийдөө Бурханы шашин, Христийн шашин, Лалын шашин гэсэн гурван үндсэн чиглэлд хуваагддаг. Дэлхийн улс орнууд ч шашин төрийн харилцааг өөрсдийн хууль ёсондоо нарийн тусгаж ард түмний шашин шүтэх эрх чөлөөг хуулиараа зохицуулж өгдөг байна.

Өнөөдөр дэлхийн зарим улс оронд шашны мөргөлдөөн их гарч олон хүний амь эрсдэж байгаа нь тухайн шашин нь өөрийн үзлийг үнэнд барьж бусад шашны ёсыг буруутган хориглосноор үүсч байгаа юм. Шашин нь хэдийгээр бие даасан зүйл боловч түүнийг төрийн оролцоогоор тодорхой хэмжээгээр зохицуулж анхаарал тавьж байх хэрэгтэй юм. Гэхдээ 1921 оны Ардын хувьсгалаас хойш Монгол Улсад болж өнгөрсөн үйл явдлаас үзэхэд шашин болон хүн нийгмийг төрийн зүгээс хэт их хянаж барих нь сөрөг нөлөөтэй болох нь харагдаж байна.

Сүүлийн үед Монгол Улсад хүний эрхийг дээдэлснээр олон ургальч үзэл, шашин шүтэх эс шүтэх эрх нээлттэй болсоноор олон шашны урсгалууд орж ирэн хүн ардын үзэл бодол оюун санааг хуваалцах болсон.

Ардчилсан нийгэмд олон шашин, олон ургальч үзэл байх ёстой үзэгдэл боловч тэдгээрийг төрийн зүгээс их анхааралтай ажиглаж яваандаа нийгэмд гарч болох сөрөг үзэгдлээс сэрэмжлэх нь чухал.

Монгол Улсын Үндсэн хуулинд төр шашин сүм хийдийн харилцааны тухай: “ Монгол Улс дахь төр, сүм хийдийн харилцаа төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдлэх зарчимд үндэслэнэ” гэж заасан юм. Энэ заалт нь шашны зүгээс төрийг дээдлэж түүний дор орших явдлыг хэлж байна. Харин төрийн зүгээс шашныг хүндлэнэ гэж ерөнхийд нь хэлж тодорхойлсон ч төрийн зүгээс шашинтай хэрхэн харилцах талаар бүрхэгдүүлсэн заалт юм. Учир нь шашныг төрийн бодлогоос ангид болгож шашныг төрөөс тусгаарлах нь муу үр дагаврыг агуулж байдаг. Гэхдээ өмнөх

олон үеийн түүхийн хуудаснаас монголд болж байсан хямралыг үзвэл шашин төрийн хэрэгт их оролцсоноос үүсч байсан нь цөөнгүй байна.

Шашин бол хүний дотоод сэтгэлд оршин эзэмдэж тухайн ард түмний өв соёл, зан заншилд уялдаж шингэсэн байдаг. Ард түмэн нь тухайн улсын хамгийн эрхэм зүйл ба төр нь ард түмний төлөөлөл, эрх ашгийг хамгаалагч төв юм.

Тиймээс төр нь шашны асуудлыг шашны дотоод хэрэг гэж орхилгүйгээр зарим бодлогын чанартай асуудалдаа хамааруулж байх нь чухал юм.

Миний энд дурьдаж буй шашны асуудлыг төрийн зүгээс бодлогын чанарт хамаарна гэдэг нь төрийн зүгээс ард түмнийг ямар нэг шашныг голчилж шүтүүлэх хэрэгтэй гэсэн үг биш, ялангуяа шинээр тулгар хөгжин урагшилж буй Монгол Улсад олон шашин байвал цөөхөн хүн амыг дотор нь, магадгүй нэг гэр бүлийг ч олон үзэл, шашнаар хагаралдуулах магадлалтай юм. Хэрэв ард түмэн дотроо үзэл бодлын хувьд, олон шашинаар хагаралдаж бутарвал Монгол Улсын ирээдүй нэн бүрхэг болох талтай.

Эзэн Чингэс хаан, түүний хөвгүүдийн байгуулсан Монголын эзэнт гүрний нийслэл Хар Хорумд маш олон шашны сүм хийдүүд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байсан түүхтэй. Тэд дундаа эв найртай оршин тогтнож байсны гол шалтгаан нь төрөөс олон шашнуудын дотоод хэрэгт оролцолгүй хүндэтгэн үзэж нэгэн түвшинд харьцах хэрнээ тэдгээрийн үйл ажиллагааны чиглэлийг төрөөс хууль цаазаар зохицуулж байсанд байна.

Монголчуудын хувьд олон зууны тэртээгээс нүүдлийн соёл иргэншилтэй бурхан шашныг дээдлэн шүтэж зан заншил өв уламжлалдаа нягт шингээж бурхан шашинт улс хэмээн нэрлэгдэж ирсэн билээ.

Бурханы шашны бусад шашинаас ялгагддаг онцлог нь ертөнц хорвоод өөрөө үнэнээсээ бүтсэн зүйл нэг ч үгүй ямар нэгэн эзэн ч түүнийг бүтээдгүй харин юмс үзэгдэл бүгд учир шалтгаантай бөгөөд харилцан учир шалтгааны үүднээс уялдаж буй болсон гэж үздэг. Энэ үзэл баримтлалаараа монголын нүүдэлчин ард түмний зан заншил, байгаль эх дэлхийтэйгээ харьцдаг харьцаатай их ойр байдаг учраас манай өвөг дээдэс сонгон шүтэж ирсэн юм.

Бурхны шашин Бурхан багшийн сургаальд учир шалтгааны үүднээс хамаг амьтанд энэрэн нигүүлсэхүй бодь сэтгэлийг бясалгаж хамаг амьтныг зовлонгоос гэтэлгэж сайн сайхныг олуулах гэсэн сургааль хамгийн эрхэм.

Бодь сэтгэл нь юутай ч зүйрлэшгүй агуу зүйл бөгөөд бодь сэтгэлийг төрүүлэхэд маш бэрхтэй. Бодь сэтгэлийг бясалгадаг нь бусад шашнаас ялгагддаг онцлог юм. Энэ бодь сэтгэл гэдгийг орчин цагийн ойлголттой ерөнхийд нь дүйцүүлвэл хорвоогийн хүн болон амьтны эрх, эрх чөлөө ба бие биенийгээ хүндлэх бусдын эрхийг хүндэтгэх гэсэн утга юм. Бурхан багш сургаальдаа:

Хилэнц нүгэл юуг ч үйлдэхгүй

Буяныг хотол чуулган болгоод

Өөрийн сэтгэлийг огоот номхотговол

Энэ л бурхны шашин мөн гэж айлдсан байдаг. Энэ айлдвар нь өөрийн зүгээс бусдад хорлол хөнөөл учруулж болох бүх зүйлийг хилэнц нүгэлд тооцдог ба амийг нь авахаар тулгасан ч хилэнц нүгэлийг үйлдэхгүй, өөрийн зүгээс бусдад тус хэрэг болох зүйлийг хичээн бүтээх нь буян болдог учир бусдын тусыг дээдлэх, мөн өөрийн сэтгэлд бүгж буй хорт сэтгэл, шунал тачаал, уур мунхагыг даран чадвал жинхэнэ бурхны шашин, бурхны шашинтан болно гэсэн утгатай бөгөөд энэрэн нигүүлсэхүй сэтгэл нь бусдын тусыг бүтээх зорилготой ба юун түүрүүнд бусдыг хайрлаж энэрэснээр өөрийн хэрэг үйлс бүтэх гэсэн энэ сэтгэлгээ нь бусдын эрхийг хүндэтгэснээр өөрийн эрхийг улам баталгаажуулна гэсэн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын заалттай ч нийцэж байгаа юм.

Мөн Бурхан багш шашны төртэй харилцах харьцааг ч сургаалаараа дамжуулж айлдсан билээ. Бурхан багш төрийг хамгийн аугаа зүйл ба түүний дор шашин орших тухай сургаальдаа айлдсан байдаг.

Монгол Улсын хүн амын олонхи нь бурхны шашин шүтдэг. Тиймээс ч бурхны шашныг Монголын үндэсний шашны хэмжээнд үздэг. 1990 оноос эхлэн олон жил хаалттай байсан бурханы шашин дахин сэргэж хүн ардын сүсэг бишрэл хүслийг хангах болсон билээ. Гэвч өмнөх цаг төрийн үймээний үеэр олон хүрээ, сүм хийдийг устгаж, олон лам хуврагуудыг хэлмэгдүүлсний уршгаар шашин хичнээн сэргэвч тодорхой боловсон хүчин эрдэмтэй лам хуврагууд байнга дутагдаж, сүм хийдийн жинхэнэ орчин сайн бүрэлдэж чадахгүй байна. Хэдийгээр дахин сэргэж буй том жижиг сүм хийдүүд өөрийн хүч бололцооны хирээр лам хуврагуудыг эрдэм боловсролтой болгож, сүм хийдийн байдлыг сайжруулахыг оролдож нийгэмд үйлчилэхээр хичээж байгаа ч хэд хэдэн үндсэн шалтгаанаас болж ахиц гарахгүй байна.

Үүнд: төрөөс дэмжлэг үгүй, сүм хийдүүдийн хоорондын харилцаа сул, хүрээ хийдүүдийн эдийн засгийн чадавхи муу, сайн багш нар дутагдалтай, гадаад харилцаа тааруухан, шашны боловсролыг орчин цагийн боловсролтой нийцүүлэн олгох боловсролын нэгдсэн тогтолцоогүй, сүм хийд аглагт орших гэсэн зарчмаас хазайсан зэргээс хамаарч байна. Эдгээр хүчин зүйлс өнгөц харахад зөвхөн шашны дотоод хэрэг мэт үзэгдэвч үндсэндээ хүн амын олонхи шүтдэг мөн зан заншилд ч шашны зан үйл ихээр тусгагдан хэрэглэгдэн уламжлагдаж байгаа талаас нь авч үзвэл төрийн оролцоо зайлшгүй хэрэгтэй бөгөөд төр хууль тогтоомжиндоо тусгаж дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

Бурхны шашны онол нь ертөнцийн юмс үзэгдлийн мөн чанар, учир шалтгааны үүднээс тайлбарладаг, бас хүний сэтгэлийн мөн чанарыг судлан түүнийгээ нотлон бясалгадаг нь шинжлэх ухааны талаасаа бүхэл бүтэн бие даасан ухаанлиг шашин бөгөөд орчин цагийн шинжлэх ухаан, техник технологи өндөр хөгжсөн нийгэм, хүмүүсийн оюун ухаан улам нарийсч оюунлаг шинж чанартай болж байгаа үед оюуны хэрэгцээг бүрэн хангаж чадна. Гадаад улс орнууд ч бурхны шашинд өндөр ач холбогдол өгч бурхны шашныг судлан хэрэгжүүлэх нь эрчимтэй өрнөж байгаа энэ үед төр ба шашны харилцаанд шинэчлэл гаргах, бурхан шашны эртний уламжлалтай Монгол Улс бурхны шашнаа дээдлэн хүндлэх хэрэгтэй ба лам хуврагууд нь ч хүн ардыгаа мухар сүсгийн эргүүлгэнд автуулах биш учир шалтгааны зүгээс тайлбарлан оюунлаг, эв найрамдалтай, эрч хүчтэй улсыг цогцлоон бүтээхэд хувь нэмрээ оруулах чухал үүрэгтэй байна



**ХҮН ХУДАЛДААЛАХ БОЛОН БЭЛГИЙН МӨЛЖЛӨГӨӨС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХЭД ХУУЛЬ  
ТОГТООМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ****Ж.Дашдорж  
ХЭҮК-ын гишүүн**

Монгол улс 1990-ээд оноос ардчилал, зах зээлийн харилцаанд шилжиж, шинэ Үндсэн хуулиараа хүний эрх, эрх чөлөөг олон улсын жишигт нийцүүлэн баталгаажуулж, улмаар түүнийг хангах баталгааг бүрдүүлж эхэлсэн билээ. Үүний зэрэгцээгээр Монгол орны өнөөгийн нөхцөлд учирч байгаа бэрхшээл, ялангуяа ажилгүйдэл, ядуурал, хөдөлмөрийн үнэлгээний хомсдол, эдийн засгийн хямрал нь иргэдийн гадаадад гарч ажиллах, мэргэжил боловсрол эзэмших, өндөр цалин хөлс авч ахуй амьдралаа дээшлүүлэх, хуримтлал бий болгох гэсэн хүсэл сонирхлыг төрүүлэх болсон.

Иргэдийн энэхүү хүсэл, эрмэлзлэл, хэрэгцээ, шаардлагыг гадаад, дотоодын зарим иргэд, байгууллага сөргөөр ашиглаж, жуучлах, виз гаргаж өгөх, ажилд оруулж өгөх, гадаадын иргэдтэй гэр бүл болоход нь туслах нэрээр тэднийг /хүн/ худалдаалж ашиг хонжоо олох хэрэгсэл болгодог шинэ төрлийн гэмт хэрэг багагүй гарч, хүнийг эрхийг ихээхэн хөсөрдүүлэх болов. Энэ нь хүний аюулгүй байдалд ноцтой харш нөлөөлж, ийм төрлийн хэрэг даамжрах хандлагатай болж байгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр удаа дараа нийтлэн харуулж, хууль сахиулах байгууллагад цөөнгүй хэрэг бүртгэгдэх болсон байна. Иймээс “Хүн худалдаалах” хэмээх шинэ гэмт хэргийг Монгол Улсын Эрүүгийн хууль ба практикт шинээр нэвтрүүлж, уул гэмт хэрэг үйлдэгдэн гарч буй шалтгаан нөхцөл, түүнд дөхөм үзүүлсэн нөхцөл байдлыг тогтоож, улмаар хуулиар хориглон сэргийлэх, устган арилгах оролдлого хийж, эрх зүйн зохих орчин бүрдүүлж байна. Гэвч энэ гэмт хэрэг нь Монголын хувьд шинэ үзэгдэл, хууль эрх зүйн орчин сайтар бүрэлдэн тогтоогүй, шүүхийн практик шинэ тутам байгаагаас уул тэмцлийн

үр нөлөө сайнгүй байгааг нийтээр хүлээн зөвшөөрч байна. Иймээс хүн худалдаалах гэмт хэргийг эрүүгийн хуулиар тодорхойлсон байдал, ял шийтгэл, түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг тухайлан судалж юуны өмнө хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь тулгамдсан асуудал мөн. Энэ зорилгоор хүн худалдаалах болон эмэгтэйчүүд, хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглах гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн орчин ямар байгаад судалгаа, дүгнэлт хийв. Энэхүү судалгааг хийхдээ шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурор уул хэргийг хэрхэн мөрдөн шалгаж шийдвэрлэж байгаа практик, түүнд одоо үйлчилж буй хууль, эрх зүйн бусад акт хэрхэн нийцэж нөлөөлж буйг харьцуулан судлах замаар хууль, журам, зааврыг нягтлан үзэж дүгнэлт хийсэн болно.

Хууль тогтоогчид, шийдвэр гаргагчид, хуульчид, эрдэмтэн, судлаачдад хэрэгтэй хэмээн үзэж, судалгааны гол, гол дүгнэлтүүдийг товчлон нийтэлж байна.

**Нэг. Хүн худалдаалах гэмт хэргийн талаархи  
Эрүүгийн хуулийн зохицуулалт:**

Монгол улсад хүн худалдаалах гэмт хэрэгтэй хийх эрх зүйн тэмцэл 2000 оноос эхэлсэн гэж үздэг.

Хүн худалдаалах гэмт хэргийг манай улсын эрүүгийн хууль тогтоомжид хэрхэн тодорхойлж, ямар ял шийтгэл оноохоор тогтоож ирснийг дор харьцуулан үзүүлэв.

2000 оны ЭХ-ийн 111-р зүйл	2002 оны хууль ЭХ-ийн 113-р зүйл Хүн худалдах, худалдан авах	2008 оны ЭХ-ийн 113-р зүйл Хүн худалдаалах
111.1. Биеийг нь үнэлүүлж ашиг олох зорилгоор хууран мэхэлж хүмүүсийг элсүүлсэн бол 4 жил хүртэл хорих	113.1. Хүн худалдсан, худалдан авсан бол ХХДХ-г 51-250 дахин нугалж торгох, 300-500 цаг албадан ажил хийх, 3 жил хүртэл хорих	113.1. Ашиг олох мөлжих зорилгоор худалдаалахдаа хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хууран мэхэлсэн, эмзэг байдлыг нь далимдуулсан, түүнчлэн бусдыг элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан бол ХХДХ-Г 51-250 дахин нугалж торгох, эсхүл 5 жил хүртэл хорих /хүндэвтэр/

111.2. Урьдчилан тохирсон бүлэг үйлдсэн бол <b>3-8 жил хорих</b>	113.2. Энэ хэргийг хүний цус, эд эрхтэнг ашиглах, биеийг нь үнэлүүлэх зорилгоор, давтан, хоёр буюу түүнээс олон хүнийг, насанд хүрээгүй хүнийг, бүлэглэж буюу үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн бол <b>5-10 жил хорих</b>	113.2. Энэ хэргийг насанд хүрээгүй хүнийг, 2, түүнээс олон хүнийг, хулгайлах, эрх мэдлээ урвуулан ашиглах, эрхшээлдээ байгаа хүнийг, давтан, бүлэглэж, буюу урьдчилан тохиролцсон бүлэг үйлдсэн бол <b>ХХДХ-г 51-250 нугалж торгох, 5-10 жил хорих /хүнд/</b>
	111.3. энэ хэргийг байнга үйлдсэн, хил давуулан худалдсан, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, хүнд хор уршиг учирсан бол <b>10-15 жил хорих ял шийтгэх</b>	113.3. Хүнийг хил давуулан худалд сан, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол <b>10-15 жил хорих ял шийтгэнэ. /онц хүнд/</b>

Эрүүгийн хуулийн хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлсон зүйл заалт нь дор дурьдсан учир дутагдалтай байна гэж үзсэн.

ЭХ-ийн 113-р зүйлд заасан Хүн худалдаалах гэмт хэргийн 3 бүрэлдэхүүн нь хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэргийн ангилалд багтжээ. Хүн худалдаалах гэмт хэрэг нь хүний халдашгүй чөлөөтэй байх, боолчлол, хүчирхийллээс ангид байх суурь эрхэд халдаж, хүнийг бараа таваар мэтээр зарж ашиг хонжоо олох гэсэн онц ноцтой хэрэг мөртөө хүндэвтэр гэмт хэргийн ангилалд багтаж байгаа нь зохимжгүй байна. Энэ гэмт хэргийн бүрэлдэхүүн нь зөвхөн хүнд, онц хүнд гэмт хэргийн ангилалд л багтах ёстой.

Эхний 2 хэсэгт нь хорихоос өөр төрлийн /торгох/ ял ч оноож болохоор байна. ЭХ-ийн 113-р зүйлийн 1 дэх хэсэг нь хүндэвтэр гэмт хэргийн ангилалд хамаарч буй тул хорих ял оноож, түүнийгээ тэнсэх ч бололцоотой. Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорих ял л оноохоор хуульчлах шаардлагатай.

Түүнчлэн 2008 оны Эрүүгийн хуулиар хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлохдоо Палермогийн протоколын заалтанд нийцүүлсэн гэх боловч утга агуулгын алдаа гаргаж, хүн наймаалж болно гэхдээ тодорхой нөхцөлд гэмт хэрэг болно гэсэн агуулгаар тодорхойлсон мэт ойлгогдож байна. Ашиг олох зорилгоор хүн худалдаалахдаа хүч хэрэглэсэн ....., түүнчлэн тээвэрлэсэн .....бол ... шийтгэнэ гэж тодорхойлсон нь хүн

худалдаалж болно тэгэхдээ тэр нь тодорхой нөхцөлд хэрэг болно гэсэн агуулгатай харагдаж байна.

Энэ гэмт хэргийн онц хүндрүүлэн үзэх бүрэлдэхүүнийг тодорхой болгож, нэрлэн заах, хүнд хор уршиг гэдгийг хасаж, эд хөрөнгийн хохирол учирсан бол онц хүндрүүлэн үзэхээр тайлбарласныг өөрчлөх нь зүйтэй.

Эрүүгийн хуулийн 113-р зүйлийг дараахь байдлаар өөрчлөн найруулах нь зохистой гэж үзсэн.

**Эрүүгийн хуулийн 113-р зүйл. Хүн худалдаалах**

113.1. Хүнийг мөлжих буюу ашиг олох зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх, хүч хэрэглэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах эсхүл өөр этгээдийг хяналтандаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, буюу хахуулдах зэрэг аргаар элсүүлсэн, тээвэрлэсэн, орогнуулсан, дамжуулсан, хүлээн авсан бол 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

113.2. Хэргийг дараахь нөхцөл байдалтайгаар үйлдсэн бол:

- 113.2.1. насанд хүрээгүй хүнийг худалдаалсан,
- 113.2.2. хулгайлах замаар худалдаалсан,
- 113.2.3. хил давуулан худалдаалсан,
- 113.2.4. эрх мэдлээ ашиглах буюу эрхшээлдээ байгааг нь далимдуулж хүнийг худалдаалсан,
- 113.2.5. бүлэглэж буюу урьдчилан тохирсон бүлэг үйлдсэн,
- 113.2.6. 2 буюу түүнээс олон хүнийг худалдаалсан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

113.3. Энэ гэмт хэргийг давтан эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас хүний амь хохирсон, хүнд гэмтэл учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

**Хоёр. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зохицуулалт:**

Хүн худалдаалах болон хүнийг бэлгийн мөлжлөгт ашиглах гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүн таслах, эдгээр гэмт хэргийн хохирогчдын хувийн нууцлалыг хамгаалах, тэдэнд нийгмийн үйлчилгээ үзүүлэх, эрхийг нь

хангах талаар Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд тусгайлан журамласан зүйл заалт байхгүй байна.

Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Палермогийн протоколд “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хувийн амьдралыг болон бие хүний хувьд тухайн хэргийн шүүн таслах ажиллагааг нууцлах замаар дотоодын хууль тогтоомжоор байж болох хэмжээнд хамгаална. Хохирогчдын бие бялдар, сэтгэл зүй, нийгэмд эзлэх байр суурийг нь нөхөн сэргээх арга хэмжээг тухайлбал орон байраар хангах, ойлгогдох хэлээр эрхийн талаар нь мэдээлэл зөвлөгөө өгөх, эмнэлгийн болон сэтгэл зүйн материаллаг туслалцаа үзүүлэх, хөдөлмөрлөх, боловсрол эзэмших, суралцах бололцоогоор хангах, нөхөн төлбөр авах боломж олгох хууль зүйн тогтолцоог бий болгоно.” гэж заасан боловч манай ЭБШ хууль бусад хуульд ийм зохицуулалт байхгүй байна. Иймд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эрх, аюулгүй байдлыг нь хангах бие даасан хууль гаргах, ЭБШХ-нд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч хохирогчийг эрхээ эдлэх боломжоор хангах үүрэгтэй биш харин эрхийг нь хангах, бусад хуульд тусгайлан заасан, буюу шаардлагатай тохиолдолд хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хувийн нууцыг хамгаалах үүрэгтэй байхаар нэмэлт оруулах, хувийн нууцын тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах, хүн худалдаалах гэмт хэргийг хаалттай хэлэлцдэг журам тогтоох нь зүйтэй байна.

#### **Гурав. Монгол улсын Гэр бүлийн тухай хууль тогтоомжийн талаар**

Гэр бүл, эр эм, насанд хүрэгчид, хүүхдийн хоорондын харилцаан дахь хүчирхийлэл, мөлжлөгийн шинжтэй үйлдлүүдээс сэргийлэх, таслан зогсоох, ийм үйлдлийн үүсэн гарах шалтгаан нөхцлийг хязгаарлахад гэр бүлийн хууль тогтоомж чухал үүрэгтэй тул гэр бүлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэв.

Монгол Улсын харъяат эмэгтэйчүүд гадаадын иргэнтэй гэрлэж буй практик сүүлийн жилүүдэд анхаарал татаж, ялангуяа зуучлах товчоо буюу хэн нэгний тусламжтайгаар гадаадын иргэнтэй гэр бүл болж, зуучлагчид аль аль тал нь тодорхой мөнгө төлж, гэр бүл болж, харийн нутагт очиж, дараа нь хүчирхийлэл дарамтанд, өртөж, байнгын боолчлолын байдалд

орж, эрх ашиг нь зөрчигдөж байгаа нь худалдаалагдсантай утга чанар адил байна. Гэрлэгчдийн хайр дурлал, сайн дурын хүсэл зориг, эрх тэгш харилцаанд үндэслэсэн гэрлэх ёсыг хөндлөнгийн этгээдийн ашиг хонжоо олох хэрэгсэл болгож байгаа гаж буруу үйлдэл, явдлыг хатуу хориглох шаардлагатай байгаа боловч манай өнөөгийн хуулинд үүнийг хориглосон заалт байхгүй. Гэр бүлийн тухай хуулиар ийм зохицуулалт хийвэл ийм төрлийн зар хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарах боломжгүй, ийм үйлчилгээ явуулсан иргэдэд хуулийн дагуу хариуцлага тооцох боломжтой болно. Тухайлбал Гэр бүлийн тухай хуулинд “Байгууллага, иргэд Монгол Улсын иргэнийг гадаадын иргэн, харъяалалгүй хүн, бусадтай гэрлэхэд нь зуучлах үйлчилгээ үзүүлэх, хөндлөнгөөс оролцохыг хориглоно, ийм төрлийн зарыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон бусад хэлбэрээр түгээхийг хориглоно” гэсэн нэмэлтийг Гэр бүлийн тухай хуулинд оруулах шаардлагатай.

Монгол Улс Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай НҮБ-ын конвенци-д<sup>1</sup> 1998 онд нэгдэн орсон.

Монгол Улсын харъяат хүүхдийг гадаад улсын иргэнд үрчлүүлэх тухай дотоодын хууль тогтоомж нь энэхүү Конвенцид ерөнхийдөө нийцэж байгаа боловч зарим зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай.

Монгол Улс хүүхэд үрчлэн авах Монгол Улсын иргэнд ямар болзол, шаардлага тавигдахыг хуулиараа тодорхойлсон атлаа Монгол Улсын харъяат хүүхдийг үрчлэн авах гадаадын иргэнд тавигдах болзол, шаардлагыг журмаар зохицуулсан нь бодлогын чанартай том алдаа болжээ. Ялангуяа гадаадад үрчлэгдсэн хүүхдийн эрх ашиг зөрчигдөж байгаа эсэхийг хянах эрх зүйн тогтолцоо сайтар бүрдээгүй байна.

Гэр бүлийн тухай хуулинд гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх журмыг хууль зүйн болон эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүд хамтран тогтооно гэж заасан боловч уг журмыг Хууль зүй дотоод хэргийн, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны сайдууд хамтран баталсан байна.

Гэр бүлийн тухай хууль, гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх журам зэргийг хянан үзэж Монгол Улсын харъяат хүүхдийг гадаадын иргэнд

<sup>1</sup> Төрийн мэдээлэл сэтгүүл. Тусгай дугаар. 1-р боть. 2004 он. 94-р тал.

үрчлүүлэхдээ үрчлэгчид ямар шаардлага, болзол тавигдахыг хуулиар тогтоож, үрчлэгдсэн хүүхдийн нөхцөл байдалд хяналт тавих, эх оронд нь тодорхой хугацаанд айлчлуулж, хүүхдийг эцэг эхтэй нь уулзуулах, эх оронтой нь танилцуулах, хүүхдийг хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлж танилцуулах үүргийг хуульчлах шаардлагатай байна.

Иймд Монгол Улсын харъяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх хууль тогтоомжийг боловсронгуй болгож, Монгол Улсын харъяат хүүхдийг өргөж авах гадаадын иргэнд тавигдах шаардлага, түүний хүлээх үүрэг, хариуцлагыг улам боловсронгуй болгож, зөвхөн хуулиар зохицуулах, үүний дотор үрчлэгдсэн хүүхэд зөв хөгжиж хүмүүжиж байгаа гэдгийг мэдүүлэх үүргийг улам чангатгах, гадаадад үрчлэгдсэн Монгол хүүхдийн эрх, ашгийг хамгаалах, хяналт тавих эрх, үүргийг Монгол Улсаас гадаад оронд суугаа дипломат төлөөлөгчийн газарт олгох, үрчлэгдсэн хүүхдийн тухай мэдээллийг тэдгээрт өгдөг, зохих хөрөнгө хуваарилдаг болгох шаардлагатай.

**Дөрөв. Хүүхдийг бэлгийн мөлжлөгт болон садар самуунд ашиглахыг хориглосон хууль, тогтоомжийн талаар:**

Насанд хүрээгүй хүмүүсийг биеэ үнэлэхэд уруу татах, тэднийг садар самууны сурталчилгаанд ашиглах нь тэднийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, биеэ үнэлэгч болох эрсдэлийг дагуулдаг учир эдгээр гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байдаг.

Эрүүгийн хуулийн 115-р зүйлд насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэл, гуйланчлалд татан оролцуулахыг гэмт хэрэг хэмээн тодорхойлжээ. Энэ зүйл 3 хэсэгтэй байна.

Насанд хүрээгүй хүнийг биеэ үнэлэх, согтуурах, мансуурахад татан оролцуулах нь хүүхдийн эрүүл энх өсөж хөгжих, хамгаалуулах эрхийг зөрчсөн, хүүхдийн эсрэг ноцтой гэмт хэрэг мөн. Тэр тусмаа хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх замаар биеэ үнэлэхэд татан оролцуулсан, энэ хэргийг давтан үйлдсэн нь бүр ч илүү хор аюултай ёс суртахууны хувьд ноцтой хэрэг. Гэтэл Эрүүгийн хуулийн 115-р зүйлийн эхний 1 дэх хэсэг нь хөнгөн гэмт хэргийн, сүүлийн хоёр хэсэг нь хүндэвтэр гэмт хэргийн

ангилалд хамаарч байгаа ба бүх хэсгүүдэд нь торгох, албадан ажил хийлгэх, баривчлах ял оноох заалттай байгаа нь учир дутагдалтай байна. Ялангуяа хүч хэрэглэж үйлдсэн ийм төрлийн хэрэг хүндэвтэр гэмт хэргийн ангилалд хамаарах ёсгүй.

Эрүүгийн хуулийн 123-р зүйлд насанд хүрээгүй хүнийг хүч хэрэглэж садар самууны сурталчилгаанд татан оролцуулсан бол зөвхөн 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан мөртөө хүч хэрэглэж биеийг нь үнэлүүлсэн бол торгох ял оноож болохоор байна. Хүч хэрэглэж биеийг нь үнэлүүлнэ гэдэг түүнээс илүү хор аюултай үйлдэл мөн.

Түүнчлэн ЭХ-ийн 122-р зүйлд 16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдвэл эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Манай улс 18 насанд хүрээгүй хүнийг хүүхэд гэж үздэг, хүүхэд 18 насандаа бүрэн дунд боловсрол эзэмшихээр байгаа. Хуулийн эдгээр заалт, Хүүхдийн эрхийн конвенцийн зарчмуудыг харгалзан ЭХ-ийн 122 зүйлийн 16 нас гэснийг 18 болгох шаардлагатай. Ер нь манай ирээдүй болсон хүүхэд залуучуудын эсрэг чиглэсэн тэднийг бэлгийн мөлжлөг, садар самууны сурталчилгаанд ашигласан гэмт хэргүүдийг тодорхойлсон дээр дурьдсан зүйл ангиудыг бүхэлд нь хянан үзэж, хэргийн ангилал, ял, хариуцлагыг нь хянан зохицуулах нь хүүхдийн эрх ашигт нийцнэ.

**Тав: Садар самуун явдалтай тэмцэх тухай  
хууль тогтоомжийн талаар:**

Монгол Улс Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийг 1998 онд баталсан. Хуулиар биеэ үнэлж бусадтай хурьцал үйлдэх, биеэ үнэлэхэд бусдыг уруу татах, бусдыг биеэ үнэлэхэд нь зуучлах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, хурьцал үйлдэхийг өдөөн турхирах, энэ зорилгоор бэлэг эрхтнийг илээр үзүүлэх, сонсгох, уншуулахыг тус тус энэ хуулиар хориглож хариуцлага хүлээлгэхээр тогтоосон.

Харин биеэ үнэлж явалдах гэдэг нь хоёр хүний хоорондын тохиролцооны асуудал бөгөөд хуульд биеэ үнэлж<sup>2</sup> явалдсан этгээдийнх нь үйлдлийг хориглосон атлаа бусдын биеийг нь үнэлж мөнгө, эд зүйл

<sup>2</sup> Биеэ үнэлэх гэдгийг нарийвчлан тодорхойлоогүй.



өгч явалдсан этгээдийн үйлдлийг хориглоогүй орхигдуулсныг авч үзэх ёстой. Энэ нь нөгөө талаар иргэдийн хууль, шүүхийн өмнө адил тэгш байх эрхийг зөрчсөн асуудал ч гэж хэлж болохоор байна. Биеэ үнэлж буй хүн гэдэг бол санхүүгийн хувьд хөрөнгө мөнгөөр гачигдсан, ажилгүй эсвэл эд хөрөнгийн хувьд хомсдолтой, ийм хэрэгцээ шаардлагатай байгаа эмэгтэйчүүд байдаг. Нэгэнт л биеэ үнэлж явалдахыг нийгэмд хор хөнөөлтэй үйлдэл гэж үзэж, хуулиар хориглож байгаа бол ийм үйлдлийг үйлдсэн хоёр тал нэгэн адил буруутайд тооцогдож аль альных нь үйлдлийг хориглож, адилхан хариуцлага хүлээлгэх ёстой.

Бусдын биеийг үнэлж явалдсан этгээдэд хариуцлага хүлээлгэдэггүй атлаа зуучилсан буюу биеэ үнэлэх гэж байгаа этгээдэд үйлчлүүлэгч олж өгсөн, тээврийн хэрэгслээр үйлчилсэн этгээдийг бүр Эрүүгийн хуулийн 124-р зүйлийн 124.2. дахь хэсэгт зааснаар торгох, албадан ажил хийлгэх, 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна.

Биеэ үнэлэх асуудлыг хуулиар хориглож, захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг энэ эрх зүйн зохицуулалт үйлчилсээр олон жил болсон хэдий ч энэ зохицуулалтын үр дүн гараагүй харин ч ийм явдал улам газар авсаар байна. Иймд биеэ үнэлэх асуудлыг зохицуулж байгаа хуулийн зохицуулалтыг иж бүрнээр нь авч үзэж, бусад орны туршлагыг судалж асуудлыг зохицуулахыг амьдрал шаардаж байна.

### **Зургаа. Монгол улсын иргэд гадаадад зорчих, цагаачлах хуульд заасан механизмын талаар:**

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулинд Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах бол түүнд үндэсний гадаад паспорт олгоно.

Насанд хүрээгүй хүн гадаадад зорчих, цагаачлах бол дараахь баримт бичгийн аль нэгийг олгоно гэж заажээ.

- үндэсний гадаад паспорт
- Эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийн үндэсний гадаад паспортонд зургийг нь нааж баталгаажуулах,
- Эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийн хамт түр хугацаагаар гадаадад зорчих хүүхдэд үндэсний гадаад паспортонд нь хавсаргагдах үнэмлэх олгох,

- Гадаадын иргэнд үрчлэгдсэн хүүхдэд үндэсний энгийн гадаад паспорт олгодог байна.

Төрийн өндөр албан тушаалтнууд болон албан хэргээр зорчих иргэдэд албаны /ногоон/, дипломат /цэнхэр/ паспортыг Гадаад хэргийн яамнаас олгодог байна.

Хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэхэд хуурамчаар үйлдсэн баримт бичгийг ашиглах явдал багагүй гардаг учир гадаадад зорчих баримт бичгийн үйлдвэрлэл, олголтонд тавих хяналтын тогтолцоо чухал ач холбогдолтой. үндэсний гадаад паспорт авах баримт бичгийг хянан үзэж зөрчилгүй байна гэж үзвэл иргэний бүртгэл мэдээллийн байгууллага зохих баримт бичгийг бүрдүүлж, паспортыг хэвлүүлэхээр хувийн хэвлэлийн компанид материалыг нь шилжүүлж, паспортыг хэвлүүлж, уг паспорт хэвлэгдсэний дараа иргэний бүртгэл мэдээллийн байгууллага хянан үзэж тамга дарж, эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулдаг ажээ. Иймд гадаад паспортын нууцлалыг чангатгаж, түүнийг хэвлэж буй байгууллагын ажилтнууд хуурамч паспорт үйлдвэрлэж гаргахаас сэргийлэх, тийм боломж олгохгүй байх үүднээс төрийн зүгээс зохих хяналт тавих шаардлагатай гэж үзэж байна. Ер нь иргэндээ олгож буй улсын чухал баримт бичгийг хувийн байгууллага үйлдвэрлэж байгаа нь зөв эсэхэд ч дүгнэлт хийх хэрэгтэй. Иргэний бичиг баримтыг хэвлэх байгууллага нь /үйлдвэр/ төрийн мэдэлд иргэний бүртгэл мэдээллийн байгууллагынхаа харъяанд тусгай хамгаалалтын дор байх нь зохистой гэж үзэж байна.

Гадаадад зорчиж буй насанд хүрээгүй хүмүүст тавих хяналтыг ялангуяа тэдэнд олгож буй гадаадад зорчих баримт бичгийн бүрдэл, хүчин төгөлдөр байдалд тавих хяналтыг сайжруулах нь гадаадад зорчих нэрийн дор хүүхэд худалдаалагдахаас сэргийлэх нэг чухал нөхцөл мөн учир хүүхдэд олгож буй баримт бичгийн талаар судалгаа дүгнэлт хийх хэрэгтэй байна.

Тэдэнд дээр дурьдсан 3 төрлийн баримт бичиг олгодог бөгөөд эдгээрээс эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийнх нь паспортонд зургийг нь нааж баталгаажуулах, эсвэл паспортонд нь хавсралт үнэмлэх олгох гэсэн баримт бичгүүд нь хуурамчаар үйлдэгдэхгүй гэх нууцлалын баталгаатай эсэх нь эргэлзээтэй байна.

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах болон Иргэний бүртгэлийн тухай холбогдох хуулиудад өөрчлөлт оруулж төрсний гэрчилгээ болон гадаад паспортын үйлдвэрлэл, нууцлалыг сайжруулж, эдгээр баримт бичгийг хуурамчаар үйлдэх боломжийг хаах, насанд хүрээгүй хүн гадаадад зорчиход нь үндэсний гадаад паспорт олгодог болгох, гадаадад зорчсон насанд хүрээгүй хүмүүс эргэж ирсэн эсэхийг нь хянадаг тогтолцоог бий болгох шаардлагатай.

### **Долоо. Хараа хяналтгүй хүүхдийн талаархи хууль тогтоомж:**

Манай улсын нийслэл Улаанбаатар болон бусад төв суурин газарт хараа хяналтгүй “тэнэмэл амьдралтай” хүүхдүүд цөөнгүй байгаа нь худалдаалагдах, бэлгийн мөлжлөгт өртөх өндөр эрсдэлийг дагуулж байна.

Нийслэлийн Цагдаагийн газрын харъяа хүүхдийн халамж үйлчилгээний төвд 2006 онд 1128, 2007 онд 1067, 2008 онд 990 гаруй хараа хяналтгүй хүүхэд албадан саатуулагдаж, төрийн болон хувийн байгууллагын санхүүжилтээр үйл ажиллагаа явуулдаг 45 хүүхдийн асрамжийн байгууллагуудад 1450 орчим хүүхэд хүмүүжиж, 50-60 орчим хүүхэд траншейнд амьдарч байна.<sup>3</sup> Эдгээр хараа хяналтгүй хүүхдүүдийг бүртгэлд хамруулах, худалдаалагдах бэлгийн мөлжлөгт ашиглагдахаас сэргийлэх талаар хууль эрх зүйн харилцааг зөв зохицуулах, энэ талаар байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй байна. Эдгээр хүүхдүүдийн талаар нэгдсэн тоо бүртгэл, хяналт байхгүй байна.

Иймээс Нийслэл Улаанбаатар хотод байгаа хараа хяналтгүй хүүхдийн нэгдсэн бүртгэл, судалгаатай, бичиг баримттай, овог нэртэй болгож, хөдөлгөөнд нь хяналт тавьдаг тогтолцоог бий болгох, дээрхи ажлыг Нийслэлийн Цагдаагийн газрын дэргэдэх Халамж үйлчилгээний төвд хариуцуулж, бусад хүүхдийн халамжийн газрууд өөрсдийн асрамжинд байгаа хүүхдийн шилжилт хөдөлгөөнийх нь талаар тус тивд мэдээллэдэг журмыг тогтоох, уг журмыг Орхон, Дархан-уул, Дорнод, Дорно-говь зэрэг аймгуудад нэгэн адил тогтоох шаардлагатай.

<sup>3</sup> Хүний Эрхийн Үндэсний Комиссын илтгэл. 2008 он.

**Найм. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаар:**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг /ГХУСТХ/ 1997 онд баталжээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд Хууль зүйн сайдаар, аймаг, нийслэл, сум, дүүрэгт түүний Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргаар толгойлуулсан орон тооны бус зөвлөл зохицуулна гэж заажээ. Энэ хуулийн зорилт нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын ерөнхий зохион байгуулалт, үндсэн чиглэл, төрөл, арга хэлбэр, энэ талаар төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбоотой харилцааг зохицуулахад оршдог байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудал бол улс орны иргэдийн аюулгүй байдал, иргэдийн эрх, эрх чөлөө, иргэд, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хамгаалж хангахад онцгой чухал ажил юм. Гэтэл энэ ажлыг хариуцсан алба орон тооны бус байна гэдэг улс, иргэдийн эрх ашигт нийцэхгүй байна. Энэ албыг орон тооны болгож, эрх хэмжээг нь нэмэгдүүлэх, үйл ажиллагааг нь тодорхой болгох шаардлагатай.

Хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгтэй холбоотой хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажилд иргэдийн мэдээлэл онцгой ач холбогдолтой. Гэвч энэ хуулинд гэмт хэргийн талаархи мэдээллийг иргэдээс төлбөртэй авахаар заасан боловч мэдээлэл өгөгчийн тухай мэдээллийг нууцлах, түүнийг хамгаалах асуудал сайтар тусгагдаагүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14-р зүйлд: Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэн тухай мэдээллийг цагдаагийн байгууллага иргэдээс төлбөртэй авч болно. Онц хүнд ба зохион байгуулалттай гэмт хэргийн талаархи мэдээллийн төлбөрийг мэдээлэгчтэй тохиролцон тогтоож болно. Цагдаагийн байгууллага мэдээллийн нууцыг чанд хадгалж, шаардлагатай бол мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах үүрэгтэй гэжээ.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь нууц далд аргаар, зохион байгуулалттайгаар, хил дамнан үйлддэгддэг ноцтой гэмт хэрэг тул энэ хэргийн талаархи мэдээлэлд онцгой ач холбогдол өгөх нь зүйтэй. Хуулийн 14-р зүйлийн 14.4. дэх хэсгийн “онц хүнд” гэсний өмнө “хүн худалдаалах” гэж нэмж оруулах шаардлагатай байна.

Мөн зүйлийн 14.5. дахь хэсэгт “ мэдээллийн нууцыг чанд хадгалж” гэдэг нь өрөөсгөл бөгөөд зүй нь мэдээллийн нууц биш харин мэдээлэл өгсөн хүний хувийн байдал /овог, нэр, хаяг, эрхэлдэг ажил, утас болон шуудангийн хаяг/ ын талаархи мэдээллийг чандлан нууцлана гэж тодруулж, улмаар мэдээллийг хэргийн материалд оруулахгүй гэж өөрчлөх нь зүйтэй байна. Хэргийн талаархи мэдээлэл нь нууц биш харин мэдээлэгчийг нууцалж, хувийн аюулгүй байдлыг нь хангах үүргийг зөвхөн шаардлагатай тохиолдолд бус бүх тохиолдолд төр хүлээх ёстой. Ийм шаардлагыг хангахгүй бол иргэн хүн аюултай алхам хийж эрсдэлд орохыг хүсэхгүй.

**Ес. Гадаадад ажиллах хүч гаргах болон гадаадаас ажиллах хүч, /мэрэгжилтэн/ авах тухай хуулийн талаар:**

Монгол Улсын иргэдийн гадаадад сурч, ажиллаж, амьдрах гэсэн хүсэл сонирхол нь ашиг хонжоо хичээсэн хүмүүсийн шуналыг өдөөж, худалдаалагдах нэг нөхцөл нь болсоор байна. Манай иргэд өндөр цалинтай ажилд оруулж өгнө гэсэн хуурамч зард итгэж хохирсон тохиолдол багагүй байна. Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд нь зуучлах тухай асуудлыг Гадаадад ажиллах хүч гаргах болон гадаадаас ажиллах хүч, мэрэгжилтэн авах тухай 2001 оны хуулиар зохицуулж байна.

Энэ хуулиар гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрлийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр иргэд, байгууллагад олгож байхаар тогтоосон байна.

Байгууллага иргэн нь гадаадад ажиллах хүч гаргах талаар гадаадын байгууллагатай гэрээ байгуулсны дараа тусгай зөвшөөрөл хүсэх бөгөөд ингэхдээ ямар баримт бичиг бүрдүүлэхийг уг хуулийн 6-р зүйлийн 6.3. дахь хэсэгт заажээ. Энэ хэсэгт 6 зүйлийн баримт бичиг шаардсан байх бөгөөд эдгээр нь зөвхөн аж ахуйн нэгж, байгууллагад хамааралтай зүйлүүд байна. Ийм төрлийн тусгай зөвшөөрөл хүссэн иргэн, байгууллагад ямар болзол шаардлага тавигдахыг нарийвчлан зохицуулаагүй байна.

Нэгэнт иргэн, байгууллагад энэхүү тусгай зөвшөөрлийг олгохоор хуульчлагдсан тул энэ чиглэлийн хувь хүний аливаа зар мэдээлэлд иргэд хуурч мэхлэгдсээр байна.

Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд нь зуучлах тусгай зөвшөөрлийг хатуу тогтоосон тусгай шаардлагыг хангасан аж ахуйн нэгж, байгууллагад олгодог тогтолцоонд шилжиж, зохих хуулиудад өөрчлөлт оруулах, Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлүүлэхэд зуучлах тухай зарыг зөвхөн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон бусад аргаар нийтэд зарлан мэдэгдэнэ гэсэн заалтыг хуулинд тусгах нь зүйтэй.

**Арав. Донорын тухай хууль дахь механизм:**

Хүн худалдаалах гэмт хэргийн нэг гол зорилго нь хүний цус, эд, эрхтэнийг авч худалдаалж ашиг олох явдал байдаг. Манай улсад анагаах ухааны орчин үеийн ололт нэвтэрч, Монгол эмч нар хүний эд эрхтнийг шилжүүлэн суулгах мэс ажилбарыг дотооддоо хийх явдал өргөжиж байна. Эрхтэн шилжүүлэн суулгах мэс ажилбарын сөрөг үр дагавар нь хүний эд, эрхтнийг г дотооддоо худалдаалах асуудал байдаг.

Иймд эрхтэн шилжүүлэн суулгах асуудлыг хуулиар нарийн зохицуулах шаардлага гардаг. Энэ үйл ажиллагааг донорын тухай хуулиар зохицуулдаг. Донорын тухай хуулиар шилжүүлэн суулгах эд эрхтэнг аль болох амьгүй донороос авах, амьд донороос эрхтнийг авахдаа ихрүүд, ах, дүү, ураг, төрлийн бусад эрүүл хүнийг сонгоно гэжээ.

Амьгүй донор болохыг тархины үхлийн эмнэл зүйн шалгуурыг баримтлан мэргэжлийн эмч нарын комисс тогтоодог байна. Амьгүй донороос эд эрхтэн авахдаа түүний өөрийн гэрээслэл, эсхүл түүний төрөл садангийн зөвшөөрлийг бичгээр авах буюу шаардлагатай бол хуулийн байгууллагын зөвшөөрлийг үндэслэнэ гэж заажээ.

Хуулийн энэхүү заалт маш бүдэг, бүрхэг байна. Төрөл садан гэж хэн болох, хуулийн байгууллага гэж ямар байгууллагыг хэлэх зэрэг нь тодорхойгүй байгаа тул амьд болон амьгүй донороос эд эрхтнийг нь шилжүүлэн суулгахдаа гэр бүлийн гишүүн /эхнэр, нөхөр, төрсөн болон үрчлэн авсан хүүхэд/, эцэг, эхийнх нь зөвшөөрлөөс гадна цагдаагийн байгууллагын зөвшөөрлийг заавал авдаг болох өөрчлөлтийг хуулинд оруулах шаардлагатай.

**Арван нэг. Зар сурталчилгааны тухай хуулийн талаар:**

Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгч нь “гадаадад өндөр цалинтай ажилд оруулна”, “виз гаргаж өгнө”, “суралцуулна”, “гадаадын хүнтэй гэр бүл болоход нь зуучилна” гэсэн зар гаргаж, худалдаалах, бэлгийн мөлжлөгт ашиглах хүнээ сонгож авдаг нь удаа дараагийн ажиглалт, судалгаагаар тогтоогдсон байна. Иймээс зар сурталчилгааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хууль бус зар сурталчилгааг хязгаарлах, хууль бус зар сурталчилгаа хийсэн байгууллага, иргэдтэй хариуцлага тооцох тогтолцоог оновчтой болгох нь хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

Зар сурталчилгааны хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих эрх бүхий байгууллагыг зөв тогтоох хэрэгтэй байна. Энэ хуулинд Монгол Улсын нутаг дэвсгэрт зар сурталчилгаанд тавих хяналтыг оюуны өмчийн улсын хяналтын алба хэрэгжүүлнэ гэж заажээ. Зар сурталчилгаа бол нийгмийн олон төрлийн харилцаатай холбоотой арилжааны шинжтэй зар сурталчилгаанаас гадна банк, санхүү, хөрөнгө оруулалт, даатгал, үнэт цаас, байгаль орчин, эрүүл мэнд, нийгмийн шинжтэй зар сурталчилгаа гэсэн маш олон салбарын мэдээлэл хамрагдаж байна. Энэ олон салбарын харилцаанд Оюуны өмчийн улсын хяналтын алба хяналт тавих боломж ч байхгүй, тэдний эрхлэх ажлын хүрээнд ч багтахгүй. Зар сурталчилгааны зохицуулж байгаа харилцаа, чиглэлийг харгалзан төрийн хяналтын байгууллагууд чиглэл чиглэлээрээ хяналт тавьдаг болгож, тусгай зөвшөөрөл шаардагдах ажил, үйлчилгээний зарыг зөвхөн тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр зарлаж байхаар хуульд өөрчлөлт оруулах, зар сурталчилгааны хуулийн хэрэгжилтэнд мэргэжлийн хяналтын байгууллагууд чиглэл чиглэлээрээ хяналт тавьдаг үүрэгтэй болгох, гэмт хэргийн шинжтэй /хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгт ашиглах, залилан мэхлэх гэх мэт/ зар сурталчилгааны мөрөөр цагдаа, тагнуулын байгууллага хяналт тавих үүрэгтэй болгох хэрэгтэй.

**Арван хоёр: Нэгдсэн санал дүгнэлт:**

Энэхүү судалгааг “Хүний аюулгүй байдал” төслийн санаачлагаар одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг амьдрал дээр

ажиглагдаж, анхаарал татаж буй зарим асуудлууд, зарим мэдээ, тайлантай харьцуулан үзэж хийсэн болно. Хүн худалдаалах гэмт хэрэг нь хүний амьд явах, халдашгүй, чөлөөтэй, боолчлол, хүчирхийллээс ангид байх эрхэнд халдсан хүний эрхийн ноцтой зөрчлүүдийн нэг мөн. Энэ гэмт хэргийн талаар сүүлийн жилүүдэд ярьж эхэлсэн ч, нөхцөл байдал анхаарал татахуйц хэмжээнд хүрсэн. Манай улсад хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар хууль тогтоомжуудад тусгагдсан хэдий ч түүнийг боловсронгуй болгох, зарим хуульд нэмэлт өөрчлөлт, шинчлэлт оруулах, шинээр хууль гаргах шаардлагатай болохыг судалгааны дүн харуулж байна. Иймд дараахь ерөнхий санал дүгнэлтийг дэвшүүлж байна.

1. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх тусгайлсан хууль гаргаж, энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах, хохирлыг нөхөн төлүүлэх үндсэн асуудлуудыг зохицуулах.

2. Судалгааны тайлангийн дэд хэсгүүдэд дэвшүүлсэн саналуудыг хэрэгжүүлэх үүднээс хууль санаачлах, одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлт оруулах, холбогдох байгууллагуудад энэ тухай уламжилж хамтран ажиллах шаардлагатай.

3. Энэхүү судалгааны тайланг үндэсний Аюулгүй байдлын зөвлөл, Улсын Их Хурал /нэн тэргүүнд Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо/, Засгийн Газар, хууль хяналтын байгууллагуудад танилцуулж анхаарлыг нь хандуулах.

4. Энэ төрлийн гэмт хэргийг газар авахуулахгүй таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд төрийн болоод иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн идэвхитэй хамтын ажиллагааг өрнүүлэх.

5. Хүн худалдаалах гэмт хэргийн илрүүлэлт, шалтгаан, нөхцөл, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанд кримнологийн нарийвчилсан судалгаа хийж, энэ төрлийн гэмт хэргийг шалган шийдвэрлэж байгаа практикийг сайжруулах, ажилтнуудыг мэрэгшүүлэх, сургах арга хэмжээ авах.



## АМЬД ЯВАХ ЭРХ БА ЦААЗААР АВАХ ЯЛ



**Ч.Отгончулуун**  
**ХЭҮК-ын өргөдөл, гомдол хариуцсан**  
**ахлах референт, магистр**

Орчлон хорвоо дээр хүмүүн заяаг олж төрөх нь зүүний үзүүрт тогтсон ширхэг будаатай адил хэмээн бурхан багшийн сургаальд сургасан байдаг. Хүн та хүмүүн хэмээх энэхүү эрхэм нэр алдрыг ямагт хайрлаж хамгаалж өндөрт өргөж

явах нь таны дээд үүрэг юм.

Эрт дээр цагаас эдүгээг хүртэл хууль зүйн, философын, нийгмийн шинжлэх ухаан бүхэлдээ хүний эрхийн зүй тогтол, хүн нийгмийн харилцаа хамаарал түүний шүтэн барилдлага, хүний жам ёсны болон позитив эрхийн хамгаалалтын талаар судлаж ирсэн билээ.

Амьд явах эрх- хүн бүр амьд явах эрхтэй. Энэхүү жам ёсны, хүний өөрийн угаас заяамал салшгүй эрхийг хуулиар баталгаажуулан хамгаалах нь аливаа төрийн /ямар дэглэмтэй байхаас үл шалтгаалан/ дээд үүрэг юм.

Монгол Улсын үндсэн хуулийн /1992 он/ арван зургаадугаар зүйлийн 1-т Монгол Улсын иргэн "амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиололд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно"<sup>1</sup> гэж тунхаглан заасан билээ.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 3 дугаар зүйлд "Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй"<sup>2</sup>. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 6 дугаар зүйлд "Хүн бүр амьд явах салшгүй эрхтэй. Энэ эрхийг хуулиар хамгаална. Хэний ч амь

<sup>1</sup>. "Монгол улсын Үндсэн хууль" 1992 он Тйрийн мэдээлэл сэтгүүл

<sup>2</sup>. "Хүний эрхийн түгээмэл тунхаглал" Төрийн мэдээлэл сэтгүүл 2004 он /тусгай дугаар/

насыг дур мэдэн бусниулж болохгүй. Цаазаар авах ялыг цуцлаагүй улсад уг ялыг зөвхөн онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир энэхүү Пакт болон Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчийг шийтгэх тухай конвенцийн заалтад нийцсэн бөгөөд тухайн гэмт хэрэг үйлдэх үед хүчинтэй байсан хуулийн дагуу тухайн этгээдэд оногдуулж болно. Энэхүү ялыг эрх бүхий шүүхийн эцсийн шийдвэрийн дагуу гүйцэтгэж болно”<sup>3</sup> гэж заасан нь төрийн зүгээс хүний амь насыг хууль бусаар бусниулж хэрхэвч болохгүй гэсэн утга санааг илэрхийлж байна.

Хүний үндсэн эрх болох амьд явах эрхийн гол онцлог шинж нь жирийн хүмүүсийн хоорондын харилцаанд биш, төр нийгэмтэй харилцахад буюу нэг талд нь хүн, хүмүүсийн нэгдэл нөгөө талд нь засаг төр гэсэн нарийн төвөгтэй харилцаанд хамаарч, илэрч хэрэгждэг бас зөрчигддөг байна. Энэ учраас хүний амьд явах эрх бол юуны өмнө засаг төрөөс хууль бусаар буюу дур зоргоороо хүний амь нас бүрэлгэхийг хатуу хориглоно гэж зарим судлаачид тайлбарласан байна.

Хууль зүйн шинжлэх ухаанд цаазаар авах ялын талаар Ретрибут /өр, төлбөр, цээрлэл, ял шийтгэл/, Иструменталь /багаж хэрэглэгдэхүүн/ гэсэн хоёр загвар буюу чиг хандлага бий болж хөгжиж иржээ.

Ретрибут загвар нь:

1. Цаазаар авах нь – өшөө авалт
2. Цаазаар авах нь – өр төлөөс
3. Цаазаар авах нь – ял мөн гэж үздэг бол

Иструменталь загвар нь:

1. Цаазаар авах нь – өвчнийг эмчлэх “эм тан”<sup>4</sup>
2. Цаазаар авах нь-нийгмийн хамгааллийн арга хэмжээ
3. Цаазаар авах нь – гэмт явдалтай тэмцэх онцгой арга хэмжээ гэж тус тус үздэг байна.

Цаазаар авах ял шийтгэл нь Монгол Улсад эрт дээр үеэс уламжлагдан ирсэн нь анхны бичмэл хууль болох Чингэс хааны “Их засаг хууль” болон Монгол-Ойрдын цааз, Халх журам гэх мэт түүхийн их хуулиудад тусгалаа

<sup>3</sup> “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт” мөн тэнд

<sup>4</sup> “Монгол Улсад цаазаар авах ялтай гэмт хэргийг хуульчилж ирсэн байдал ба цаазаар авах ялыг цөөрүүлэх боломж” доктор, профессор Б.Бат-Эрдэнэ 2008 он илтгэл

олсон байв. 1921 оны Ардын хувьсгалаас хойш 1926, 1929, 1934, 1942, 1961, 1987 оны Эрүүгийн хуулиудад ч мөн тусгагдсан байв.

Монгол Улс түүхэндээ анх удаа 1953 оны 8 дугаар сард Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 93 дугаар зарлигаар “Алах ялыг өөрчлөх тухай. Энх тайван цаг үед алах ялыг хойшид хэрэглэх хэрэггүй гэж үзнэ” хэмээн түүхэн дэвшилтэт шийдвэр гаргаж байсан боловч харамсалтай нь уг заалт зөвхөн 10 сар л хэрэгжиж 1954 оны 67 дугаар зарлигаар хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг санаатай алсан гэмт хэрэгт буудан алах ял хэрэглэж байхаар тогтоожээ.

Цаазаар авах ялыг хамгийн их эрсдэл дагуулсан ялын хувьд гэм буруу нь нотлох баримтаар хөдөлбөргүй тогтоогдсон тохиолдолд гагцхүү шүүх оногдуулж, оногдуулсан ялыг зохих журмын дагуу гүйцэтгэх ба эс тэгвэл засаж залруулах ямар ч боломжгүй, хүний хувь заяа нэгэнт эцэслэн шийдвэрлэгдсэн онцгой нөхцөл байдал үүсдэг бөгөөд иймд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд дээрх нөхцөл байдлыг байнга анхаарч байх нь нэн чухал байдаг. Монгол Улсад коммунист дэглэмийн үед шүүхийн бус байгууллагын хууль бус шийдвэрээр тухайн үеийн улс төрийн хэлмэгдүүлэлтийн золиос болгож үй олон хүмүүсийг хэлмэгдүүлж бөөнөөр нь буудан хороож байсан гашуун түүхийг бид мартаж учиргүй билээ.

Дэлхий нийтийн чиг хандлага сүүлийн жилүүдэд цаазаар авах ялыг халж буй улс орнуудын тоо жилээс жилд өсөн нэмэгдсээр байна. Дэлхийн улс орнуудын талаас илүү хувь нь цаазаар авах ялыг нэгэнт халсан байна. Энэ нь дэлхийн 86 улсад бүх төрлийн гэмт хэргүүдэд цаазаар авах ялыг цуцалсан, 11 улс дайны үеийн гэмт хэргээс бусад тохиолдолд цаазаар авах ял оногдуулахыг цуцалсан байна. Мөн 25 улс цаазаар авах ялыг хуулиндаа тусгасан ч хэрэглэхээ зогсоож, сүүлийн 10 гаруй жилд цаазаар авах ялын гүйцэтгэл нэг ч удаа хийгдээгүй байна. өөрөөр хэлбэл нийтдээ 122 улс цаазаар авах ял оногдуулах болон гүйцэтгэхээ зогсоож бусад 74 улсад тус ялыг оногдуулж байгаа боловч нэлээд хэд хэдэн улсад нэг жилд гүйцэтгэх тоо буурсан хандлагатай байна.

Монгол Улсын Их хурлаас 2002 оны Эрүүгийн хуульд Төр нийгмийн зүтгэлтний амь биед халдах /81.2/, Хорлон сүйтгэх /84/, Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг санаатай алах /91.2/, Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх /126.3/, Зандалчлах /177.2/, Терроризм /178.1.2/

Төрлөөр устгах /302/ зэрэг зүйл ангиудад цаазаар авах ял шийтгэл оногдуулж байхаар заасан байна.

Манай Эрүүгийн хуулийн дээрх заалтуудаас үзэхэд зарим заалт нь хүний амь нас хохироогүй үйлдэлд цаазаар авах ял шийтгэл оноож болохоор нөхцөл заасан байна. өөрөөр хэлбэл Төрлөөр устгах гэмт хэрэгт /Эрүүгийн хуулийн 302 дугаар зүйл/ бие махбодид хүнд гэмтэл учруулсан, төрөлтийг хүчээр зогсоосон, хүүхдийг бусад бүлэгт шилжүүлсэн, албадан зайлуулсан зэрэг хүний амь нас хохироогүй үйлдэлд цаазаар авах ял шийтгэл оногдуулж болохоор байна. Мөн дэлхий нийтээр цаазаар авах ял шийтгэлээс татгалзах чиг хандлагыг баримталж байхад манай улс 2008 оны 2 дугаар сард Эрүүгийн хуульд нэмэлтээр 178.1.2 гэсэн зүйл анги нэмж цаазаар авах ял шийтгэлтэй зүйл ангийг нэмэгдүүлсэн байна.

Иймд Монгол Улсын Эрүүгийн хуулиас зарим төрлийн цаазаар авах ял шийтгэлтэй зүйл ангийг багасгаж тоон үзүүлэлтийг бууруулж болох юм. үүнд: Эрүүгийн хуулийн 81.2-т Төр нийгмийн зүтгэлтнийг алсан бол гэсэн заалтыг хүчингүй болгож Эрүүгийн хуулийн 91.2-т заасан Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг санаатай алах гэсэн зүйл ангийн тохирох хэсгээр зүйлчилж шийдвэрлэх боломжтой юм.

Монгол Улсын Их Хурлаас 2003 онд батлан гаргасан Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт “Шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан цаазаар авах ялд эргэлзээ төрвөл гүйцэтгэх хугацааг 3 жилээр хойшлуулж, эцэслэн хянах журмыг хуулиар тогтооно. Хөтөлбөрийн 2.1.1.1-д “Эмэгтэйчүүд, насанд хүрээгүй болон 60-аас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял хэрэглэхийг хориглосон Эрүүгийн хуулийн заалтийг хэвээр хадгалахын зэрэгцээ уг ялыг оногдуулдаг хэргийн төрлийг цөөрүүлэх, хэтдээ ялын төрлөөс хасах чиглэл баримтлана” гэж заасан байна.

Цаазаар авах ялыг хэтдээ халах зорилтыг биелүүлэхэд Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын хоёр дахь нэмэлт протоколыг соёрхон батлах нь нэн чухал юм.

Цаазаар авах ял шийтгэлийг халахад тухайн улсын улс төрийн бодлого, эдийн засгийн нөхцөл байдал, гэмт хэргийн гаралт, иргэдийн амьжиргааны түвшин ихээхэн нөлөөлөх нь дамжиггүй юм. өнөөгийн Монгол улсад дээрх нөхцөл байдлууд хараахан төлөвшөөгүй ч аль болох цаазаар авах ялыг оногдуулах тоог цөөрүүлэх, Эрүүгийн хуулиас цаазаар

авах ял шийтгэлтэй зүйл ангийг багасгах талаар тодорхой үр дүнтэй арга хэмжээ авах нь зүйтэй юм.

Мөн Эрүүгийн хуулийн 53.3-т “Цаазаар авах ял шийгүүлсэн этгээд Монгол Улсын Ерөнхийлөгчид хандаж уучлалт хүсэх эрхтэй. Монгол Улсын Ерөнхийлөгч цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд гучин жилийн хугацаагаар гянданд хорих ялаар солино”<sup>5</sup> гэж заасан байна. Гяндангийн нөхцөл байдалд аливаа хүн 30 жилийн хугацаагаар хоригдоно гэдэг нь дэндүү урт хугацаа бөгөөд тухайн нөхцөл байдалд хүн хөдөлгөөний дутагдалд орж, ясны сүрьеэ гэх мэт өвчин тусаж, сэтгэл санааны хямралд орох зэрэг уг ял шийтгэлийг эдлэн гарч дийлэхгүй элдэв өвчнөөр нас барах тохиолдол элбэг байдаг байна. Монгол улсад гяндангийн 30 жилийн ял шийтгэлийг эдлэж дуусгасан хүн одоогоор нэгээхэн ч үгүй байна.

Иймд гянданд ял эдлэх хугацааг багасгаж эрүүгийн хуулийн хорих ялын дээд хугацаатай адилтгаж 25 жил болгох нь зүйтэй юм. Мөн хорих ангийн дотоод журамд өөрчлөлт оруулж гянданд ял эдлэж буй ялтныг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор тогтмол дасгал сургуулилт хийх, өдөрт нарлуулах цагийг уртасгах шаардлагатай байна.

Цаазаар авах ялаар шийтгүүлсэн ялтанд уучлал үзүүлэх эсэх асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 156 дугаар зарлигаар баталсан “ялтанд уучлал үзүүлэхийг хянан шийдвэрлэх журам”-аар зохицуулан энэхүү зарлиг нь Төрийн нууцын тухай хуулийн дагуу нууцын зэрэглэлд хамаарч байна. Нууцлалын зэрэглэлээс хамаарч цаазаар авах ялыг хэрхэн гүйцэтгэдэг, цогцсыг хэрхэдэг, иргэний бүртгэлээс хэрхэн хасдаг зэрэг нь өнөөдөр огт тодорхойгүй байгаа нь иргэдийн дунд уг ялын гүйцэтгэлтэй холбоотой сэжиг, таамаг цуу яриа их гарахад хүргэдэг байна.

Мөн цаазаар авах ял шийтгэлээр шийтгүүлсэн этгээдийн ар гэрийнхэн нь цогцосыг нь ч болтугай авч хүний ёсоор оршуулахыг хүсдэг ч харамсалтай нь тэд ялыг гүйцэтгэсэн огноог ч мэдэх боломжгүй юм.

Тиймээс цаазаар авах ялыг гүйцэтгэх огноог нууцалж, цогцосыг ар гэрт нь хүлээлгэж өгөхөөс татгалзаж буй гэр бүлийн гишүүдийг сэтгэл зүйн дарамтанд оруулж, хүнлэг бусаар хандахад хүргэж байгаа тул ял гүйцэтгэх огноог ил болгож цогцосыг ар гэрт нь хүлээлгэж өгдөг болох эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна.

<sup>5</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль 2002 он

**ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХИ  
НИЙГМИЙН ОЙЛГОЛТ, ХАНДЛАГА**

**Б. Уранцэцэг**  
Удирдлагын Академийн профессор,  
доктор

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (цаашид ОУХБ гэх болно)-аас гаргасан суурь 8 конвенцийн дотор албадан хөдөлмөрийг хориглон арилгахад чиглэгдсэн 29, 105 дугаар конвенцууд багтдаг. Эдгээр конвенц нь хөдөлмөрийн харилцаанд баримтлан мөрдөж хэрэгжүүлэх ёстой үндсэн дөрвөн зарчмыг агуулгаараа тусгасан билээ. Ийм зарчмуудын нэг нь албадан хөдөлмөрийг хязгаарлах улмаар устгах явдал бөгөөд дээрх хоёр конвенцоос 29 дүгээр конвенцид Монгол Улс нэгдэн орж, 2005 онд соёрхон баталсан юм. Конвенцийн агуулгаас үзвэл “албадан хөдөлмөр” гэдэг нь зөвхөн хөдөлмөрийн харилцаанд төдийгүй нийгмийн бусад харилцааны хүрээнд илрэх өргөн агуулга бүхий ойлголт ажээ. Ийм албадан хөдөлмөрийн хамгийн ноцтой уршиг бүхий нэг хэлбэр бол “хүн худалдаалах гэмт хэрэг” билээ.

ОУХБ-ын суурь конвенцид нэгдэн орсон орны хувьд Монгол Улс үндэсний хууль тогтоомжоо уг конвенцийн агуулгад нийцүүлэх, улмаар конвенцийн хэрэгжилтийн талаар тодорхой хугацаанд илтгэх, тайлагнах үүргийг ОУХБ-ын гишүүн бусад улс орны адил хүлээдэг. Энэхүү хүлээсэн үүргийнхээ дагуу илгээсэн Монгол Улсын Засгийн Газрын илтгэлийг ОУХБ зохих журмаар хүлээн авч хэлэлцэхдээ тухайн конвенцийн хэрэгжилтийн талаар хөндлөнгийн шинжээчдийг оролцуулсан судалгааг хийлгэн тайланг нь бичгээр хүлээн авч судалдаг практиктай ажээ.

Монгол Улс 2005 онд ОУХБ-ын 29 дүгээр конвенцид нэгдэн орохоос 2-3 жилийн өмнө ч “Монгол улсад албадан хөдөлмөрийн төлөв байдал” ямар байгаа талаар тандалтын судалгааг ОУХБ-аас хөндлөнгийн

шинжээчээр хийлгэсэн билээ. Харин 2009 онд ОУХБ нь Монгол Улс нэгдэн орж соёрхон баталсан 29 дүгээр конвенцтой холбоотойгоор “Монгол Улс дахь албадан хөдөлмөрийн өнөөгийн байдал” гэсэн судалгааг хөндлөнгийн шинжээчээр хийлгэсэн. Эдгээр тандалтын болон өнөөгийн төлөв байдлын судалгаа хийсэн судлаачийн хувьд миний бие “Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх нийгмийн ойлголт, хандлага, төлөвшин бүрдэж буй байдал”-ын тухай энэ удаа зориглон хөндөж бичиж байна.

2003 онд хийгдсэн тандалтын судалгааны үед хүн худалдаалах гэмт хэргийн талаар Монголын нийгэм ямар нэг ойлголтгүй байсан гэж үзэж болохоор байсан. Хүн худалдаалах гэмт хэргийн нэг илрэл болох охид бүсгүйчүүдийг хил дамнуулан худалдах явдал манай орны хувьд шинэ үзэгдэл байв.

Тоталитари дэглэмтэйгээр олон арван жилийн турш оршиж байсан Монгол Улсад 1990-ээд оноос хэрэгжсэн ардчилсан өөрчлөлтүүд нь өмнө байгаагүй шинэ олон үзэгдэл бий болгосон. Монгол Улс гадаад харилцаагаа өргөжүүлж иргэд нь гадаадын улс оронд чөлөөтэй зорчин явах эрхтэй болсон зэрэг олон улсын харилцааны хүрээн дэх өөрчлөлтүүд нь хил давуулж хүн наймаалах гэсэн бараан үзэгдлийг ч бас дагуулсан. Өмнө нь байгаагүй энэхүү сөрөг үзэгдлийн талаар Монголын нийгэм нэг хэсэгтээ ойлголтгүй байсан зэрэг нь эдүгээ нийгмийн хэмжээнд айдас, гайхшрал төрүүлсэн хуурч мэхлэх замаар хүн худалдаалах гэмт хэрэг газар авсан байж болохуйц нөхцөл байдлыг бүрдүүлэхэд ч зохих хэмжээгээр нөлөөлсөн гэх үндэстэй юм. Монголын нийгэмд өнөөдөр тулгамдсан гол асуудлын нэг болох ядуурал, ажилгүйдэл ч хүн худалдаалах, биеийг нь албадан үнэлүүлэх гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж байна. Иймд эдгээр гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгах, гэмт хэргийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэхэд гэмт хэргийн талаар нийгэм олон түмэнд зөв ойлголтыг төлөвшүүлж эдгээрээс сэргийлэх, тэмцэхэд тэдний анхаарлыг хандуулж, хүчийг ашиглах зэрэгт нөлөөлөх, үүний тулд гэгээрүүлэх явдал ихээхэн ашиг тустай гэж үзэж байна. Хүн худалдаалах, биеийг нь албадан үнэлүүлэх гэмт хэргийн талаар олон түмэн ямар төсөөлөл, ойлголттой байгааг тодруулах, үүнийг судлах нь нийгэмд аюултай уг үзэгдлээс сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх аль ч шатанд чухал ач холбогдолтой.

Хүн худалдаалах гэмт хэргийн талаар Монголын нийгэмд зөв ойлголт төлөвшүүлэх, хүмүүсийн сэтгэл, оюун санаанд түүний хор уршиг, үр дагаврыг ухамсарлуулж мэдрүүлэх нь хэд хэдэн талын учир холбогдолтой юм. Юуны өмнө, энэ төрлийн гэмт хэрэгт өртөж болзошгүй хэсэг (ядуу, ажилгүй гэх мэт)-ийнхэн, эцэг эхчүүд болон хүний эрхийг хангаж хамгаалах зорилгоор байгуулагдан ажиллаж буй төрийн ба төрийн бус байгууллагынханд нэгдмэл ойлголт бий болгон, гэмт хэргээс сэргийлэх, гэмт үйлдлийг таслан зогсоох, гэмт хэрэгтнийг илрүүлэх, хохирогчид анхаарал халамж тавихад тэдний анхаарлыг хандуулахад чухал нөлөөлнө. Мөн бусад иргэд ч энэ гэмт хэргийн талаар зөв ойлголттой болсноор нийт нийгмээр энэхүү сөрөг үзэгдлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд нэгдэн хандах нь чухал юм. Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчид анхаарал тавих түүнд сэтгэл зүйн дарамт учруулахгүй харин дэмжихэд ч зохистой нөлөөлнө.

Хил давуулан худалдагдаж, хүчээр биеэ үнэлүүлэх болсон эмэгтэйчүүдийн талаар нийгэм өмнө нь буруу ойлголт хандлагатай байсан. Тэднийг өөрсдийн дураар, хүсч гарсан “биеэ үнэлэгч” мэт үзэж ойлгодог байснаас сэтгэл зүйн дарамт үүсч, хэргийн хохирогчийн зовлон, хохирол асар их нэмэгддэг, хэргийн талаар тэд зохих байгууллагад байтугай өөрийн ойрын хүмүүстээ ч мэдэгдэх сонирхолгүй байдаг. өмнө хийж байсан тандалтын судалгааны явцад цагдаагийн байгууллага Япон Улс руу охидыг биеийг нь үнэлүүлэх зорилгоор гаргадаг хоёр компанийг 2001 онд илрүүлсэн бодит тохиолдол хөндөгдөж байв. үүнд эрүүгийн хэрэг үүсгэн шалгах явцад хохирогч нараас гомдол гаргаагүй гэсэн шалтгаанаар хэрэг бүрдэж чадахгүй байгаа тухай тусгаж байсан.<sup>1</sup> Энэ нь уг хохирогчид өөрсдөө гомдолгүй байгаагаасаа бус, бүх хохирол зовлонгоо бие сэтгэлээрээ үүрч, дээр нь нэмж хохирохгүй гэсэн бодолтой нь үндсэндээ холбоотой байсан юм. Харин одоо энэхүү гэмт хэргийн талаар нийгмийг гэгээрүүлэх, ойлгуулах үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага зохих хэмжээгээр явуулах болж албан ба албан ёс сургалт, хэвлэл, мэдээллийн хэрэгсэлийг энэ зорилгод ашиглах болсон. Яг энэ чиглэлээр Монгол улсад сүүлийн хоёр, гурван жилд мэдэгдэхүйц ахиц гарсан нь энэ удаагийн судалгаагаар ажиглагдсан.

<sup>1</sup> Монгол улс дахь албадан хөдөлмөрийн төлөв байдал. (тандалтын судалгаа) тайлан. УБ., 2004. 24 дэх талд



Хүн худалдаалах, бусдыг албадан биеийг нь үнэлүүлэх төрлийн гэмт хэргийн талаар нийгэмд тодорхой ойлголт бий болгож түүнээс сэргийлэх, тэмцэхэд олон түмнийг чиглүүлсэн шинжтэй үйл ажиллагаа хэд хэдэн төрөл, чиглэлээр хэрэгжиж байна.

Төрийн байгууллагуудын зүгээс хийж буй тодорхой үйл ажиллагаа, Төрийн бус байгууллагуудаас явуулж буй үйл ажиллагаа аль аль нь энд багтах юм. Мөн энд дээрх байгууллагуудаас сурталчилгааны болон сургалтын мөн мэдээллийн, судалгаа шинжилгээний шинжтэй хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нилээд зонхилох байр суурийг эзэлж байгааг дурьдах нь зүйтэй. Ийнхүү дээр дурьдсан чиглэл, төрлөөр явагдаж байгаа үйл ажиллагаа нь тус тусдаа төдийгүй ихэвчлэн хамтарсан хэлбэрээр хэрэгжиж байгаа нь бас ажиглагдсан.

Төрийн байгууллагуудаас хүн худалдаалах, биеийг нь зохион байгуулалттай албадан үнэлүүлэх гэмт хэргийн чиглэлээр нийгэмд зөв ойлголт төрүүлж төлөвшүүлэхэд чиглүүлэн явуулж буй үйл ажиллагаа нь цагдаа, шүүх зэрэг хуулийн байгууллагуудаас олон нийтэд хандан хэвлэл, мэдээллийн хэрэгслээр, дамжуулан эдгээр хэргүүдийн талаар хийсэн мэдээлэл, сэрэмжлүүлгийн хэлбэрээр ихэвчлэн илэрч байна. Ялангуяа өдөр тутмын сонин болон телевизүүдийн мэдээний цаг, цагдаагийн байгууллагаас тусгайлан бэлтгэж цацдаг мэдээллийн цагаар эдгээр хэргийн илрүүлэлт болон хэргийн шалтгаан, урьдчилан сэргийлэх талаар мэдээлэх нь тогтмолжсон. Мөн хэвлэлийн хурал дээр мэдээлэх, сурвалжлагчдад ярилцлага өгөх зэргээр энэ асуудал олон нийтэд зохих хэмжээгээр хүрч байгаа юм. Түүнчлэн төрийн зохих байгууллагад ажиллаж байгаа хуульч, судлаачид энэ төрлийн гэмт хэргийг зориуд судлаж буй нь эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд төдийгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хүрээнд явагдах үйл ажиллагаа, хууль боловсруулах үйл ажиллагаа ч шинжлэх ухааны үндэстэй хэрэгжихэд зохистой нөлөөлнө гэж үзэж байна.

Эдүгээ хүн худалдаалах гэмт хэргийн талаар хуульчид, түүн дотроо практикт ажиллаж байгаа хуульчид тухайлан судлаж, гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, оногдуулж байгаа ял шийтгэл түүний үр нөлөө зэргийг мэргэжлийн үүднээс иж бүрэн судлах болж судалгааныхаа үр дүнгээс нийтийн хүртээл болгож байна. Мөн бусад хүмүүс ч хүн худалдаалах гэмт хэргийн талаар онол, практикийн шинжтэй өгүүлэл бичиж сонин сэтгүүлд

асуудал дэвшүүлсэн, хөндсөн бүтээлүүдийг нийтлэх болжээ. Харин 2006 оноос өмнө хүн худалдаалах гэмт хэргийн талаар нийтэд зориулагдсан мэдээлэл, энэ тухай тодорхой өгүүлэл зэрэг материал олддоггүй, ер нь нийтлэгдэж хөндөгдөж бичигддэггүй байв. Тэгвэл одоо байдал өөрчлөгдсөн гэж үзэж болох юм.

Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллагууд гол үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь өнгөрсөн хугацаанд Монголын нийгэмд төлөвшиж буй хүн худалдаалах гэмт хэргийн талаарх зөв ойлголт, хандлагаар нотлогдож байна.

Хэвлэл, мэдээллийн ажилтнууд түүн дотроо сэтгүүлчид олон нийтэд зориулж гаргадаг хэвлэлүүдэд хүн худалдаалах гэмт хэргийн тухай ихээхэн хөндөж бичих болжээ. Зөвхөн 2008 онд гарсан цөөн тооны тодорхой сонингуудад хийсэн судалгаанаас үүнийг мэдэж болох юм. Жишээ болгон Монголчуудын олонхи нь уншдаг “өдрийн сонин”, “Нийгмийн толь” гэсэн хоёр сонинд нийтлэгдсэн нийтлэлүүдээс хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдээллийг шүүн түүвэрлэж авснаа энд дурьдая. 2008 оны 1 дүгээр сараас эхлэн 3 сарын хугацаанд “өдрийн сонин”-д нийт 8 удаа хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдсон нийтлэл хэвлэгдэн гарчээ. Үүнээс 3 нийтлэлийг нэг сэтгүүлч (Б. Цэцэгдэлгэр) бичсэн байгаагаас үзвэл сэтгүүлчид энэ чиглэлээр их анхаарч байгаа төдийгүй дагнаж мэрэгших хандлага ч бий болж байж болох юм. Мөн 2007 онд “Нийгмийн толь” сонинд уг асуудлаар нийт 6 сэтгүүлчийн бичсэн нийтлэл гарч байв. Энд Н. Санаа гэдэг сэтгүүлч гадаадад худалдагдаж буй иргэдийн тухай хоёр удаа нийтлэл бичсэн байна. Сонин хэвлэлүүдэд сэтгүүлчдийн бичиж байгаа өгүүлэл, нийтлэлүүд нь дотроо сурталчилгааны, мэдээллийн, асуудал дэвшүүлсэн, олны анхаарлыг хандуулсан гэсэн хэд хэдэн өөр зорилго бүхий байгаа юм.

Сурталчилгааны шинжтэй өгүүлэл, нийтлэл нь иргэдэд хүн худалдаалах болон бусдын биеийг албадан үнэлүүлэх гэмт хэргийн тухай ойлголтыг бий болгож, түүнээс сэргийлэх, эдгээрт өртөгдөгсдийн эрх ашиг сонирхлыг хангаж хамгаалахад нийтээр анхаарахад олныг хандуулах зорилготой байна. Тэгвэл мэдээллийн шинжтэй нийтлэлүүд нь дурьдсан төрлийн гэмт хэрэг байж болзошгүй тийм шинж бүхий үйлдлүүд гарч буйг олонд мэдэгдсэн, хууль хяналтын байгууллагынхны анхаарлыг хандуулахад чиглэгддэг. Үүнээс гадна Эрүүгийн хуулийн 113, 124 дүгээр

зүйлүүдэд буй хүн худалдаалах болон бусдын биеийг албадан үнэлүүлэх гэмт хэргийн талаар нийтэд сурталчилсан мэдээллийг хэвлэл нийтлэлийн хэрэгсэл, ялангуяа сонин сэтгүүлүүдэд нилээд хөндөж, бичиж байгаа нь эдгээр гэмт хэргийн талаар иргэдийн эрх зүйн цэгц, зөв ойлголт мэдлэгийг бий болгох, төлөвшүүлэхэд тус дөхөм болж байна. Эрүүгийн хуулийн 113, 124 дүгээр зүйлүүдийн талаар, эдгээрт орсон өөрчлөлтүүдийн тухай уншигчдад хэд хэдэн нийтлэл, мэдээлэл 2008 онд бичигдсэн. Жишээ нь, сэтгүүлч Ж. Наран УИХ-аас Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг баталмагц “өглөөний сонин”-ны 2008 оны 02 сарын 20-ны 033 (356) дугаарт “Хил давуулан хүн худалдсан тохиолдолд 10-аас дээш жилийн ялаар шийтгэнэ” гэсэн өгүүллийг бичиж нийтлүүлжээ. үүнтэй хамт “өнөөдөр” гэх мэт хэд хэдэн сонинд Эрүүгийн хуулийн 113, 124 дүгээр зүйлүүдэд оруулсан нэмэлт өөрчлөлтийн талаар мэдээлэл нийтлэгдсэн байна. Үүнээс гадна, хэвлэл мэдээллийн хэрэгслийн, хүч нөлөө нь хүн хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх таслан зогсоох хүрээнд иргэд, төрийн ба төрийн бус байгууллагууд хамтран ажиллахад ихээхэн тус нэмэр болж байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн энэхүү хүчтэй шинжийг ашиглан Монгол дахь хүний наймааны асуудалд олон нийтийг, төрийн байгууллагуудыг хандуулж чадаж байгаа билээ. 2008 оны 2 дугаар сарын 20-23-ны хооронд үндэсний өдөр тутмын хэд хэдэн сонинд “Охид, бүсгүйчүүдийг гудамжнаас хулгайлан худалдаж биеийг нь үнэлүүлж байгаа тухай мэдээллүүд<sup>2</sup> нилээд олон тоогоор нийтлэгдэж байв. Энэ нь эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нэгэн төрийн бус байгууллагад хохирогч охины эх хандсанаар уг байгууллагынхан асуудлыг тавьсан нийтэд хандан тавьсантай холбоотой байв. Улмаар 2008 оны 2 дугаар сарын 19-ны өдөр төрийн бус хэд хэдэн байгууллага нэгдэн хүн худалдаалах наймааны эсрэг нэгдэн тэмцэх болсноо мэдэгдэн хэвлэлийн бага хурал хийлгэжээ. 2008 оны 2 дугаар сарын 21-нд Ардчилсан Намын дэргэдэх Ардчилсан Эмэгтэйчүүдийн холбооны санаачлагаар Цагдаагийн ерөнхий газар, Эрүүгийн цагдаагийн газар зэрэг хуулийн байгууллагын, мөн хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын болон Азийн сангийн төлөөлөгчид

<sup>2</sup>Үндэсний өдөр тутмын хэвлэл “өнөөдөр” сонин. 2008-02-20, №40 (3303). Нийгмийн толь сонин. 2008-02-22, 044 (447) гэх мэт.

оролцон “Хүн худалдаалах гэмт хэрэг Монголд” гэсэн сэдвээр уулзалт ярилцлага зохион байгуулжээ.<sup>3</sup> Оролцогчид хүн худалдаалах гэмт хэргийн өнөөгийн байдлыг төдийгүй түүнтэй тэмцэх, сэргийлэхэд хамтран ажиллахаар санал нэгдсэн байна. Яг энэ үеэр Улсын Их Хурлын Төрийн байгуулан, аюулгүй байдлын байнгын хорооны дарга Б. Мөнхтуяа сэтгүүлчидтэй уулзан хорооны ажлын талаар мэдээлэхдээ охид бүсгүйчүүдийг худалдаж байгаа талаар мэдээлэл ирдэг, энэ асуудалд хяналт тавьж ажиллана гэсэн.<sup>4</sup> Ийнхүү хүн худалдаалах гэмт хэргийг олон нийтээр хэлэлцэх үйл явцад улс төрийн зарим хүчин ч өөрийн байр суурийг илэрхийлж хамтран тэмцэхээ илэрхийлж байв.

Олон нийтийн дунд хүн худалдаалах гэмт хэргийн хор уршгийн талаар ийнхүү нэгдмэл ойлголт төлөвшиж эхэлсэн, хамтран ажиллах эхлэл суурь бий болсны үр дүн нь эдүгээ олон хэлбэрээр илэрч байна. Тухайлбал, уг асуудлаар хүмүүс өөрсдийн үзэл бодлыг хэвлэлээр дамжуулж илэрхийлэх нь нэмэгдсэн. Үүнийг сонин хэвлэлд нийтлэгдэж буй мэдээ баримтууд нотлох юм. Мөн зарим сонин хэвлэлд хүн худалдаалах гэмт хэргийн талаар, ийм үйлдэлд өртөж болзошгүй нөхцөл байдлыг анхааруулж, сэрэмжлүүлсэн шинжтэй булан нийтлэх болсон, зарим телевиз тусгай нэвтрүүлэг бэлтгэн үзэгчдэд хүргэх мөн энэ асуудлаар ТВ шууд ярилцлага хийх болжээ. Эдгээр нь хүн худалдаалах, албадан биеийг нь үнэлүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоход олон нийтийн зохистой оролцоог төлөвшүүлэхэд ихээхэн үр дүнтэй юм. Зөвхөн 2008 оны 7, 8 сард гэхэд л энэ тухай тусгай нэвтрүүлэг TV9, Ийгл TV-ээр<sup>5</sup> цацагджээ. Харин цаашдаа хэвлэл мэдээллийн ажилтнууд, сэтгүүлчдэд хүн худалдаалах гэмт хэргийн талаар эрх зүйн цогц сургалт явуулах үндсэн дээр олон нийтэд мэдээлж буй мэдээлэл баталгаатай, үндэслэлтэй байх нөхцлийг бүрдүүлэхэд нь зориуд анхаарч туслах нь зүйтэй. Ингэснээр мэдээлэл нь сенсаци үүсгэх, шалгагдаж нотлогдоогүй үйл явдлыг мэдээлж олон нийтийг дэмий цочроох, хуулийн байгууллага ба иргэд хооронд үл итгэлцэх байдал төрүүлэхээс зайлсхийхэд нөлөөлнө. Гэхдээ хэвлэл мэдээллийн байгууллагуудаас олон нийтийн дунд цацаж, хүргэж байгаа

<sup>3</sup> Үндэсний өдөр тутмын сонин “өдрийн сонин” 2008-02-22, №043 (2807)

<sup>4</sup> Нийгмийн толь сонин. 2008-02-21,

<sup>5</sup> Ийгл TV-ийн 2008-08-02-ны өдрийн 10<sup>30</sup>- 10<sup>55</sup> минутад цацагдсан тусгай нэвтрүүлэг.

мэдээлэлийг тэр бүр үнэн зөв гэх баталгаатай үндэслэл байдаггүй. Энэ нь нэг талаас хэвлэл мэдээллийн ажилтнуудын мэдлэг, чадвар хангалтгүй байдагтай, нөгөө талаас хуулийн байгууллагуудад шалгагдаж буй хүн худалдаалах гэмт хэргийн байдлыг тэр бүр нээлттэй, зөв мэдээлэл өгч чаддаггүйтэй холбоотой юм. Гэвч эрүүгийн хэрэг үүсгэн шалгагдаж буй хэргийн талаар, уг хэргийг шүүх хэрхэн шийдвэрлэсэн талаар хэвлэл мэдээллийнхэнд болон олон нийтэд хамаагүй, журамгүй мэдээлэх нь өөрөө бас эрсдэлтэй нөхцөл байдлыг бий болгож болох билээ. Жишээ нь, хохирогчийн хохирсон байдлыг мэдээлэх нь түүнийг бусдад ялангуяа ойр дотны хүмст нь таниулчих бололцоог давхар агуулдаг. Эндээс хүн ам цөөхөн, бие биеэ шууд болон дам байдлаар дорхноо мэдэж таних бололцоо бүхий Монголчуудын хувьд хүн худалдах гэмт хэргийн хохирогчид эргээд нэр хүндээ хамгаалах шаардлагын үүднээс гомдлоо буцаах, хэрэгтэнтэй эвлэрэх, тэр ч байтугай байнга оршин суух газраасаа дайжих, зайлахад ч хүргэж хэрэг замхрах нөхцлийг бий болгож болох юм. Иймд хүн худалдаалах гэмт хэргийн тодорхой тохиолдлын талаар хэвлэл мэдээллийн ажилтнууд өөрсдийн мэдээ, нийтлэлд тусгаж нийтэд түгээхдээ уг хэргийг шалгаж шийдвэрлэх явцад сөрөг нөлөө үзүүлэхгүй байхад чиглэгдсэн мэрэгжлийн онцлог сургалтыг тэдэнд явуулах, зөвлөмж гаргах зэрэг бодитой ажлуудыг хэвлэл мэдээллийн байгууллага дангаараа болон хуулийн байгууллагуудтай хамтарч хийх нь зүйтэй. Мөн нийтэд мэдээлэхтэй холбогдсон өвөрмөц зохицуулалтыг ч холбогдох хуулиудад тусгаж өгвөл зохино.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, сэргийлэхэд төрийн байгууллагуудын оролцоо чухал юм. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, сэргийлэх хүрээнд төрийн байгууллагууд ч ихээхэн анхаарч ажиллаж байна. Тэдэнд Олон улсын байгууллагууд, гадаадын зарим улс орон ч зохих дэмжлэг туслалцаа үзүүлдэг. Монгол Улсын Гадаад Харилцааны Яам, Олон улсын шилжин суурьшилтын байгууллагатай хамтран “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчдыг аврах, тэдэнд тусламж үзүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж эхэлжээ. Төслийн хүрээнд ажиллах, хамрагдах хүмүүстээ зориулж 2 өдрийн сургалт зохион байгуулсан. Гадаад харилцааны яамны төрийн нарийн бичгийн дарга О.Очиржав Өдрийн сонины 2007 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн №246 (2698) дугаарт сэтгүүлчид өгсөн мэдээлэлдээ: Хүн худалдаалах

гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар манай улс олон улсын байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай байгааг цохон хэлээд олон улсын цагаачлалын байгууллагад гишүүнээр элсэх, манайхаас чиглэн энэ төрлийн гэмт хэрэг хамгийн их илэрдэг Макао зэрэг орнуудтай гэрээ хэлэлцээр байгуулж хамтран ажиллахаар төлөвлөж байгаа гэсэн. Мөн хил дамжуулан худалдаалагдсан байж болзошгүй охид бүсгүйчүүдийн тухай мэдээлэл хуулийн байгууллагад ирдэг тул энэ асуудлыг Хууль зүй дотоод хэргийн яамны оролцоотой зохих журмын дагуу Монгол Улсын Гадаад хэргийн яам зохих улс оронд хандаж тавьдаг. Жишээ нь, Гадаад Хэргийн Яам өнгөрсөн жил Макаоод худалдагдсан байж болзошгүй “Н” гэдэг эмэгтэйн асуудлаар Макао руу хандаж тусламж хүссэн гэжээ. Энэ эмэгтэй анх Солонгос улс руу ажиллахаар тодорхой этгээдүүдээр зуучлуулан хил давж явсан ч ээждээ Макаоод худалдагдаад байгаагаа мессежээр бичиж мэдэгдсэн тухай хэвлэлд бас бичигдэж байсан юм. Цагдаагийн ерөнхий газар, нийслэлийн болон дүүргийн шүүхүүдээс хүн худалдаалах, албадан биеийг нь үнэлүүлэх гэмт хэргийн шалтгаан, нөхцлийн талаар иргэдэд сануулж сэрэмжлүүлсэн агуулга бүхий мэдээлэл, сурталчилгааг ч телевизүүдээр зохих хэмжээгээр явуулж байна. Цагдаагийн ерөнхий газраас 2008 оны 2 сард садар самуун, хууль бус мэдээ явуулахгүй байхыг чаат нэвтрүүлэг явуулдаг телевизүүдэд анхааруулж байв. Монгол улсаас гадаадын улс оронд суугаа элчин сайдын яам, консулын газрууд 2006 онд гэхэд хил давуулж хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн (Макао, БНСУ, Хятад, Израиль, Малайз гэх мэт) 50 гаруй иргэнийг эх оронд нь буцаан авчирсан гэж сонинд мэдээлжээ.<sup>6</sup> Ер нь Монголоос хүн худалдах гэмт хэрэг чиглэгдэж буй Макао, Гонконг, Малайз гэх мэт улс оронтой энэ гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр даруй байгуулах бодит шаардлага одоо нэгэнт тулгарч байгаа, тулгамдсан шинжтэй асуудалд болж байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдийг судалж байхад дээрх шаардлага үнэхээр тулгамдсан шинжтэй болохыг батлах жишээ бидэнд тохиолдсон. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Шүүхийн 2006 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 17 тоот таслан шийтгэх тогтоол бүхий эрүүгийн хавтаст хэргийн

<sup>6</sup>өдрийн сонин 2007-10-16, №246 (2698)

материалтай танилцаж байхад<sup>7</sup> Шүүгдэгч Д нь 2004 оны 6 сараас 10 сарын хооронд Монгол улсын хилийг давуулж Макао улсад 7 монгол эмэгтэйг 3500 доллараар худалдагдсан, 10 эмэгтэйг худалдахаар завдсан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутай нь тогтоогджээ. Уг үйлдэлдээ тэрээр Эрүүгийн хуулийг 113 дугаар зүйлийн 113.3 дахь заалтын дагуу 10 жил 10 хоног хорих ялаар шийтгүүлсэн. Энэ хэргийг үйлдэгч нь Макаод охидыг хүргэн өгч тэнд амьдарч буй Монгол улсын иргэн “Анна” гэгч эмэгтэйд хүлээлгэн өгдөг болохоо хүлээсэн. Анна гэгч нь энэ мэтээр охид бүсгүйчүүдийг хүлээн авч худалддаг гол этгээд, хэргийг хамтран үйлдэгч, нэг бус удаагийн үйлдэлтэй ч Монголд ирдэггүй, Макаод байнга оршин амьдардаг этгээд болох нь хэргийн материалаас ойлгогдож байв. Түүний тухай манай шүүх, цагдаагийнхан бүгд мэддэг болох нь зохих хүмүүстэй уулзан ярилцаж байх хэд хэдэн тохиолдолд бидэнд мэдрэгдсэн. Гагцхүү эрх зүйн харилцан туслалцааны тухай, гэмт хэрэгтнийг шилжүүлэх тухай гэрээг Макаотой байгуулаагүйгээс энэ этгээд хэргээ үргэлжлүүлэн үйлдсээр байгаа юм.

Хүн худалдаалах гэмт хэргийн талаар нийгэмд зөв ойлголт, хандлага төлөвшүүлэхэд төрийн бус байгууллагууд ч чухал үүрэг гүйцэтгэж байна. 1998 онд байгуулагдан хүний эрхийн чиглэлээр тодорхой үйл ажиллагаа явуулж байгаа “Хүний эрх хөгжил төв” төрийн бус байгууллага нь Монгол улсад хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тэмцэх талаар дорвитой олон ажлуудыг хийж гүйцэтгэж байна. 2000 онд уг байгууллага хүн худалдаалах гэмт хэргийн талаар анхны судалгааг хийснийхээ дараа 2002 онд “Эмэгтэйчүүд хүүхдийг худалдах гэмт хэргийн байдал Монгол улсад”<sup>8</sup> (Хүний Эрхийн Үндэсний Коммисстой хамтран НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр), 2003-2004 онд Монгол улсад хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх нь: “Асуудал ба арга зам”<sup>9</sup> судалгааг (АНУ-ын Азийн сангийн санхүүжилтээр) тус тус хийжээ. Судалгааны тайлангууд ном болон тус бүр хэвлэгдсэн байна. Уг байгууллага нь зөвхөн судалгаа хийх бус, хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирогчид өмгөөлөлийн туслалцаа үзүүлэх, хохирогчийн эрхийг хамгаалж нөхөн сэргээх хэлбэрийн

<sup>7</sup> Нийслэлийн Шүүхийн архив. 2006.

<sup>8</sup> “Эмэгтэйчүүд хүүхдийг худалдах гэмт хэргийн байдал Монгол улсад” УБ., 2002

<sup>9</sup> “Монгол улсад хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх нь: асуудал ба арга зам”, УБ., 2005

нилээд өргөн хүрээтэй үйл ажиллагаагаа явуулж байна. 2002 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн заалтад нэмэлт өөрчлөлт оруулах, Улсын Дээд Шүүхээр зохих тайлбар гаргуулах зэрэгт ихээхэн анхаарч идэвхитэй нөлөөлөл үзүүлсэн. Хуулийн байгууллагын ажилтануудыг хүн худалдаалах гэмт хэргийн асуудлаар чадавхижуулах зорилгоор мөн идэвхитэй, санаачлагатай ажиллаж байна. “Хүний эрх хөгжил төв” ТББ одоо хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа юм. Тус хөтөлбөрийн зохицуулагч хуульч Дондовтой уулзан зохих мэдээллийг бид авсан. Түүний ярьснаар йнгөрсөн хугацаанд уг байгууллага хүн худалдах гэмт хэргийн хохирогч болох 58 хүнд зөвлөгөө өгсөн, зөвлөгөө өгөх ажил 2006 оны 2 дугаар сараас эхэлсэн. Хохирогчид хууль зүйн зөвлөгөө /өмгөөлөл/ туслалцаа өгдөг. Хөтөлбөрийн хүрээнд 7 аймагт “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлийг зогсоох сүлжээ”-г Альянс төв /ТББ/, Хүчирхийлэлийн эсрэг үндэсний төв /ТББ/- тэй нийлж байгуулсан ажээ.

Хүйсийн тэгш эрхийн төв нь хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хийж байгаа төрийн бус өөр нэг байгууллага юм. Уг байгууллага нь “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгаалалын хөтөлбөр” боловсруулан хэрэгжүүлж байна. Олон улсын шилжин суурьшигчдын байгуулагатай энэ чиглэлээр хамтран ажилладаг. Хүйсийн тэгш эрхийн төв ТББ нь Хүний эрх хөгжил төв ТББ-тай хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтарч ажилладаг бөгөөд энэ хүрээнд явуулж буй үйл ажиллагааныхаа чиг үүргийг хувиарлан хэрэгжүүлдэг, хоорондоо гэрээ байгуулан ажиллаж байгаа ажээ. Хүйсийн тэгш эрхийн төв нь өөрийн байгууллагад хандсан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг “Хүний эрх хөгжил төв”-ийн хуульчдаар гүйцэтгүүлдэг ажээ. Ийнхүү уг хоёр байгууллага хүн худалдаалах гэмт хэргийн чиглэлээр хамтран ажилласнаар хүчээ нэгтгэх замаар үр дүнд хүрэх зохион байгуулалтын нөхцөл бүрдсэн гэж үзэхээр байлаа.



## ХҮҮХЭД ХӨДӨЛМӨРЛӨХ “СТОЙ ЮУ?”



Д.Солонго ХЭҮК-ын дарга

Хүүхэд хөдөлмөрлөх эсэх тухай ярихаас өмнө “хүүхдийн хөдөлмөр” гэж юу болохыг товч хөндөн өгүүлэх нь зүйтэй болов уу. “Хүүхдийн хөдөлмөр” гэдгийг бид хүүхдүүдийг байнга болон түр хугацаагаар ажил хийлгэх явдал гэж ойлгодог.

Харин эл үйлдлийг олон улсын зонхилох байгууллагууд мөлжлөгийн нэг хэлбэр хэмээн үзэж, ихэнх улс орнуудад хууль бус үйл ажиллагаанд тооцдог байна.

Хүн төрөлхтний түүхийн хуудсыг сөхөн үзвэл, 1837-1901 онд амьдарч байсан Английн хатан хаан Викториагийн эрин үед хүүхдүүд үйлдвэр, уурхайд маш олноор ажиллаж, яндан хөөлөгч хүүхдүүд хотоор дүүрч байжээ.<sup>1</sup> Эдийн засгийн хүнд нөхцөл байдлын улмаас хөдөлмөр эрхэлсэн хүүхдүүд Аж үйлдвэрийн хувьсгалд чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд Английн алдарт зохиолч Чарльз Дикенс хүртэл өрийн дарамтаас гарахаар гэр бүлийн гишүүдийн хамт 12 настайгаасаа үйлдвэрт ажиллаж байсан гэдэг. Ядуу хүүхдүүд гэр бүлийн төсөвт хувь нэмэр оруулахаар бага цалинтай, маш хүнд, аюултай нөхцөлд удаан хугацаагаар ажилладаг байв. Шалмаг, овсгоотой хүүхдийг яндан хөөлөгчөөр, жижиг биетэй хүүхдийг үйлдвэрийн даавууны дамар солиулах, мөн уурхайн нарийхан цооногоор чулуун нүүрс гаргуулах, захиа хүргэх, хивс гүвэх, гутал тослох, шүдэнз, цэцэг зэрэг хямдхан бараа заруулдаг байжээ.<sup>2</sup> Зарим хүүхдийг худалдаа, барилга дээр, мөн гэрийн зарцаар ажиллуулдаг байсан бөгөөд XVIII зууны дунд үед Лондон хотод 120,000 гэрийн зарц байжээ. Ажлын цаг маш удаан, зуны цагт барилгачид долоо хоногт 64 цаг, өвлийн цагт 52 цаг, гэрийн зарц нар

<sup>1</sup> Laura Del Col, West Virginia University, The Life of the Industrial Worker in Nineteenth-Century England

<sup>2</sup> Barbara Daniels, Poverty and Families in the Victorian Era

долоо хоногт 80 цаг ажилладаг. Мөн хүүхдийн биеийг үнэлүүлэх явдал газар авсан байжээ.<sup>3</sup> Ихэвчлэн хүүхдийг гурван настайгаас ажилд авах боловч уурхайд таван настайгаас авч, харин ажилчин хүүхэд 25 нас хүрэлгүй нас бардаг байв<sup>4</sup>. Ерөнхийдөө XVIII зууны сүүлч XIX зууны эхээр хүүхдийг дөрвөн настайгаас нь аюултай, амь насанд заналхийлсэн нөхцөл байдал бүхий үйлдвэрт ажиллуулдаг байв<sup>5</sup>. Тиймээс хүүхдийн хөдөлмөрийн эсрэг хамгийн анхны эрх зүйн зохицуулалт бүхий “үйлдвэрийн тухай хууль”-ийг Их Британид XIX зууны эхний хагаст батлан гаргажээ. Тухайн үед ихэнх хүүхэд насанд хүрсэн хүний нэгэн адил өдөрт 16 цаг ажиллаж байсныг 1802, 1819 онд баталсан “үйлдвэрийн тухай хууль”-иар есөн насанд хүрээгүй хүүхдийг ажилд авч болохгүй, 18 насанд хүрээгүй хүүхдийн нэг өдрийн ажлын цагийг 12-оос хэтрүүлэхгүй байлгахар тогтоожээ<sup>6</sup>. Гэсэн хэдий ч энэ нь тодорхой үр нөлөө үзүүлээгүй учир 1833 онд байгуулсан хааны хорооноос 11-18 насанд хүрсэн хүүхэд 12 цаг, 9-11 насанд хүрсэн хүүхэд 8 цаг, 9 насанд хүрээгүй хүүхэд ажиллах ёсгүй гэж тогтоожээ. Хэдийгээр энэ хэм хэмжээ зөвхөн үйлдвэрийн газруудад хэрэгжсэн боловч 1847 онд насанд хүрсэн хүн болон хүүхэд өдөрт 10 цагаас илүү ажиллаж болохгүй тухай өөр хуулийг батлан гаргахад нөлөөлсөн юм.

Аж үйлдвэрийн хувьсгалаас өмнө бүх хүүхэд ямар нэгэн хэлбэрээр ажил эрхэлж байсан. Харин Аж үйлдвэрийн хувьсгалын үеэр олон хүүхэд хөдөө аж ахуйгаас үйлдвэрийн газарт ажиллах болж, улмаар эцэг эх хүүхдээ үйлдвэр рүү биш сургуульд явуулдаг болсон нь хууль тогтоомжоос гадна орлого нэмэгдэж эхэлсэнтэй холбоотой. Нөгөө талаас хүүхдийн хөдөлмөрийг дэмждэг эрдэмтэд, хүнд хүчир ажилд нүхчин дарлагдаж байсан хүүхдүүд орчин нөхцөл сайтай үйлдвэрийн газарт ажиллах болсноор нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулсан гэж үнэлдэг. Гэхдээ хүн төрөлхтний хойч ирээдүй болсон хүүхдийн бие махбодийн хүч хөдөлмөрөөр хөгжлийг тодорхойлох нь орчин цагт өрөөсгөл бөгөөд хөдөлмөрийн зах зээл болон аж ахуй дахь хүүхдийн хөдөлмөрийг салгаж

<sup>3</sup> Labor David Cody, Hartwick College <http://victorianweb.org/history/hist8.html>

<sup>4</sup> <http://hiddenlives.org.uk/articles/poverty.html>

<sup>5</sup> E. P. Thompson, *The Making of the English Working Class*, (Penguin, 1968), pp. 366-7

<sup>6</sup> Laura Del Col, *The Life of the Industrial Worker in Nineteenth-Century England* West Virginia University

ойлгох шаардлагыг эрдэмтэд тавьсаар байна. Ер нь эрт дээр үеэс олон төрөл хэлбэрээр хүүхдийн хөдөлмөрийг ашиглаж ирсэн боловч аж үйлдвэржилтийн үр дүнд хөдөлмөрийн нөхцөл өөрчлөгдөж, ажилтны болон хүүхдийн эрхийн тухай ухагдахуун бий болсноор нийгмийн энэхүү маргаант байдал бий болжээ. Гэсэн хэдий ч одоо хүртэл дэлхийн зарим хэсэгт хүүхдийн хөдөлмөр энгийн үзэгдэлд тооцогдож, хүүхдийг үйлдвэр, уурхай, газар тариаланд<sup>7</sup> ажиллуулах, насанд хүрэгчдийн хийхээс зайлсхийдэг бохир заваан ажил хийлгэх, биеийг нь үнэлүүлэх, гар дээрээс худалдаа хийлгэх, ачаа зөөлгөх зэргээр эцэг эх нь өөрсдийн аж амьдралд туслуулсаар байна. Зарим хүүхэд жуулчдад хөтөч болох, тэднийг дэлгүүр, зоогийн газар аваачих, үйлчлэх зэрэг ажил эрхэлдэг бол зарим нь нударган зодоон хийх, гутал тослох, дэлгүүрийн бараа бүтээгдэхүүнийг зөөх, цэвэрлэх зэрэг хүнд хүчир ажлыг шахалтаар гүйцэтгэдэг. Ер нь бодит амьдрал дээр хүүхдүүд хууль хяналтын байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслээс далдуур гудамжинд худалдаа, наймаа хийх, тариалангийн ажилд зүтгэх, эсвэл орон байранд нууц байдлаар ажиллах зэрэг хууль бус явдал түгээмэл байна. Түүгээр ч үл барам тэднээр тухайн ажлыг жилийн турш амралтгүйгээр хийлгээд зогсохгүй хамгийн бага хөлс өгдөг ажээ.

Ядуу тарчиг айлын хүүхэд хүссэн, хүсээгүй хөдөлмөр эрхэлсээр байгаа билээ<sup>8</sup>. Ядуу гэр бүлийн хувьд, амь зуухын тулд хүүхдээ хөдөлмөр эрхлүүлдэг, зарим тохиолдолд хүүхэд нь цорын ганц орлогын эх үүсвэр болох явдал ч бий. 1998 оны Америкийн эдийн засгийн тойм сэтгүүлийн “Хүүхдийн хөдөлмөрийн эдийн засаг” нийтлэлд судлаач Каушук Басу, Фам Хоанг Ван нар хүүхдийн хөдөлмөрийн үндсэн шалтгааныг эцэг эхийн ядуу байдал хэмээн тодорхойлсон байна. Түүнчлэн тэд хүүхдийн хөдөлмөрийн эсрэг хууль тогтоомжоор хорио, хязгаарлалт тавьснаар эерэг үр дүнд хүрэх боломжгүйг анхааруулаад, хүүхдийн хөдөлмөрийн эсрэг хорио нь зөвхөн насанд хүрсэн этгээдийн цалин орлогыг нэмэгдүүлж, ядуу хүүхдүүдийн гэр бүлд нөхөн олговор олгох нөхцөл бүрдсэн тохиолдолд хэрэгжиж болох юм гэжээ. Одоо хүртэл Энэтхэг, Бангладеш зэрэг улсуудад хүүхдийн хөдөлмөр өргөн тархсан хэвээр байна. Судалгаагаар Энэтхэг

<sup>7</sup> “Child labour in Kyrgyz coal mines”. BBC News. <http://news.bbc.co.uk/2/hi/asia-pacific/6955202.stm>. Retrieved on 2007-08-25.

<sup>8</sup> “The State of the World’s Children 1997”. UNICEF.

улсад 70-80 сая хөдөлмөр эрхлэгч хүүхэд байгааг тогтоожээ.<sup>9</sup> Мөн зарим улс оронд 14 насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулж болохгүй хэмээн үндэсний хуулиндаа тусгасан боловч түүнийгээ биелүүлдэггүй тохиолдол их бөгөөд тухайлбал, 11 настай хүүхдүүд өдөрт 20 цаг ажиллаж, дэлхийд алдартай дэлгүүрийн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоогоор 1 цент авдаг үзэгдэл эрх чөлөөний орон гэгдэх АНУ-д байсаар байна. Хүүхдүүдийг насанд хүрсэн хүнээс хямд цалин хөлсөөр ажиллуулж болдог тул компаниуд илүү их орлого олох зорилгоор тэднийг гутал, хувцас зэрэг их хэмжээгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг газарт хүүхдүүдийг байнга ажиллуулдаг ажээ.

Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн харьцаа улс орон бүрт харилцан адилгүйгээс гадна бүс нутгаас шалтгаалан өөр өөр байдаг. Хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн тоо, хувь хэмжээг тивээр ангилан үзвэл, Ази тивд 61%, Африк тивд 32%, өмнөд Америкт 6%, Хойд Америк, Европ тивд 1% оногдож байх ба Ази тивийн ажиллах хүчний 22 хувийг, өмнөд Америкийн ажиллах хүчний 17 хувийг хүүхэд эзэлж байна.

Энэ мэтээр хүүхдийн хөдөлмөрийг ашиглах явдлыг орчин цагт хөгжилтэй улс орнууд хүний эрхийн зөрчилд тооцож, хууль бус хэмээн үздэг боловч буурай орнуудад энэхүү зөрчил оршсоор байна. Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх зорилгоор цагдаагийн байгууллага хүүхэд ажилладаг хэмээн сэжиглэсэн үйлдвэрүүдийг байнга шалгадаг ажээ.<sup>10</sup>

Нэгдсэн үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүүхдийн сангийн зүгээс эдүгээ дэлхий дээр 5-14 насны 158 сая хүүхэд ил болон далд хэлбэрээр хөдөлмөр эрхэлж байгааг мэдэгджээ.<sup>11</sup> Тэрчлэн судалгааны баримтаар өдгөө дэлхий дахинд 2-18 насны 250 сая хүүхэд хөдөлмөрлөж байгаа ажээ.<sup>12</sup> НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 32 дугаар зүйлд: “Оролцогч улсууд эдийн засгийн мөлжлөгөөс хамгаалуулах, хүүхдийн эрүүл мэнд, бие бялдар, оюун ухаан, сэтгэл санаа, ёс суртахуун, нийгмийн хөгжилд аюултай боловсрол эзэмшихэд нь саад болох ажил эрхлэхээс

<sup>9</sup> <http://www.boloji.com/society/0035.htm>

<sup>10</sup> Morendy Octora - Central Of Manpower Data & Information, 2008; Aditya Agroebie - ILO, 2008)

<sup>11</sup> [http://www.unicef.org/ceecis/pub\\_beyond\\_en.pdf](http://www.unicef.org/ceecis/pub_beyond_en.pdf)

<sup>12</sup> "Worst Forms of Child labor Recommendation, 1999". International labor Organization. <http://www.ilo.org/ilolex/cgi-lex/convde.pl?R190>. Retrieved on 2006-10-05.

хамгаалуулах эрхийг хүлээн зөвшөөрнө” гэж заасныг хүүхдийн хөдөлмөрийг ашиглах, мөлжих боломжтой гэж үзэж ойлгох явдал ч байна.<sup>13</sup>

1990-ээд оноос АНУ, Сомалиас бусад бүх НҮБ-ын гишүүн орнууд Хүүхдийн эрхийн тухай конвенцид гарын үсэг зурсан билээ. НҮБ-ын Сангийн (The United Nations Foundation) мэдэгдсэнээр, Сомали Улс 2002 онд гарын үсэг зурах үйл явц удаашралтай байгааг төрийн эрх барих байгууллага байхгүй байсантай холбон тайлбарладаг байна.<sup>14</sup> Хүүхдийн эрхийн тухай конвенц нь хууль бус хүүхдийн хөдөлмөрийг хориглосон хамгийн үр нөлөөтэй олон улсын эрх зүйн эх сурвалж мөн боловч чухамдаа хүүхдийн хөдөлмөрийг хууль бус гэж шууд тодорхойлоогүй муу талтай. Нөгөөтэйгүүр хүүхдийн эрхийн төлөө үйл ажиллагаа явуулдаг зарим бүлэг, хүүхдэд хэрэгтэй гэх үүднээс хүүхдийн хөдөлмөрийг хориглох нь хүүхдүүдийн ахархан хугацаанд олох орлого, амьдралын итгэл найдварыг давхар үгүй хийж байна, “хуулинд заасан насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөрийг хориглох нь хүний эрхийг зөрчиж, хүүхдийн боломж бололцоог бууруулж байгаа үзэгдэл. Хүүхэд зөвхөн мөнгө гэдэг зүйлийг хүсэж мөрөөдөхөөс өөр зүйл чадахгүй боллоо” гэж өөрсдийн байр суурийг илэрхийлэх явдал ч бий.

Юутай ч хөгжингүй улс орнууд хүүхэд хөдөлмөр эрхлэх насанд хүрээгүй тохиолдолд гэрийн болон сургуулийн ажлаас бусад ажил эрхлэх явдлыг тохиромжтой бус буюу мөлжиж байгаа хэлбэр гэж үздэг, ажил олгогч насанд хүрээгүй хүүхэд ажилд авахыг хориглодог<sup>15</sup> билээ. Ер нь ажил эрхлэх доод насыг улс орон бүр харилцан адилгүй тогтоосон байдаг бөгөөд “Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль”-нд 16 насанд хүрсэн хүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрнаас бусад ажилд 14 насанд хүрсэн хүнийг мэргэжлийн баримжаа, ажлын дадлага олгох зорилгоор эцэг эх, асран

<sup>13</sup> “Convention on the Rights of the Child”. United Nations. <http://www.ohchr.org/english/law/crc.htm>. Retrieved on 2006-10-05.

<sup>14</sup> [http://www.unwire.org/unwire/20020510/26300\\_story.asp](http://www.unwire.org/unwire/20020510/26300_story.asp)

<sup>15</sup> “Ratification of the Convention on the Rights of the Child”. Office of the United Nations High Commissioner for Human Rights. <http://www.ohchr.org/english/countries/ratification/11.htm>.

хамгаалагч болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр ажиллуулж болохыг заажээ.

1998 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр эхэлсэн “Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхий дахины аян”-ы уриалга эрчимтэй өрнөн дэлхийн өнцөг булан бүрт хүрч, олон нийтийн анхаарлыг татан, өргөн хүрээг хамарч, хүүхдийн хөдөлмөрийн эсрэг уриаг олон мянган хүн дэмжсэн юм. Энэхүү аян үргэлжилсээр Швейцарь Улсын Женев хотод болсон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын бага хурлаар өндөрлөсөн билээ. Аянд оролцогчдын дуу хоолой Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах тухай конвенцийн төсөл боловсруулагч нарт хүрч, тэдний үзэл бодлыг конвенцийн төсөлд тусгаж, улмаар жилийн дараа тус конвенцийг ямар ч саналын зөрөлдөөнгүй баталсан ажгуу. өдгөө дэлхийн 169 улс уг конвенцийг соёрхон баталснаас гадна Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын түүхэнд хамгийн богино хугацаанд баталсан конвенц болж оржээ. үүнд аянд оролцсон гишүүн улсууд голлох үүрэг гүйцэтгэснийг дэлхий нийт талархан тэмдэглэдэг бөлгөө.

Монгол Улсын хувьд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас баталсан “Алагчилахгүй байх (Ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай” олон улсын хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенц, “Аж үйлдвэрийн салбарт ажилд авах насны доод хязгаарын тухай” олон улсын хөдөлмөрийн байгууллагын 59 дүгээр конвенц (хянаж өөрчилсөн), “Газар доор буюу уурхайд ажиллагсдын насны доод хязгаарын тухай” олон улсын хөдөлмөрийн байгууллагын 123 дугаар конвенци, “Тэгш шан хөлс олгох тухай” олон улсын хөдөлмөрийн байгууллагын 100 дугаар конвенц, “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай” олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенци, “Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай” олон улсын хөдөлмөрийн байгууллагын 122 дугаар конвенциудад нэгдэн орж, соёрхон баталсны дээр холбогдох харилцааг зохицуулсан үндэсний хууль тогтоомжийн зохицуулалтыг тодорхой хэмжээнд нийцүүлэн өөрчилсөн боловч нийгэмд хүүхдийн хөдөлмөр оршсоор байна. Учир нь эдийн засгийн баталгаа, амьжиргааны түвшинтэй энэ нь шууд холбоотой тавигддаг асуудал билээ.

Технологийн болон эдийн засгийн өөрчлөлт нь хүүхдийг ажлын байрнаас шахаж, сургуульд явах боломжийг бүрдүүлж байна. Дэлхийн ядуу буурай улс орнуудад XIX зуунаас өвлөн авсан хүүхдийн хөдөлмөрийг олон гэр бүл өөрийн амь зуух хэрэгсэл болгож байна. Хүүхдийн хөдөлмөрийг дуусгавар болгохын тулд дан ганц хуулиар хүчлэн хориглох бус, нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдлыг харгалзан, эерэг өөрчлөлтийг хийх замаар буюу үр нөлөөтэй арга замыг сонгон ажиллах шаардлагатай байна.

Эцэст нь, АНУ-ын “Уурхайчдын барууны холбоо”-ны тэргүүн, “Дэлхийн аж үйлдвэрийн ажилчид” байгууллагыг үндэслэгч, тэргүүн Билл Хейвудын хүүхдийн хөдөлмөрийг эсэргүүцэж хэлсэн алдарт үгээр бичвэрээ өндөрлөө. “Хамгийн өөдгүй хулгай бол хүүхдийн тоглох цагаас хулгайлах явдал”<sup>16</sup> гэдгийг санана уу.

## ШҮҮХ-ХҮНИЙ ЭРХИЙН БАТАЛГАА



**Ц.Цогт**  
**Нийслэлийн Захиргааны хэргийн**  
**шүүхийн шүүгч**

Шүүх хүний эрхийн жинхэнэ баталгаа байхын тулд бодит байдлаар бие даасан, хараат бус байх явдал юм. Тиймээс “гэрээ засаад төрөө зас” гэдэг шиг шүүх, шүүгч өөрөө хамгаалагдсан байж дараа нь өөр бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах ...

Хүний нийгэм өөрөө тааварлашгүй олон төрлийн харилцааг үүсгэх, тохиолдох боломжтой юм. Тиймээс нийгмийн харилцааг зохицуулсан “хууль” нь тэр бүх байгаа болон байж болох тохиолдлуудыг бүрэн зохицуулах боломж байхгүй. Хуулийг тухайн тохиолдол бүрт оновчтойгоор хэрэглэж, үүссэн маргаан, асуудлыг шийдвэрлэхийн тулд шүүх, шүүгч байдаг.

Латин гаралтай “justice” гэсэн үг нь англи хэлэнд “шудрага ёс” гэсэн шууд утгыг агуулдаг. Эндээс үзвэл “шудрага ёс” гэсэн үг “шүүх” гэсэн үгтэй нэг утгаар хэрэглэгддэг, бие биенээс нь салгаж ойлгох боломжгүй ажээ. “Шүүх – шудрага” эсхүл “шүүх - шудрага бус” байхын тухай маргаан байхгүй харин “шүүх ажиллагаа - шудрага” эсхүл “шүүх ажиллагаа - шудрага бус” байгаа тухай хэлэлцэж, маргаан өрнүүлдэг байна.

Манайд эсрэгээрээ буюу “шүүх шудрага” байна уу “шүүх шудрага бус” байна уу гэж маргадаг, энэ нь үндэслэлтэй ч юм шиг. Учир нь хөгжингүй улсуудад шүүхийг бүрдүүлж, шудрага ёс (шудрага хууль) -ыг тогтоож, хамгаалж байх үндсэн үүрэгтэй “шүүгч” –ийг улс төрийн, эдийн засгийн, төрийн бусад эрх мэдэл, ашиг сонирхлын групп болон хувь хүний нөлөөллөөс ангид байх нөхцлийг “боломжит дээд хэмжээнд” бүрдүүлсэн байдаг.



Харин манай улсад хууль, эрх зүйгээр шүүхэд, шүүгчид тавигддаг шаардлага бол өрнөдийн орнуудын төвшинтэй яг ижил өөрөөр хэлбэл “шүүх нь бие даасан, шүүгч нь хараат бус байх” явдал, харин шүүгч энэхүү өндөр хариуцлага, үүргийг биелүүлэхэд шаардлагатай хамгаалалт хууль, эрх зүйн бусад хэм хэмжээгээр олгогдоогүй, байгаа зарим нь ор нэр төдий, хэрэгжих үндэслэлгүй сул зохицуулалттай байдаг.

Дээр дурьдсанчлан шүүхээс - бие даасан гэдгийг, шүүгчээс - хараат бус гэсэн утгыг салгаж ойлгох юм бол шүүх, шүүгч гэдэг байгууллага, ажил үүрэг утга чанараа бүр мөсөн гээнэ гэсэн үг. Шүүх, шүүгч бол Монгол улсад хүний эрх, эрх чөлөө хэрэгжихийн цорын ганц баталгаа мөн. Энэ утгаар нь авч үзвэл “гэрээ засаад төрөө зас” гэдэг шиг шүүгч өөрөө хамгаалагдсан байж дараа нь өөр бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах тухай ярих боломжтой болно.

Гэхдээ “шүүгч хараат бус байх” явдал бол харьцангуй ойлголт бөгөөд дийлэнхдээ тухайн хувь шүүгчийн төлөвлөөс хамааралтай. Хэдий тарчиг ядуу цалинтай, тал бүрийн дарамттай ч “хуулийн өмнө” өргөсөн тангарагтаа үнэнч, нийгмийн амьдрал оршин тогтнох үндэс болсон “хүний эрх” гэгч амин чухал зүйлийг хамгаалах цорын ганц амьд хэрэгслэл гэдгээ бүрэн ухамсарласан шүүгч олон байна.

Нийгмийн ихэнх хэсэг аливаа маргааныг “шүүх”-ээр шудрага шүүлгэх сонирхолтой, энэ ч жам ёсны шаардлага юм. Харин цөөн хэсэг бүлэг хүмүүс маргааныг “шүүх” –ээр өөрийн хүслээр шийдвэрлүүлэх сонирхолтой байна.

Шүүхийн журмаар иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаанд хуулийг хэрэглэх асуудлыг боловсронгуй болгоход анхаарч санал шүүмжлэлээ хэлэх үүднээс биш хэдэн илүү бор төгрөгний төлөө - мэргэжлээ, авдаг цалингаараа амьдралаа залган, ажиллаж байдаг шудрагаар ажиллаж буй шүүгчдийг эрх мэдэлтэнтэй, увайгүй этгээдүүдтэй хавсран “шороотой холих” ажлыг хийж байгаа зарим нэг хуульч нарт ч энэ бас хамааралтай.

Шүүхийн нэр хүнд гэдгийг шүүхийн шийдвэрлэсэн тодорхой нэг хэрэгтэй холбогдуулан ярих, хамааруулах, хэвлэл мэдээллээр ард иргэдэд буруу ойлголт өгөх зорилгоор цацах нь өрөөсгөл юм. Шүүх бие даасан, шүүгч хараат бус байна гэдэг бол шүүх, шүүгч нэг үзэл номлолд нэвт шингэсэн, хэн нэгэн хүн, улс төр эдийн засгийн бүлэглэлээс шууд хараат хэвлэл мэдээллээс ч, тэдний үзэл сурталын нөлөөнд автсан олон нийтээс ч, албан тушаалтан, нам, эвсэлээс ч хамаарахгүй байна гэсэн үг.

Шүүхийн шийдвэрлэсэн тодорхой хэргийн шийдвэр энэ хэрэгт ашиг сонирхолтой этгээдэд ашиггүй гарснаас хамааран, өөрт ашиггүй шийдвэр гарсны төлөө шүүхийг нөлөөлөлд орсон гэх, шүүхийн төсөв мөнгөний асуудлаар хаана, бооно гэх аястай санал, зөвлөмж газар аваад байна. үнэн сэтгэлээсээ шүүхийн болон шүүн таслах ажиллагаагаар хүний эрхийг хангах ажиллагааг боловсронгуй болгох асуудалд санаа зовсондоо биш тодорхой хэрэг маргааны шийдвэрт гомдлоо тайлах аястай нь олонх байдаг.

Бид өнөөдөр ардчилсан хуультай, тогтолцоотой улс заавал нэг тодорхой хүний хүслээр эсвэл нэг улс төрийн хүчний сонирхолд нийцүүлэн шийдвэр гаргах ёсгүй. Энэ бол өнөөдрийн шүүхийн тэр дотроо үндсэн хуулийн шүүх, захиргааны хэргийн шүүхийн хамгийн тулгамдсан асуудал мөн.

Нэр хүнд чинь унана, нэр хүндтэй чинь ярина гэх асуудалд: хувь хүний тухайд бол нэр хүндээ бодно, хичээнэ гэдэг бол бараг л хэн хүнд таалагдахын төлөө байна гэсэн үг. Харин шүүхэд нэр хүндээ бодох гэдэг юмуу хичээх гэсэн ойлголт байх ёсгүй мэт. Хэрэв шүүх нэр хүндээ бодно гэх бол хэн нэгэнд таалагдах шийдвэр гаргахыг хэлнэ.

Шүүгчийн ажил бол бусдад тус хүргэдэг ажил биш, хэзээ ч хэн ч шүүгчээс хийж буй ажил үүргийнх нь хувьд тусламж, дэмжлэг бүү хүс, бүү гуй, гуйсныхаа дараа хараал эсхүл зүхэл, бүр ерөөл ч хийгээд хэрэггүй.

2007 оны 11 дүгээр сарын 15–нд Нью-Йорк хотод саяхан АНУ–ын Дээд шүүхийн шүүгчийн албан тушаалаас тэтгэвэрт гарсан шүүгч Сандра

О'Коннор Нью Йорк муж болон бусад мужид хэрэгжиж байгаа “шүүгчийн албан тушаалд сонгууль явуулдаг” системийг “авилгын өөгшүүлсэн хэлбэр” хэмээн буруушаасан мэдэгдэл гаргажээ. Тэрээр Нэгдсэн Улсын хэмжээнд тэргүүлэх хуулийн сургуулийн нэг болох Колумбын Их сургуулийн Хуулийн сургуульд зочлох үеэрээ дээрх мэдэгдлийг хийж, энэхүү “алдаатай системийг яаралтай засаж, өөрчлөх” нь хуулийн мэргэжилтэнүүдийн өмнө тулгарч буй нэн тулгамдсан асуудал болохыг онцолж, тус сургуулийн эрдэмтэн профессорууд болон оюутнуудад хандаж энэ үйлсэд хүч нэгдэхийг уриалсан байна.

Гэтэл Монгол Улсад энэ хандлага эсрэгээрээ буюу “шүүгчийн албан тушаалд сонгууль явуулах нь зөв, Америкийн бүх муж улсуудад шүүхийн шүүгчийг сонгуулиар сонгодог” гэх мэтээр ташаарч байх юм. Америкийн Нэгдсэн Улсын бүх мужууд шүүгчийг сонгодоггүй бөгөөд тус улсын хэмжээнд шүүгчийг сонгодог энэ системээс татгалзах урт удаан жилийн аян олон жилийн өмнөөс одоог хүртэл өрнөж байгаагаас харвал “шүүгчийг сонгодог систем нь шалгарсан арга биш төдийгүй томилдогосоо долоон доор болох нь нотлогдсон”, түүнчлэн энэ талаарх хэдэн зуун нийтлэл интернетээс олж унших боломжтой байгаа. Шүүгчийг томилох эсхүл сонгохын давуу болон сул талуудыг харьцуулсан судалгаа ч олон байдаг. Тиймээс асуудлыг ул суурьтай, бодит судалгааны үндсэн дээр хөндөж тавих нь зүйтэй болов уу. Монгол Улсад шүүгчийг томилж байгаа одоогийн системийг олон улсын практикт шалгарсан хэлбэрт нийцүүлэн улам боловсронгуй болгох нь илүү оновчтой.

Жишээ нь: Техаст байрлаж үйл ажиллагаа явуулж шүүхийг хөндлөнгөөс судалдаг олон нийтийн байгууллагаас Бүгд Найрамдах Нам, Ардчилсан Намаас Техасын Дээд шүүхийн шүүгчийн 3 орон тоонд нэр дэвшиж байгаа нэр дэвшигчид нь өөр үүсвэрээс сонгуулийн компанит ажлынхаа ихээхэн хэмжээний мөнгийг цуглуулж байгаа болохыг олж тогтоосон байна.

“Олон нийтийн шүүхийн төлөө Техасчууд” гэдэг нэртэй ТББ–ын мэдэгдэж байгаагаар Бүгд Найрамдахчууд өөрсдийнхөө компанит ажлын ихээхэн хувийг бизнесийн томоохон хуулийн этгээдүүдээс бүрдүүлж авсан

байхад Ардчилсан намынхан өмгөөлөгч нараас ихээхэн хэмжээний хандив авч байгаа нь нэхэмжлэгч нарт нааштай ханддаг Дээд шүүхийг бүрдүүлэх оролдлого хийж байгааг харуулж байна гэжээ. Нийт 6 нэр дэвшигчид бүгд цуглуулсан 2.3 сая долларын 65 хувийг өөрийнх нь шүүхийн өмнө ямар нэг байдлаар хэргээ шийдүүлж байсан өмгөөлөгч, хэргийн оролцогч нараас цуглуулсан байна.

Техасын сонгогчид болон иргэд шүүхийн системд итгэх үнэмшил бага байна. Учир нь дээрх жишээ нь Техаст шударга үнэнийг худалдаж авч болдог гэдгийг харуулж байна. 2005 оноос хойш тус шүүхэд хэлэлцэгдсэн 4.295 хэргийн 40 хувь нь ямар нэгэн байдлаар нөлөөтэй шийдвэрлэгдсэн гэж дээрх ТББ мэдэгдэж байгаа бөгөөд учир нь тэдгээрийг шийдсэн 3 шүүгч нь дор хаяж аль нэг талын өмгөөлөгч эсхүл оролцогчоос тодорхой хэмжээний сонгуулийн хандив авч байсан хэмээн мэдэгдэж байна.

Харин энэ бүхэн сонгуулийн хандив тойрсон асуудалд АНУ-ын Дээд шүүх 2009 оны 6 дугаар сарын 09 –ны өдрийн Түүхэн шийдвэрээрээ<sup>1</sup> (*CAPERTON ET AL. v. A. T. MASSEY COAL CO., INC., ET AL.*) цэг тавьж, шүүгчийн албан тушаалд сонгуулиар буй хэн мөнгөтэй, эсхүл мөнгөтэй хүмүүсийн дэмжлэг авсан (шүүхийг худалдаж авдаг) нь хүрдэг бурангуй тогтолцооны сул талыг тодорхойлж өглөө.

Шүүх шударга байх нь бүх нийтийн сонирхол /үүнийг манай Үндсэн хуулийн зарчмаас харж болно/, харин зөвхөн өөрийнх нь хүслээр /буюу “тэдний шалгуураар шударга”/ байлгах сонирхол цөөнгүй этгээдэд байдаг.

Шүүмжлэлд *Сонингоор ялаа, дарга 2-ийг алж болно* гэдэг шиг байдлаар хандах нь харин аль аль талдаа халтай, үр дүнгүй шахуу, нийгмийг бухимдуулах үндэс болоод байх шиг санагдах юм. Яагаад гэвэл хэрэв тэр шүүгч сонин хэвлэлд гараад байгаа шигээ “авлигад автагдсан, нөлөөнд орсон” бол сонин, хэвлэлд бичээд ч нэмэргүй этгээд байж таарна. Яг л нөгөө алт хийсэн ч, ус хийсэн ч адил илжигний ижил. үүний оронд тэрхүү нөлөөнд оруулаад эсхүл ороод байх боломжийг бий

<sup>1</sup> <http://www.supremecourtus.gov/opinions/08pdf/08-22.pdf>

болгоод байгаа хууль, магадгүй байгууллагын дотоод журам гэх мэтийг өөрчлөх, боловсронгуй болгоход анхаарал, хүчээ тавьж ажиллах нь зүйтэй байна. Харин өөрөө хэн нэгнээс, аль нэгэн бүлэг, магадгүй улс төрийн нам эвсэл, улс төр, эрх мэдэл, эд хөрөнгийн нөлөө бүхий хувь этгээдээс **хараат хэвлэл мэдээлэл** оршин тогтнож байгаа бол тэрхүү biased (нөлөөнд автагдах, нэг талыг барьсан) хэвлэл мэдээллийн цацаж буй “мэдээлэл” нь улс орны хөгжилд, шүүхийн бие даасан байдалд ноцтой урхагтай төдийгүй үндсэн хуулийн хямралд хүргэх хортой.

Нөгөөтэйгүүр шүүхийг “хянаж, зааварлах” биш, харин бие даан, хараат бусаар ажиллахад саад бололгүйгээр хөндлөнгөөс “ажиглаж” / мониторинг хийх/ үр дүнг нь олон нийтэд мэдээлж, хэлэлцүүлж байх чиг үүрэг бүхий ХӨНДЛӨНГИЙН /нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн/ байгууллага байх хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй байна. үүнийг бий болгох хэрэгтэй шиг санагдах юм. Бидний хөгжилтэй гэж үздэг улс орнуудад, judicial watchdog эсхүл judicial watch гэх мэт нэрээр шүүх, шүүгч үйл ажиллагаагаа хуульд нийцүүлэн явуулж байгаа эсэхэд хөндлөнгийн ажиглалт хийж, сэжигтэй, алдаатай асуудлыг олон нийтэд мэдээлж, хэвлэл, мэдээллийн анхаарлыг түүнд хандуулж байдаг байгууллагууд ажиллаж хэвшсэн байдаг.

Ер нь бол Ардчилсан үндсэн хуулиас эхлэн хууль, шүүхийн байгууллагуудад шинэтгэл хийгдсээр ирсэн. Гэвч онцлог нь шинэтгэлийн тухай асуудал бол зөвхөн нэгэн хэсэгт, нэгэн үед, нэгэн цаг хугацаанд яригдах ёстой биш, харин нийгэм хөгжихийн хирээр зайлшгүй байнга хөндөгдөж яригдах сэдэв. Хэзээ эсхүл хэн шүүхийн удирдлагад байхаас үл хамааран шинэчлэл хийгдэх зүйн хэрэг, учир нь “шүүх” нийгмийн бүрэлдэхүүн болохын хувьд үргэлжид мөнхийн “хөдөлгөөн”, өөрчлөлт шинэчлэлтийг шаардаж байх болно. Зарим судлаачид (зарим нэг дэмий, хоосон, мэдлэггүй шүүмжлэгч биш) **шүүх өөрөө эрс шинэчлэгдэж амжаагүй** байгааг хэлж, сануулж байна. “Шүүхийн шинэтгэл” –ийн тухай хэлэлцэхэд ялангуяа дотор нь ажиллаж, юу нь болж, юу нь болохгүй байгааг бие, сэтгэлээрээ мэдэрч, шүүх гэсэн нэр сайн, муугаар хэлэгдэх тоолонд яс хавталзаж суудаг тэр “хүмүүс” идэвхийлэн оролцох

шаардлагатай. Тэгээд ч шүүхийн шинэчлэлийн талаар ярихаар хэн нэгний ажил үүргийг булаан хийх гэж байгаа мэт, эсхүл эсэргүү тэрслүү этгээд мэт ойлгогдох цаг улиран одсон биздээ.

Гэхдээ шүүхийн удирдлага, бүтэц, зохион байгуулалтад хийгдэх шинэтгэл нь өөрөө шүүхийн “бие даасан”, “хариуцлагатай” байх зарчмуудын хүрээнд байх ёстой. Шинэтгэл хийж байна гээд эдгээр зарчмуудаас гажиж болохгүй. Эдгээр хоёр зарчмыг Монгол гэрээр зүйрлэвэл “шүүх” оршин тогтнох тулгуур хоёр багана болох юм. Аль нэг нь доголдвол шүүх “шүүх биш” болно. Жишээ нь: шинэтгэл хийж байна гээд “хариуцлагаас мултрах, хайцаалах” боломж олгосон өөрчлөлт хуульд оруулж болохгүй, мөн шинэтгэл хийж байна гээд “хараат бус байдлыг одоогийнхоос улам дордуулсан” өөрчлөлт хуульд хийж болохгүй.

Ялангуяа тэр “шүүгчийг сонгуулиар” тодруулдаг болох тухай өнгөрсөн зууны эхэн үеийн улирсан баларсан, үеэ өнгөрөөсөн, уршигтай, урхагтай, сул талууд нь олон улс даяар ямар нэгэн дахин нотлох, турших шаардлагагүй болтлоо илэрхий болсон зүйлийг “шинэтгэл” -ийн арга, хэлбэр гэж үзэх огтхон ч шаардлагагүй. Харамсалтай нь одоо манайд бас ч үгүй боломжийн хэмжээнд олонд танигдсан хуульчид үүнийг шүүхийг шинэчлэх нэгэн боломж хэмээн “зүтгүүлж” байгаа юм, тун харамсалтай байна. Түүнчлэн аливаа шинэтгэлийг хүнээс (боловсон хүчин) эхэлж хийх нь зайлшгүй байна. Тиймээс хууль, шүүхийн байгууллагуудыг шинэчлэх, хүний эрхийн жинхэнэ баталгаа болгон хөгжүүлэх ажиллагааны хувьд **загас шиг дуугүй байх** нь оновчгүй бөгөөд загас мэт байхыг шаардах нь ч утгагүй.

**ШҮҮХ, ПРОКУРОР, ӨМГӨӨЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН  
ХАРААТ БУС, ШУДАРГА БАЙДАЛ**



**У. Эрдэнтуяа**  
**УЕПГ-ын хяналтын прокурор,**  
**Хууль зүйн ухааны магистр.**

Энэхүү нийтлэлээрээ 2003 онд НҮБ-аас батлан гаргасан “Хууль ёсыг хэрэгжүүлэхэд хүний эрхийг хангах нь: Хүний эрхийн талаар Шүүгч, прокурор, өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага” номын “Шүүх, прокурор, өмгөөллийн байгууллагын хараат бус, шударга байдал”<sup>1</sup> IY бүлгийг утгачилан орчуулж хүргүүлж байна. Уншигч та мэргэн оюундаа тунгаана уу.

**Эрх зүйт ёсыг хэрэгжүүлж, хүний эрхийг хангахад шүүх,  
прокурор, өмгөөллийн байгууллагын гүйцэтгэх үүрэг.**

Эрх зүйт ёсыг дээдэлдэг ардчилсан нийгэмд хүний үндсэн эрх, эрх чөлөөг хангах нэг арга зам бол хуулийн байгууллагын ялангуяа шүүх, прокурорын байгууллагын шударгаар ажиллах нөхцөл болсон хараат бус, бие даасан байдлыг хангах явдал юм.

Орчин үеийн үндсэн хуульт нийгэмд хуулийн байгууллагын буюу шүүх засаглалын бие даасан, хараат бус байдлыг ойлгох ойлголт нь засаглалыг хуваах онолоос улбаатай юм. Энэхүү онолын дагуу засаглалыг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гэсэн үндсэн гурван хэсэгт хуваан авч үзсээр ирсэн. Эдгээр засаглалын гурван эрх мэдлийн гинжин харилцаа тасралтгүй үргэлжилдэг ба энэ харилцааны үед аль нэг нь эрх мэдлээ урвуулан ашиглах замаар чөлөөт нийгэмд хор хохирол учруулахаас

<sup>1</sup> *Human Rights in the Administration of Justice: A Manual on Human Rights for Judges, Prosecutors and Lawyers*, UN, New York & Geneva, 2003, [www.ohchr.org/Documents/.../training9Titleen.pdf](http://www.ohchr.org/Documents/.../training9Titleen.pdf).

сэргийлэх зорилгоор засаглалууд харилцан бие биенээ хянаж, ингэснээрээ эрх мэдлийн тэнцвэрийг хадгалж өгдөг.

Шүүх, прокурорын байгууллагын бие даасан, хараат бус байдал нь тэднээс мэргэжлийн үүргээ гүйцэтгэхдээ хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн болон аливаа нөлөөнд авталгүйгээр ажиллах боломжтой байх тийм нөхцөлд хангагдах юм. Өөрөөр хэлбэл, шүүх засаглал нь зөвхөн хуульд заасны дагуу шударгаар, хараат бусаар бие даан ажиллаж байж хүний суурь эрх, эрх чөлөөг ханган ажиллаж чадах бөгөөд энэ нь хууль, шүүхийн байгууллагад олон нийтээс итгэл үзүүлэх гол тулгуур нөхцөл болно. Эндээс үзэхэд, шүүх засаглалын хараат бус байдлыг хангах явдал нь зөвхөн тэднийг өөрсдийг нь хамгаалах гэж байгаа ажиллагаа биш харин тэднийг эрх мэдлээ урвуулан ашиглахаас сэргийлэх, ингэснээрээ хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах суурь нөхцөл болж байна гэж хэлж болно.

Нөгөө талаас шүүх засаглал өөрийн дураар хэргийг шийдвэрлэх биш гагцхүү хуульд захирагдан ажиллах ёстой. НҮБ-аас баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглал<sup>2</sup> болон бусад олон улсын гэрээ, конвенцид батлагаажсан хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх талаарх хүний эрхийг хангах баталгаа нь хөндлөнгийн ямар нэг дарамт, нөлөөнд авталгүй шударгаар гаргасан шүүх, прокурорын шийдвэр гаргах үйл ажиллагаагаар хангагдана. Хуулиа баримталж гаргаагүй шийдвэрийн улмаас ял завших явдал нэмэгдэж энэ нь олон нийттэй харилцах харилцаанд ан цав, зай завсар үүсгэнэ.

Шүүгч, прокурорыг хуулийн дагуу шударгаар, хараат бусаар бие даан ажиллахад чөлөөт бие даасан өмгөөлөгч нар хамтран ажиллах замаар эрх зүйт ёсыг бэхжүүлж, хүний эрхийг хамгаалж чадна. Тиймээс НҮБ-ын Хүний эрхийн комиссын Тусгай илтгэгч нарын зүгээс Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 10-дугаар зүйлд заасан эрхийг хамгаалж ажиллахад нягт хамтран ажиллахыг ямагт зөвлөмж болгон өгсөөр ирсэн.

#### **Хараат бус, шударгаар ажиллахад учрах саад, бэрхшээл**

Бодит байдалд ийнхүү хараат бус, бие даасан байдлаар ажиллахад шүүгч, прокурор, өмгөөлөгчид хүндрэл бэрхшээл учирч байдаг. Тухайлбал,

<sup>2</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 10-дугаар зүйл, 1948. НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 217 А(III) тогтоол.



хэдийгээр улс гүрэн бүр өөр системтэй байдагч гэсэн шүүгч, прокурорын томилгооны асуудлаар дамжуулан хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын зүгээс шүүх засаглалын хараат бус, бие даасан байдалд халдах боломж бодитойгоор оршиж байдаг. Тиймээс шүүгч, прокурорыг томилохдоо хуулиар тавигдсан шаардлагаас өөр үндэслэл буюу тэдний гарал үүсэл, хүйс, арьсны өнгө, улс төрийн үзэл бодол, шашны итгэл үнэмшилд үндэслэн томилохыг олон улсын хэм хэмжээгээр хориглосон байдаг.<sup>3</sup> Түүнчлэн Словак улсад өгсөн зөвлөмжөөрөө НҮБ-ын Хүний эрхийн хорооноос “Шүүгчдийг томилохдоо Засгийн газраас санал болгож Парламентаар батлагаажуулж байгаа нь тэдний хараат бус байдалд нөлөөлөх боломжтой” байгаа талаар анхааруулжээ.<sup>4</sup> НҮБ-ын Хүний эрхийн хорооноос Судан, Боливи, Замби, Словак, зэрэг улсуудын засгийн газарт “улс төрийн болон шашны итгэл үнэмшилд нь үндэслэн шүүгчдийг томилохгүй байх”, “Ерөнхийлөгч нь заавал Парламент болон хуулийн байгууллагуудтай зөвшилцөн шүүгчийг томилох, ажлаас нь чөлөөлөх асуудлыг шийдвэрлэдэг байх” талаар зөвлөмж өгч байжээ.<sup>5</sup> Мөн Киргизстаны засгийн газарт өгсөн зөвлөмжөөрөө “шүүгчдэд 7 жил тутамд үнэлгээ өгөх, хангалтгүй цалинтай байлгах явдал нь тэднийг авилгал, хээл хахуульд автагдах явдлыг дэмжиж байна” гэж анхааруулжээ.<sup>6</sup> АНУ-д хэрэглэгдэж байгаа шүүгчийг сонгох замаар шалгаруулдаг системийг зарим мужуудад сайшаасан боловч шүүгчийг бие даасан байгууллага томилдог системийг судлан үзэх нь зүйтэй гэж зөвлөсөн байна.<sup>7</sup> Товчоор хэлбэл, шүүгч, прокурорыг томилох ажиллагаа нь Хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын онцгой бүрэн эрхийн асуудал байж болохгүй юм.

Цаашилбал, төрийн зүгээс шүүгч, прокурор, өмгөөлөгчийн аюулгүй байдлыг хангах, санхүүгийн хангалттай эх үүсвэр буюу цалин, хангамж үзүүлэх, сургах боловсруулах үүрэгтэй бөгөөд олон нийтийн зүгээс хэдийгээр шүүх, прокурор, өмгөөлөгчийн үйл ажиллагаа, гаргасан

<sup>3</sup> Шүүх засаглалын байгууллагын бие даасан, хараат бус байдлын үндсэн зарчмууд, НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 1985 оны 40/32, 40/146 дугаартай тогтоолууд.

<sup>4</sup> *Human Rights in the Administration of Justice: A Manual on Human Rights for Judges, Prosecutors and Lawyers*, UN, New York & Geneva, 2003, IY 6Yлээ, 124 дэх тал.

<sup>5</sup> Мөн тэнд.

<sup>6</sup> Мөн тэнд.

<sup>7</sup> Мөн тэнд, 125 дахь тал.

шийдвэртэй санал нийлэхгүй байгаа ч гэсэн заавал хүндэтгэх ёстой байна. Олон нийт үл итгэсний улмаас шүүх, прокурорын шийдвэрт дахин дахин давж заалдах, гомдол гаргах, улмаар үүнд төрийн зүгээс оролцож эхлэх нь нийгэмд бухимдал үүсгэх, шүүх, прокурорын хараат бус байдлыг алдагдуулах нөхцөл болно. өмгөөлөгчдөд лицензи олгох ажиллагаагаар дамжуулан тэдний чөлөөтэй бие даан хараат бусаар ажиллахад гүйцэтгэх засаглалын зүгээс нөлөөлөх боломж байна. Мөн зарим оронд эмэгтэй өмгөөлөгч нар хүчирхийлэл, доромжлолд өртөж байна.

Тодруулбал шүүх, прокурор, өмгөөлөгчийн бие даасан байдлыг хангах, хүндэтгэх явдал нь эрх зүйт нийгмийн үед засаглалын бүх хэлбэрийн үүрэг болж энэ нь улмаар хүний эрхийн батлагаа болох тухай олон улсын хэм хэмжээнд тусгалаа олсон байна.<sup>8</sup> Өөрөөр хэлбэл, зөвхөн төрийн зүгээс биш мөн олон нийтийн зүгээс шүүх засаглалын бие даасан, хараат бус байдалд халдах, аюулд оруулах боломж үргэлж оршсоор байдаг. Энэ байдлыг даамжруулбал, эрх зүйт ёс алгуурхнаар бөхөж, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хангах бололцоо хумигдахад хүрнэ.

Гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, гэрч, хохирогчийн үндсэн хууль болон бусад хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөөг хамгаалах талаар байцаан шийтгэх ажиллагаан дахь прокурорын үүрэг нь хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай олон улсын хэм хэмжээгээр баталгаажсан байдаг.<sup>9</sup> Тухайлбал, сэжигтэн, яллагдагчийн эрхийг бүдүүлгээр зөрчин хууль бус аргаар тэдний эсрэг мэдүүлгийг олж авах, ялангуяа эрүүдэн шүүх, харгис, хүмүүнлэг бус эсвэл доромжлон харьцах, шийтгэхийн эсрэг прокурор өндөр хариуцлага хүлээн ажилладаг. Ийм аргаар олж авсан бол нотлох баримтын хэмжээнд үнэлэхгүй байх, эрх нь зөрчигдсөн этгээдийн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авах үүргийг прокурор хүлээнэ. үүнтэй холбогдуулан НҮБ-ын Хүний эрхийн хорооноос Францад өгсөн зөвлөмжид мөрдөн байцаалтын явцад

<sup>8</sup> Мөн тэнд.

<sup>9</sup> Guidelines on the Role of Prosecutors, Eighth United Nations Congress on the Prevention of Crime and the Treatment of Offenders, Havana, 1990, UN Doc. A/CONF. 144/28/Rev.

хүний эрх зөрчигдөж байгаа болон мөрдөн байцаалтын хугацааг сунжруулах, удаашруулж байгаад анхаарч тодорхой арга хэмжээ авахыг санал болгосон байна.<sup>10</sup>

Түүнчлэн өмгөөлөгч нь мэргэжлийн үүргээ идэвхитэйгээр хэрэгжүүлэхийн тулд байцаан шийтгэх ажиллагаанд оролцох эрхийн баталгаанаас гадна гадны дайралт, доромжлол, хээл хахууль, бусад дарамтнаас ангид үйл ажиллагаагаа явуулах боломжоор хангагдсан байх ёстой. Олон улсын түвшинд өмгөөлөгчийг айлган сүрдүүлэх, амь насанд нь халдах, доромжлох тохиолдол цөөнгүй гарч байгаагаас Засгийн газрууд тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байгаа. Ялангуяа, Засгийн газрыг төлөөлөн ажиллаж байгаа өмгөөлөгчид улс төрийн зорилгоор дарамт шахалт үзүүлэх тохиолдол байгаа тухай НҮБ-ын Тусгай илтгэгч тэмдэглэн хэлсэн.<sup>11</sup>

**Шүүх, прокурор, өмгөөллийн байгууллагын хараат бус, шударга байдал ба түүнд холбогдох Олон улсын хууль тогтоомж**

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- Олон улсын Иргэний ба Улс төрийн эрхийн Пакт - International Covenant on Civil and Political Rights.
- Хүний болон ард түмний эрхийн тухай Африкийн тунхаглал - African Charter on Human and Peoples' Rights
- Хүний эрхийн тухай Америкийн конвенци - American Convention on Human Rights
- Хүний эрхийн тухай Европын конвенци - European Convention on Human Rights
- Шүүх эрх мэдлийн байгууллагын бие даасан, хараат бус байдлын тухай үндсэн зарчмууд - Basic Principles on the Independence of the Judiciary
- Прокуроруудын үүргийн тухай дүрэм - Guidelines on the Role of Prosecutors

<sup>10</sup> *Human Rights in the Administration of Justice: A Manual on Human Rights for Judges, Prosecutors and Lawyers*, UN, New York & Geneva, 2003, IY 6Үлэг, 149 дэх тал.

<sup>11</sup> Мөн тэнд, 152 дахь тал.

· Өмгөөлөгчдийн үүргийн тухай үндсэн зарчмууд - Basic Principles on the Role of Lawyers

### Дүгнэлт

Дээр өгүүлсэнчлэн, шүүгч, прокурор, өмгөөлөгч бол шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндсэн мэргэжлийн бүлгүүд юм. Тэдний үйл ажиллагаагаар дамжин ардчилсан нийгэм, хууль ёс, шударга ёс бэхжинэ. Тийм учраас олон улсын хэм хэмжээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу улс гүрнүүд шүүгч, прокурор, өмгөөлөгчийг Хууль тогтоох, Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, хувь иргэдээс хараат бус, бие даасан байдлаар, шударгаар ажиллах нөхцлийг хүлээн зөвшөөрөх, тийм нөхцөл боломжоор хангах үүрэгтэй байна. Нөгөө

**ГЭМТ ХЭРЭГ, ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ 35 АРГА ЗАМ**

**Өөрийн амьдарч буй суурин газарт:**

1. Олон нийтэд тулгамдсан асуудлыг зохицуулах зорилгоор хөршүүдийн харилцаанд суурилан, тухайн газар нутгийг өргөнөөр хамарч, төрийн байгууллага, алба хаагч болон бусад хувийн хэвшлийн, төрийн бус байгууллагатай **хамтран ажиллах**. Танай суурин газарт ямар зүйл хэрэгцээтэй байгааг мэдэгдэх нь тийм ч ичих асуудал биш.
2. Хот айл дахь залуучуудыг цагийн ажил, гэрийн багшийн хөтөлбөр, амралт, чөлөөт цагаа бүтээлчээр өнгөрүүлэх зэрэг олон нийтийн сайн дурын үйл ажиллагаанд оролцох боломжийг **бүрдүүлэх**.
3. Цагдаатай хамтран ажиллах хөршүүдийн холбоо буюу олон нийтийн эргүүл **бий болгох**. Таны амьдарч буй гудамж болон гэрийн ойр хавийг сайтар гэрэлтүүлэгтэй болгох арга хэмжээ авах.
4. Гэмт хэрэг гарсны дараа хариу арга хэмжээ авахын оронд урьдчилан сэргийлэхэд анхаарч, цагдаатай **хамтын холбоо байгуулах**. Хөршүүд сэжигтэй үйлдэл буюу гэмт хэргийн талаар ямарваа нэгэн айдасгүйгээр мэдээлэх боломжийг хангах.
5. Хөршүүдтэй хамтарч, ойр орчноо **цэвэрлэх**. Хүүхэд, өсвөр үеийнхэн, ахмад настныг татан оруулах. Хогийн тантан, эзэнгүй машины сэг, орхигдсон байшин нь таны болон оршин суугчид оршин суугаа газартаа анхаарал муу тавьж байгааг илэрхийлдэг. Иймд уг асуудлыг хариуцсан байгууллагад мэдэгдэж, бүх нийтээр цэвэрлэгээ хийхэд тусламж гуйх.
6. Орон нутгийн алба хаагчдаас гэмт хэрэгтэнг таны амьдран буй газраас хөршийн тусламжтайгаар барих шинэ арга зам ашиглахыг **хүсэх**.

7. Архи, тамхи, мансууруулах бодис, хүчирхийлэлгүй орчинг бий болгохоор сургуулиудтай **хамтран ажиллах**. Орон нутгийн тухайн асуудал хариуцсан алба хаагчтай хамтран, олон нийтийн амралт, чөлөөт цаг өнгөрүүлэх хүрээлэн, цэцэрлэгт архи тамхигүй цэвэр орчинг бий болгох.
8. Хөршүүдэд зөвлөгөө, зааварчлагаа өгөх, сургах болон бусад хэрэгцээтэй үйлчилгээ үзүүлдэг орон нутгийн байгууллагуудын утасны жагсаалтыг **байнга шинэчлэх, хоорондоо солилцох**.
9. **Хэрэв та гэмт хэрэг үйлдэж буйг харсан**, эсвэл гэмт хэрэг байж магадгүй гэж сэрдэж байвал цагдаад мэдэгдэх. Шаардлагатай тохиолдолд тухайн үйлдлийг гэрчлэхийг зөвшөөрөх.
10. Гэмт хэргийн хохирогч нарт зориулсан утасны шугам, хамгааллын төв, бусад туслалцаа үзүүлэх арга хэрэгслийг **судлах**.
11. Таны хөрш хүчирхийлэлд өртсөн бол энэ үйлдэл нь танд ч мөн хамааралтай асуудал болсон гэдгийг **анхаарах**. Та ч хүчирхийлэлд өртөхөд бэлэн байна гэсэн үг.
12. Хүүхдэд зэвсэг болгон ашиглаж болох, ялангуяа жинхэнэ галт зэвсэгтэй андуурах эд зүйсийг худалдан авахдаа дээр нь тоглоом гэж танигдах тэмдэгтэй эсэхийг **шалгаж үзэх**.
13. Гэртээ галт зэвсэг байлгах, хүүхдүүд тоглохдоо тоглоомон буу ашиглах, хүүхдэд хүчирхийлэлтэй нэвтрүүлэг, кино үзүүлэх, үүнийг хэрхэн шийдэж болох талаар хөршүүдийн дунд ярилцлага **хийх**.
14. Галт зэвсэгтэй холбоотой хууль тогтоомжийг **мэдэж авах**.
15. Галт зэвсэг хэрэглэхийг хориглосноор хүчирхийллээс урьдчилан сэргийлэх боломжтойг **тодруулан үзэх**. Сургууль, хууль сахиулах хүчний байгууллага, олон нийтийн эрүүл мэндийн байгууллага, номын сан, ажлын байр, шашны төв, хүүхэд хамгааллын байгууллага, бусад газрууд хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээ авах бус, харин урьдчилан сэргийлэх талаар юу хийж байгааг асуух. Галт зэвсэгтэй холбоотой хүчирхийллийн талаар ямар бодлого баримталж байгааг тодруулах. Таны оршин суугаа газар ямар эерэг нөлөө үзүүлэх боломжтойг асуух.

16. Та насанд хүрсэн этгээдээс туслалцаа хүссэн хүүхэд, залуучуудад зөвлөгөө өгөх **сайн дурын ажилтан болох**.
17. Хөршүүдийнхээ хүүхдүүдтэй уулзаж, хаана, ямар зүйл санааг нь зовоож буюу айлгадаг, хүчирхийлэлд өртсөн мэт санагддаг болох талаар **ярилцах**. Багш, сургуулийн ажилтан, хүүхэдтэй ойр ажилладаг хүмүүстэй ярилцлага хийх.
18. Хүчирхийллийн эсрэг арга хэмжээ зохион байгуулдаг байгууллагын үйл ажиллагааг хөхиүлэн **дэмжих**. Хөршүүд хэд хэдэн бүлэг байгуулан, хамтран ажиллах. Хэрэг түвэгт орох боломжтой хүүхдэд бүхий л нөөц бололцооны хирээр туслах.
19. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг (тэдгээрийн хүүхдийг) тусламж хүссэн тохиолдолд яаралтай, үр нөлөөтэй хариу арга хэмжээ авах, зохих хууль зүйн туслалцааг үзүүлэх замаар **хамгаалах**.
20. Цэцэрлэгт хүрээлэн, орчин тойрноо цэвэрлэх, дахин засварлах, сэжигтэй буюу хууль бус үйлдлийг цагдаад мэдэгдэх ажлыг **зохион байгуулах**. Тоглоом, олон нийтийн эд хэрэгслийг гамнаж, олон төрлийн арга хэмжээ зохион байгуулснаар хүмүүс цэцэрлэгт хүрээлэнд олноор ирж, хууль бус үйлдлийг зогсооход нөлөөлнө. Оршин суугчид нутгийн захиргаанаас цэцэрлэгт хүрээлэн орчин тойрны эд зүйлсийг эвдлэн сүйтгэсэн болон бусад эвдрэл гэмтлийг яаралтай засварлахыг шаардах.

### Сургуульд

1. Сургууль **сонгох**. Өргөн хүрээний хөтөлбөр, арга хэмжээ зохион байгуулан, олон нийтийг хамруулах замаар сургуульд нэгдмэл байдлыг бий болгоход сурагч, багш, сургуулийн ажилтнуудад туслах.
2. Хүүхдүүдийг нударга, эсвэл элдэв төрлийн зэвсэг хэрэглэхгүйгээр өөрийн уур хилэнг дарахад туслах хүчирхийллийн эсрэг чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэхийг **шаардах**. Үүний тулд Хүүхдийн зөвлөл, Зөрчилдөөнийг бүтээлчээр шийдье, Бид хийж чадна зэрэг сэдэвтэй хүүхдэд чиглэсэн соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах.
3. Сурагчид сургуульдаа ирэх болон явах аюулгүй замыг бий болгохоор сургууль, хуулийн байгууллагатай **хамтран ажиллах**. Саад

бэрхшээлийг тодорхойлох, арилгахад чиглэсэн хөршүүдийн хичээл зүтгэлийг дэмжиж туслах.

4. Цагийн ажил, мэргэшил олгох сургалт, өөрийгөө хөгжүүлэх дугуйлан зэрэг төрөл бүрийн арга хэмжээгээр сурагчид өөртөө давуу байдал олж авахад **туслах**.
5. Ур чадвар олгох, өсвөр үеийнхний дунд манлайлал бий болгох, зөвлөгөө өгөх, дасгалжуулах зэргээр сурагчидтай хамтран ажилладаг ажилтнуудыг дэмжих. Боломжтой бол иргэн та эдгээр арга хэмжээг өөрийн байгууллагаар дэмжүүлэх.
6. Өөрийн ажилтнуудын дунд уур хилэнгээ удирдах, дарамтаас ангижрах, зөрчилдөөнийг шийдвэрлэх зэрэг сэдвээр сургалт зохион байгуулах. Ажилтнууд сургалтанд хамрагдснаар гэртээ, сургуульдаа, оршин суугаа газартаа хүчирхийллийн эсрэг уур амьсгалыг бий болгоход туслах болно. Мөн илүү өндөр бүтээмжтэй ажлын орчинг бий болгоно.
7. Сургуульд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлогыг хэрэгжүүлэхэд туслах хөтөлбөр хэрэгжүүлэх, бусад эх сурвалжийг бий болгох зорилгоор хандивын сан **цуглуулах**.
8. Оршин суугаа газар дахь хүчирхийллийн хор уршгийн талаар сурагчдад мэдлэг олгоход өөрийн мэргэжлийн ур чадварыг **дайчлах**. Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан, гэмтлийн мэргэжилтэн, прокурор, өмгөөлөгч, шүүгч нараар дамжуулан, хэрэгцээтэй мэдээллийг товч байдлаар хүргэх.
9. Эцэг эх–ажилтнуудыг багштай уулзах тохиромжтой цагийг товлоход **туслах**. Сурагчдад сургалтын болон сургалтын дараахь олон нийтийн арга хэмжээ зохион байгуулагч ажилтнуудад урам хайрлах.
10. Илтгэл тавих, бүжиглэх, зураг зурах, будах, дуулах, хөгжим тоглох, жүжиглэх, зохиол бичих зэрэг бүтээлч урлагийн төрлүүдийг ашиглан, хүчирхийллийн эсрэг тэмцээн **зохион байгуулах**. Тэмцээний бай шагналыг залуучууд өөрсдөө бүтээж бий болгоход туслах. Тухайн арга хэмжээг оршин суугаа газартаа тэмдэглэлт баярын хэмжээнд тооцох.
11. Гэмт хэрэг, эсвэл сэжигтэй үйлдлийн талаар цагдаад яаралтай мэдэгдэх. Мөн эцэг эх, ажилтнуудыг нэгэн адил мэдэгдэхийг дэмжих.



12. Ажилтнууд болон бусад хүмүүстэй шууд хүчирхийлэн харьцах явдлыг гаргахгүй байх бодлогыг **төлөвлөх**.
13. Аливаа гэмт хэргийн талаар сургуулийн захиргаа, эсвэл цагдаад яаралтай **мэдэгдэх**.
14. Сурагч, тэдгээрийн гэр бүлд тулгарсан асуудлыг шийдвэрлэхээр сургуулийн болон оршин суугаа газрын хамтын холбоог бэхжүүлэхэд **туслах**.
15. Сургууль болон оршин суугаа газар дахь хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэхдээ бага ангиас ахлах анги хүртэлх сурагчдыг **татан оролцуулах**. Сурагчдыг өөрөөсөө дүү хүүхдүүд болон үе тэнгийнхэндээ хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тухай хичээл заах, насанд хүрэгчидтэй хамтран, оршин суугаа газар дахь хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэхэд туслах, хүчирхийллийн эсрэг авч буй арга хэмжээг дэмжих.

### ХҮҮХДИЙГ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Хүүхэд бол бидний хойч ирээдүй, үнэлж барамгүй нөөц баялаг гэж тодорхойлдог. Иймээс бид хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийн хохирогч болох явдлаас урьдчилан сэргийлэхийн тулд дараахь эерэг арга хэмжээг авах зайлшгүй шаардлагатай билээ.

#### Эцэг эхчүүд:

- Гэртээ, машиндаа, тоглоомын талбай дээр, хаа ч байсан хүүхдээ хэзээ ч ганцааранг нь бүү орхи.
- ТАНИХГҮЙ ХҮН гэж хэн бэ гэдгийг тайлбарлаж өгөх. Та хүүхэддээ өдөр болгон тааралддаг хэн нэгэн хүн (хөрш, сүү зардаг хүн, орцны жижүүр, таксины жолооч, цахилгаанчин, слесарь, шууданч гэх мэт) бол таньдаг хүн биш шүү гэдгийг ойлгуулах хэрэгтэй.
- Та хүүхэддээ түүний бүтэн овог, нэр, гэрийн бүтэн хаяг, утасны дугаарыг хэлж, цээжлүүлэх. Харилцах утсыг хэрхэн ашигладаг талаар зааж өгөх.
- “Тэгвэл яах вэ” гэсэн тоглоомыг хүүхэдтэйгээ тоглох. Ямарваа нэгэн аюултай, эрсдэлтэй нөхцөлтэй тулгарвал ямар арга хэмжээ

авах талаар товч, тодорхой байдлаар тоглоомын хэлбэрээр ойлгуулах. Жишээлбэл: Сургуулийн талбай дээр “Би танай ээжийн найз байна” гэж хүн дуудвал яах вэ? Би таныг танихгүй гэж хэлээд, багшдаа хэлэх гэх мэт.

- Ямагт хүүхэдтэйгээ ярилцах цаг гаргаж, тэдний зан ааш, хандлагад нөлөөлсөн гэнэтийн мэдэгдэхүйц өөрчлөлтийн талаар ямарваа нэгэн байдлаар тодруулж байх. (Зан аашийн гэнэтийн өөрчлөлт нь бэлгийн дарамт, хүчирхийллээс үүдэлтэй байж магадгүй.)
- Та хүүхдийнхээ сургууль, эсвэл цэцэрлэгт хүүхдийг таниас өөр хэн авах боломжтой талаар мэдэгдэж, хүүхэд ирээгүй тохиолдолд хэнд мэдэгдэж, ямар арга хэмээ авах талаар тохиролцсон байх.
- Хүүхдэд тэдний бие махбодь өөрт нь хамаарах хувийн шинжтэйг ойлгуулж, хэн ч чамд таагүй байдал үүсгэхээр чиний биед хүрэх ёсгүйг хэлж ойлгуулах ёстой. Хэрэв хэн нэгэн чамд (хүүхдэд) эвгүй байдлаар хүрэх юм бол **ҮГҮЙ ГЭЖ ХЭЛЭЭД, ХУРДАН ХОЛДОЖ, ИТГЭДЭГ ХҮНДЭЭ ХЭЛЭХ** ёстойг заах.

## ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН НЭР ТОМЪЁО

## А

**Ажилгүйдэл-безработица-unemployment**

Хөдөлмөрийн насны ажиллах чадвартай, ажиллахад бэлэн байгаа хүн таарч тохирох ажил олох боломжгүй байх.

**Ажилгүйдлээс хамгаалуулах эрх–право на защиту от безработицы-Right protection from unemployment**

Аль болох иж бүрэн, үр бүтээлтэй чөлөөтэй сонгосон ажил эрхлэх боломж болон ажилгүй болсон нөхцөлд зохих тусламж, тэтгэмжээр хангагдах эрхтэй

**Ажил хаях эрх- право на забастовку-right to strike**

Хүн бүр өөрийнхөө эдийн засаг, нийгмийн ашиг сонирхлоо хамгаалан хрэгжүүлэх үүднээс ҮЭ байгуулах, тэдгээрт нэгдэх эрхтэй. Харин ҮЭ нь тухайн улсын хууль тогтоомжийн хүрээнд ажил хаях эрхтэйг “ Эдийн засаг нийгэм, соёлын эрхийн дагуу тухай олон улсын пакт”–ын 8 дугаар зүйлийн d-д тодорхойлон заажээ.

**Ажил хөдөлмөр эрхлэх талаар ялгаварлан гадуурхах үзлийн тухай конвенц-конвенция о дискриминации в области труда и занятий- Convention concering Discrimination in Respect of Employment and Occupation**

ОУХБ-ын ерөнхий бага хурлаар 1958 онд баталсан. Монгол Улс энэ конвенцэд 1969 онд нэгдэж орсон. Энэ конвенцид хөдөлмөр болон ажил эрхлэлтийн салбарт тэгш хандах буюу тэгш боломжтой байх зарчмыг зөрчих буюу устгахад чиглэсэн, хүнийг арьсны өнгө, хүйс, шашин, улс төрийн үзэл бодол, нийгмийн болон гадаадын гаралтай гэсэн шалтгаанаар ялгах, илүүд үзэхийг хориглосон.

**Ажил эрхлэлтийн бодлогын тухай 122-р конвенц- Конвенция о политике в области занятости-Convention concerning Employment Policy**

ОУХБ-ын Ерөнхий бага хурлаар 1964 оны 6-р сард баталсан. Монгол улс энэ конвенцэд 1976 онд нэгдэж орсон. Энэ 122-р конвенцэд бол урьд өмнө нь ажил эрхлэлтийн асуудалтай шууд холбоотой гарсан конвенц, зөвлөмжүүдийг нийтэд нь нэгтгэн авч үзэж тэдгээрийг иж бүрэн, үр бүтээлтэй болон чөлөөтэй сонголт хийх замаар ажил эрхлэх үндсэн дээр Эдийн засгийн хөгжлийн олон улсын программт механизмд хамруулах үүднээс ажил эрхлэлтийн бодлогын талаар улс орнуудад мөрдвөл зохих хэм хэмжээг тогтоосон олон улсын эрх зүйн дээд хүчинтэй актын нэг мөн. Уг конвенцээр тодорхойлсон бодлогод дор дурьдсан зүйлийг хангах явдлыг хамруулжээ. Үүнд:

А. Ажиллахад бэлэн болон ажил эрж байгаа бүх хүнд ажил байлгах

Б. Тийм ажил нь аль болох үр бүтээлтэй байвал зохих

В. Арьс өнгө, яс үндэс, хүйс, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, нийгмийн болон аль улсын иргэний гарал үүслээс үл хамааран ажил эрхлэхэд сонголт хийх эрх чөлөөг олгох, хөдөлмөрчин хүн бүрд өөртөө тохирох ажил хийх бэлтгэлтэй болох, туршлага чадвараа ашиглах өргөн боломжоор хангах зэрэг болно. Энэ конвенц ёсоор ажил эрхлэлтийн бодлого нь эдийн засгийн хөгжлийн үе шат, хүрсэн түвшин болон ажил эрхлэлтийн салбарын зорилт, нийгэм эдийн засгийн бусад зорилт хоорондын харилцан уялдаа холбоог харгалзаж, тэдгээр нь үндэсний нөхцөл практикт нийцэх арга замаар хэрэгжих ёстой.

**Ажилчидын байгууллага- Организация трудящихся- Workers' organization**

Ажилчидыг дэмжих ба тэдгээрийн ашиг сонирхлыг хамгаалах зорилго бүхий ажилчдын аль ч байгууллага хамаарна.

**Ажилчидын төлөөлөгчид- Представители трудящихся- Workers' representatives**

ОУХБ-ын Ерөнхий бага хурлын 1971 оны чуулганаар баталсан “Үйлдвэр дэх ажилчидын төлөөлөгчдийг хамгаалах ба тэдэнд олгох боломжийн тухай” 135 дугаар конвенцийн 3 дугаар зүйлд “ажилчидын төлөөлөгчид” гэдэгт үндэсний хууль, практикаар зөвшөөрсөн бол:

1. ҮЭ-ийн төлөөлөгчид, тухайлбал ҮЭ буюу ҮЭ-ийн гишүүдээс томилогдсон буюу сонгогдсон төлөөлөгчид

2. Сонгогдсон төлөөлөгчид, тухайлбал үндэсний хууль тогтоомж, хамтын гэрээний дагуу тухайн үйлдвэрийн ажилчдын чөлөөтэй сонгосон төлөөлөгчид (хэрэв тэдгээр нь гагцхүү тухайн оронд ҮЭ-ийн эрх хэмжээнд хамаарах үйл ажиллагаа явуулдаггүй тохиолдолд ) хамаарахаар заасан

**Ажлын цагийг зохистойгоор хязгаарлуулах эрх-Право на надлежащее ограничение рабочего времени-Right to reasonable limitation of working hours**

“Аж үйлдвэрт өдрийн ажлын цагийг 8 цагаар, долоо хоногийн ажлын цагийг 48 цагаар хязгаарлах тухай” ОУХБ-ын 1 дүгээр конвенцийн 2 дугаар зүйлд улсын буюу хувийн үйлдвэр эсэхээс хамаарахгүйгээр аж үйлдвэр дахь ажлын өдрийн үргэлжлэл 8 цагаас, долоо хоногийн ажлын цаг 48-с илүүгүй байхаар заасан. ОУХБ-с баталсан анхны конвенцэд ажлын цагийг зохистойгоор хязгаарлах эрхийг баталгаажуулсан нь энэ эрх ямар ач холбогдолтой болохыг тодорхойлж байна. ОУХБ нь үүнээс хойно батлагдсан хэд хэдэн конвенцэд худалдаа, эмнэлэг, зочид буудал, уурхай зэрэг газруудад ажлын цагийг зохистойгоор хязгаарлах тухай заасан бөгөөд 1935 онд “долоо хоногийн ажлын цагийг 40 цаг хүртэл богиносгох тухай” 47 дугаар конвенцийг баталсан болно.

**Аж үйлдвэрт хүүхдийг ажилд авах доод насны хэмжээний тухай 59 дүгээр конвенц-Конвенция о минимальном возрасте приёма детей на работу в промышленности-Convention fixing the Minimum Age for Admission of Children to Industrial Employment**

ОУХБ-ын Ерөнхий бага хурлаас 1937 онд баталсан. Монгол улс энэ конвенцэд 1969 онд нэгдэж орсон. Энэхүү конвенцээр төрийн болон хувийн аж үйлдвэрийн газар эсвэл тэдгээрийн салбаруудад хүүхдийн ажилд авч болох насны нийтлэг хэмжээг арван таваас доошгүй байхаар тогтоосон юм. Гэхдээ конвенцийн 2 дугаар зүйлийн 2 дугаар хэсэг ёсоор шинж чанар, нөхцөл нь хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюултай эсвэл ёс суртахуунд хар нөлөө үзүүлэхээс бусад ажилд эзнийг зөвхөн гэр бүл ажиллаж байгаа тохиолдолд 15 нас хүрээгүй хүүхдийн хөдөлмөрийг ашиглаж болохыг үндэсний аууль тогтоомжоор зөвшөөрч болохоор заасан байдаг. Конвенцийн биелэлтэнд хяналт тавих явдлыг хөнгөвчлөх

зорилгоор үйлдвэрийн газрын удирдагч бүр өөрийнхөө үйлдвэрт ажиллаж буй 18 нас хүрээгүй хүмүүсийн бүртгэлийг төрсөн он, сар, өдрийн тэмдэглэлтэйгээр хөтлөх үүрэг хүлээдэг. Манай орны хувьд гэвэл Монгол улсын Хөдөлмөрийн хууийн 85 дугаар зүйл ёсоор хүүхдийг ажилд авч болох насны нийтлэг хэмжээг 16, харин 15 насанд хүрсэн хүүхдийг эрүүл мэнд, бие бялдарын хэвийн өсөлт, ёс суртахуунд нь муугаар нөлөөлөхгүй ажилд эцэг, эх буюу тэднийг төлөөлөх хүний зөвшөөрөлтэйгээр авч ажиллуулж болохоор заасан болно.

#### **Албадан хөдөлмөр-Принудительный труд-Compulsory Labour**

Албадан хөдөлмөр эрхлэх бүхий л хэлбэрийг устгах асуудлыг ОУХБ-ын Ерөнхий бага хурлаар 1930 онд баталсан. “албадан эсвэл заавал гүйцэтгүүлэх хөдөлмөрийн тухай” 29 дүгээр конвенцээр зохицуулдаг. Уг конвенцэд “албадан эсвэл заавал гүйцэтгүүлэх хөдөлмөр” гэдгийг “...өөрийгөө хүчин үнэлүүлэх саналаа гаргаагүй байхад нь ямар нэгэн шийтгэл оногдуулах, сүрдүүлэх, дор хэн нэгэн итгээд шаардаж хийлгэх аливаа ажил албыг хэлнэ” гэж тодоройлсон байдаг. Гэхдээ албадан заавал гүйцэтгүүлэх хөдөлмөрт хамаарахгүй ажил албыг мөн конвенцээр тодруулжээ.үүнд:

А. Хуулийн шаардлагын дагуу заавал хаавал зохих хэргийн алба

Б. Иргэдийн ердийн иргэний үүргийн хувьд гүйцэтгэвэл зохих аливаа ажил эсвэл алба

В. Зөвхөн төрийн хяналтын дор гүйцэтгэгдэх хувь хүн, компани эсвэл ямар нэг нийгэмлэгийн эрх мэдэлд шилжих явдалгүйгээр шүүхийн байгууллагын шийдвэрийн үндсэн дээр яман нэг этгээдээс хийж гүйцэтгэхийг шаардсан аливаа ажил эсвэл алба

Г. Дайн, гамшиг, эсвэл гамшиг ирэх аюул тулгарсан, тухайлбал, гал түймэр, үер, өлсгөлөн, газар хөдлөлт, халдвар, хортой адгуус амьтан, урагмалын дайралт болон бүх хүн ам эсвэл хүн амын зарим хэсгийн амьдрал, эсвэл амьжиргааны хэвийн нөхцлийг аюулд учруулж байгаа эсвэл аюулд учруулж болзошгүй зэрэг онцгой нөхцөл байдалд гүйцэтгэхийг шаардах аливаа ажил эсвэл алба

Д. Тухайн хамт олны тусын тулд хүн ам нь эсвэл түүний төлөөлөгчид нь тухайн ажлыг хийж гүйцэтгэх нь хэрэгтэй эсэх талаар өөрийн саналаа илэрхийлэх эрхээр хангагдсан нөхцөлд тухайн хамт олны тусын тулд

түүний гишүүдийн иргэний үүргийн хувьд хийж гүйцэтгэгдэх омог аймгийн шинж чанартай жижиг сажиг ажил эдгээр болно.

**Аливаа хязгаарлалтгүйгээр гэрлэх өрх тусгаарлах эрх-Право без всяких ограничений вступить в брак и создать семью- The right to marry without any limitation and to found family**

Арьсны өнгө, яс үндэс, шашин шүтлэгээс үл хамааран гадны ямар нэгэн нөлөө, оролцоогүйгээр сайн дурын үндсэн дээр гэр бүл болох эрх.

**Амрах эрх-Право на отдых- Right to rest**

Ажил хөдөлмөр эрхэлж байгаа хэн боловч ажлын цагийг зохистойгоор хязгаарлахыг шаардах, цалинтай тогтмол амралт эдлэх эрхийг оролцуулан амрах, зав чөлөөтэй байх эрхтэй гэж Хүний эрхийн бүх нийтийн тунхаглалын 24 дүгээр зүйлд заасан байдаг. Түүнчлэн манай улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4-т тунхагийн энэ заалтыг нэгэн адил мөрдөхөөр бататган заажээ.

**Амь нас, эрүүл мэнд, зан суртахуунд аюултай ажил- опасные работы для жизни, здоровья и морали- Employments, which are dangerous to the life, health or morals**

ОУХБ-ын 1937 оны “Аж үйлдвэрт хүүхдийг авах насны доод хэмжээний тухай” 59 дүгээр конвенцийн 5 дугаар зүйлд ажлын шинж чанар буюу түүний гүйцэтгэх нөхцөл нь ажилчдын амь нас, эрүүл мэнд, зан суртахуунд аюултай бол дээрх ажилд авах залуучууд буюу багачуудын доод насны хэмжээг 15-с доошгүй байхаар тогтоосон.

**Амьд байх эрх-Право на жизнь-Right to life**

Энэ эрх нь хуулиар хамгаалагдсан хүний салшгүй эрх мөн. Хэний ч амийг дур мэдэн бүрэлгэж болохгүй. Цаазаар авах ялыг устгаагүй улсад цаазаар авах, таслан шийдвэрлэх тогтоолыг гэмт хэрэг үйлдэх үед дагаж мөрдөж байсан хуулийн дагуу “Иргэний ба төийн эрхийн тухай олон улсын Пакт” болон “Төрлөөр устгах гэмт хэргийг урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг цээрлүүлэх тухай Конвенц”-ийн заалтад харшлахгүй, гагцхүү онц хүнд гэмт хэрэг үйлдсэн нөхцөлд гаргаж болно. Энэхүү шийтгэлийг гагцхүү эрх бүхий шүүхээс гаргасан таслан шийдвэрлэх эцсийн тогтоолыг биелүүлэх замаар хэрэгжүүлж болно. Гэмт

хэрэг үйлдсэн 18 нас хүрээгүй этгээдэд цаазаар авах ял оногдуулахгүй бөгөөд жирэмсэн эмэгтэйчүүдийн хувьд уг ялыг ёсоор гүйцэтгэхгүй.

**Ард түмний өөртөө засан тогтнох эрх-Право народов на самоопределение-Right of peoples to self-determination**

Бүх ард түмэн өөртөө засан тогтнох эрхтэй. Энэхүү эрхийнхээ дагуу тэд улс төрийнхөө статусыг чөлөөтэй тогтоож, эдийн засаг, нийгэм, соёлынхоо хөгжлийг чөлөөтэй хангана. Бүх ард түмэн харилцан ашигтай байх зарчим дээр тулгуурласан олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны болон олон улсын эрх зүйгээр хүлээсэн аливаа үүрэгтээ хохирол учруулахгүйгээр, байгалийн баялаг, нөөцөө өөрийнхөө зорилго чөлөөтэй ашиглана. Аль ч ард түмнийг ямар ч тохиолдолд оршин тогтнох арга хэргэсэлээс нь салгаж үл болно.

**Апартеид гэмт хэрэг- Преступление апартеида-Crime of apartheid**

“Апартеид гэмт хэрэг” гэж нэг арьс үндэстэн нөгөөгөө эрхшээлдээ оруулан ноёрхох, байнга дарлан мөлжих зорилгоор арьс үндсээр ялган тусгаарлах болон гадуурхах бодлого, дадлыг дотроо багтаасан хүний ёсноос гадуурх үйлдлийг хэлнэ. Үүнд:

Дараах үйлдлүүд хамрагдана:

1. Дор дурьдсан аргаар арьс үндэсний нэг буюу хэд хэдэн бүлгийн гишүүн буюу гишүүдийн амьд явах эрх хийгээд халдашгүй дархан байх эрхийг хасах

А. Арьс үндэсний нэг буюу хэд хэдэн бүлгийн гишүүдийг алах

Б. Арьс үндэсний нэг буюу хэд хэдэн бүлгийн гишүүдийн бие махбодид оцтой гэмтэл учруулах буюу ухаан санаанд нь согог суулгах, тэдний эрх чөлөө, нэр төрд халдах буюу хэрцгий, хүний ёсноос гадуур харьцах, нэр төрийг нь гутаан доромжлон харьцах, шийтгэх,

В. Арьс үндэсний нэг буюу хэд хэдэн бүлгийн гишүүдийг дур зоргоор баривчлах, хууль бусаар шоронд хорих.

2. Арьс үндэсний нэг буюу хэд хэдэн бүлгийн гишүүдийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь бүрэлгэн устгахад чиглэсэн амьдрал ахуйн нөхцөлийг санаатайгаар бий болгох

3. Арьс үндэсний нэг буюу хэд хэдэн бүлгийг тухайн орны улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын амьдралд оролцоход саад учруулахад чиглэсэн хууль тогтоох шинжтэй буюу бусд арга хэмжээ авах мөн



хөдөлмөрлөх эрх, хүлээн зөвшөөрсөн үйлдвэрчиний эвлэл байгуулах эрх, сурч боловсрох эрх, эх орноо орхиж явах, буцаж ирэх эрх, иргэний харъяалалтай эрх, чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгон авах эрх, өөрийн үзэл бодолтой байж, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх, тайвнаар жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийг оролцуулан арьс үндэсний нэг буюу хэд хэдэн бүлгийн гишүүдийн хувьд хүний үндсэн эрх, эрх чөлөөг үгүйсгэх замаар тийм нэг буюу хэд хэдэн бүлэгт хөгжиж дэвшихэд нь саад учруулах нөхцөл байдлыг санаатайгаар бий болгох.

4. Арьс үндэсний нэг буюу хэд хэдэн бүлгийн гишүүдэд зориуд тусгаарласан байр, хороолол байгуулах, арьс үндэснүүдийн янз бүрийн бүлэг, гишүүд өөр хоорондоо гэр бүл болохыг хориглох арьс үндэсний нэг буюу бүлэг түүнчлэн тэдний гишүүдийн газрын өмчийг хурааж арьсны өнгөөр хүн амыг салган тусгаарлахад чиглэсэн аливаа арга хэмжээ, түүний дотор хууль тогтоох шинжтэй арга хэмжээ авах

5. Арьс үндэсний нэг буюу хэд хэдэн бүлгийн гишүүдийг мөлжих, тухайлбал тэднээр албадан хөдөлмөр хийлгэх.

6. Апартеидын эсрэг тэмцсэнийх нь төлөө байгууллага, хувь хүний үндсэн эрх, эрх чөлөөг хасах замаар мөрдөн мөшгих. ӨАБНУ-д ноёрхож ирсэн апартеидын бодлого 1994 онд дуусгавар болсон.

#### **Арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах- Расовая дискриминация- Racial discrimination**

“Арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай” олон улсын конвенцийн 1 дүгээр зүйлийн 1 хэсэгт “ Арьс үндсээр ялгаварлан гадуурхах” гэдэг нь улс төр эдийн засаг, нийгэм, соёл болон нийгмийн амьдралын бусад салбарт хүний үндсэн эрх, эрх эрх чөлөөг тэгш үндсэн дээр хүлээн зөвшөөрөх, эдлүүлэх, хэрэгжүүлэхийг үгүйсгэх зорилго бүхий арьс үндэс, арьсны өнгө, ураг төрөл, үндэстний буюу угсаатны гарал үүслийн үндсэн дээр ялгаварлах онцлох, хязгаарлах буюу дээрд үзэх явдлыг хэлнэ гэж тодорхойлсон байна.

#### **Арьс үндсэн дээр ялган тусгаарлах- Расовая сегрегация-Racial segregation**

Арьс үндэсний нэг буюу хэд хэдэн бүлгийн гишүүдэд зориуд тусгаарласан байр, хороолол байгуулах, арьс үндэснүүдийн янз бүрийн

бүлэг, гишүүд өөр хоорндоо гэр бүл болохыг хориглох арьс үндэсний нэг буюу бүлэг түүнчлэн тэдний гишүүдийн газрын өмчийг хурааж арьсны өнгөөр хүн амыг салган тусгаарлахад чиглэсэн аливаа арга хэмжээ, түүний дотор хууль тогтоох шинжтэй арга хэмжээг хэлнэ. Хамгаалал шаардаж буй үндэсний буюу угсаатны зарим бүлэг, хувь хүмүүст хүний эрх, эрх чөлөө тэгш эдлэж, хэрэгжүүлэх явдлыг хангах шаардлагын үүднээс гацхүү тэдгээр бүлэг хүмүүсийг хөгжүүлэх зорилгоор л авч хэрэгжүүлж буй арга хэмжээг арьс үндсээр ялгаварлан тусгаарласан гэж үзэхгүй.

**Ж.Амарсанаа, Д.Базарсад, С.Гэрэлмаа, Б.Отгонбаяр,  
П.Цагаан, В.Лхагвасүрэн “Хүний эрхийн нэр томъёоны товч  
тайлбар толь” номоос...**